

Редакцийн зурvas

ТОМУУГИЙН ИРЭХ УЛИРАЛД ТУЛХТАЙ БЭЛТГЭ



Томуугийн цартахалд бэлтгэх ДЭМБ-ын олон шатат бэлтгэл арга хэмжээ, зөвлөмжийн хүчинд сүүлийн 5-6 жилд манай улс дахь ТТӨний лабораторид суурьласан тандалтанд ихээхэн ахиц гарч, тандалтын дүн бодит хугацаанд он-лайн нийтийн хүртээл болдог болсон ололтоо бид улам батжуулах шаардлагатай

байна. Ер нь халдварт өвчний дэгдээт, цартахалтай тулахад амжилтын үндэс нь олон жилийн байнгын тандалт, түүнэд тулгуурласан хяналтын шатчилсан арга хэмжээний цогц, эрүүл мэндийн албаныхан, ялангуяа халдварт өвчинтэй тэмцэх албаныхны бэлэн байдал, мэдлэг чадвар нэн чухал гэдэг нь 2009-2011 оны томуугийн A(H1N1) цартахлын үед тодорхой харагдсан билээ.

“Тайван цагт хөлс их гаргавал, дайнд цус бага гарна” гэдэг цэрэг-дайны бодлогын уриа халдварт өвчинтэй тэмцэхэд ч суурь болох ёстай юм. ТТӨ, түүний хүндрэлүүд манай хүн амын өвчлөл, эндэгдлийн ноцтой шалтгаан байсаар байгаа боловч, эрүүл мэндийн албаны бүх шатныхны онцгой анхаарлын бүсийн гадна байсаар л байна. Ялангуяа цартахал явваад өнгөрчихсөн гэсэн ойлголт шийдвэр гаргагсадын болон эрүүл мэндийн үйлчилгээний олон

шатныхны анхаарлыг сүлрүүлж болзошгүй эгзэгтэй цаг үе бидэнд тулж ирлээ. Тиймээс энэ жилийн томуугийн улиралд бэлтгэх ажил эрүүл мэндийн албаныхны үйл ажиллагаанд илүүтэй чиглэх хэрэгтэй гэж бид үзсэн учраас “Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн сургалт семинар” зохион байгуулахаар шийдсэн юм. Манай сэтгүүлийн энэ дугаарт ч энэ асуудалтай холбогдсон материалыг тулхүү оруулж байгаа болно.

Одоо өвлийн улирал нь таарч байгаа Дэлхийн бөмбөрцгийн өмнөд хагасын орнуудын ДЭМБ-д өгч буй мэдээнээс [1] үзэхүл томуугийн A(H1), A(H3), В вирус зэрэгцэн орчилд орж байгаа тул манай улсад ирэх томуугийн улиралд ямар вирус зонхилохыг урьдчилан таамаглахад бэрхтэй болгож байна. Манай өмнөд хөрш БНХАУ-д томуугийн В вирус давамгайлан орчих хандлагатай болж байгаа нь томуугийн тархалтын нэгэн бүсэд багтдаг манай улсад томуугийн ирэх улиралд зонхилох хандлага болж ч магадгүй. Томуугийн В вирус тархалтын эрчээрээ А вирусээс сувалтар боловч эмнэлзүйн хувьд илүү хүндрэлтэй, удаан үргэлжлэх хандлагатай байдаг өмнөх жилүүдийн хандлагыг бид эргэн харж бэлтгэлээ базаах нь чухал болж байна. Мөн улирал солигдох заагт иж томуу, респиратор-синцитиаль болон метапневмонийн вирус, ялангуяа балчир насныхан, хөгшдөл илүү халгаатай өвчлөл үүсэх хандлагатай байгааг судлан тогтоосон дүнг [2] ч бид харгалзан үзэх хэрэгтэй болно.

Академич П.Нямдараа,
Сэтгүүлийн ерөнхий эрхлэгч.
“Томуугийн тандалтын сүлжээг бэхжүүлэн хөгжүүлэх”
Монгол-АНУ-ын хамтарсан төслийн удирдлагч

Номзүй:
1.Томуу Дэлхий дахинд-3 (2011 оны 32 дугаар 7 хоног):
http://www.flu.mn/mgl/index.php?option=com_content&task=view&id=760&Itemid=49;

2.Цацрал, С., Майцэцэг, Ч., Дармаа, Б., Нямдараа.П.,
(2011): Монгол улсад 2008-2009 онд орчилд байсан амьсгалын замын өвчин үүсгэгч вирусүүдийн хөдлөлзүйг судласан дүн, Халдварт өвчин судалын Монголын сэтгүүл, № 1(38): 8-11;

Шинжилгээ судалгаа

МОНГОЛ УЛСАД 2010-2011 ОНД БҮРТГЭГДСЭН
ТОМУУГИЙН ӨВЧЛӨЛИЙН БАЙДАЛ, ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ДҮН

Б.Дармаа¹, А.Бурмаа¹, Ц.Наранзул¹, Н.Баясгалан¹,
Д.Энхсайхан¹, Ч.Майшээг¹, Г.Нямаа¹, Б.Цэрэндуулам¹,
Л.Энхбаатар¹, Б.Ганцоож¹, Ч.Уртнаасан¹, П.Нямдаваа^{1,2}

¹Халдварт өвчин судлалын үндэсний төв,

²Монголын анагаах ухааны академи

Томуугийн A(H1N1) 2009 вирусээр сэдээгдсэн цартахал манай улсад харьцангуй хожуу буюу 2009 оны 10 дугаар сараас тархаж, богино хугацаанд оргилдоо хүрээд 2010 оны 2 дугаар сараас эргэлтээс бүрэн гарч томуугийн В вирусээр солигдсон тухай ажиглалтаа бид өмнө нь нийтлүүлсэн билээ [1]. Бид энэ өгүүлэлдээ Монгол улсын хэмжээнд 2010/2011 оны хүйтний улиралд томуугийн вирусийн тархалт, өвчлөлийн байдлыг тандан судалсан дүнг нэгтгэн мэдээлж байна.

Материал:

Эпидемиологийн тандалтын материал: ХӨСҮТ, ТҮТ-ийн томуугийн харуулдан тандалтын нэгжүүд (21 аймгийн Эрүүл мэндийн газар, Улаанбаатар хотын 9 дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, дүүргийн нэгдсэн эмнэлэг, клиникийн I, III эмнэлэг, ЭНЭШТ, 126 өрхийн эмнэлэг)-эд 2010/2011 оны томуугийн улиралд бүртгэгдсэн ТТӨ-ий тохиолдлын тоо, эпидемиологийн мэдээлэл;

Вирус судалын шинжлэгдэхүүн: 2010 оны 10 дугаар сараас 2011 оны 7 дугаар сарыг дуусталх хугацаанд Томуугийн харуулдан тандалтын нэгж(TXTN)-үүдэд томуу, томуу төст өвчин (ТТӨ)-тэй гэж оношлогдсон 3972 хүнээс цуглуулсан хамар залгиурын арчдас сорьц;

Аргазүй:

ТТӨ-ий өвчлөлийн толерант босго-ыг 2000/01 оны томуугийн улирлаас хойш улс, Улаанбаатар хотын хэмжээнд бүртгэгдсэн ТТӨ-ий мэдээнд тулгуурлан И.Г.Мариничийн хувилбар аргаар бидний өмнө нь бичсэн [2]-ээр тооцоолов.

Томуугийн вирус илрүүлэх, дүйн тодорхойлох шинжилгээ-г хамар-залгиурын арчдаснаас томуугийн вирусийн PHX-г ялгаж, бодит хугацааны (бх) урвуутранскриптазын полимеразын гинжин урвал (бх-ҮТ-ПГҮ)-аар ДЭМБ-ын Томуугийн лавлагаа төвүүдээс хангасан праймеруудыг ашиглан бидний өмнө нь бичиглэсэн арга [3]-аар хийв.

Томуугийн вирус өсгөвөрлөх шинжилгээ-г бх-ҮТ-ПГҮ-аар томуугийн вирус эерэг гарсан сорьцыг

MDCK эсийн өсгөвөрт бидний өмнө нь бичиглэсэн арга [3]-аар халдвартуулж гүйцэтгэв.

Амьсгалын замын бусад вирус илрүүлэх шинжилгээ-г долоо хоног тутамд 16 сорьцыг санамсаргүй түүвэрээр сонгон нийт 661 сорьцыг R-Mix(DHI, Inc., USA) хибрид эсийн өсгөвөрт халдааж, вирусийн эсрэгтөрөгчийг иммун-флюоресцент микроскопын шууд аргаар бидний өмнө нь бичиглэсэн [4] дагуу болон, сорьцноос PHX-г ялгаж, мультиплекс бх-ҮТ-ПГҮ-аар Люксембургийн FastTrack Diagnostics(FTD) компанийн цомгоор бидний өмнө нь бичиглэсэн [5] аргаар;

Томуугийн вирусийн нейраминидазын саатуулуурт тэсвэржилтийн шинжилгээ-г эсийн өсгөвөрт ялгасан томуугийн A(H1N1) 2009 цартахлын вирусийн 28, A(H3N2) вирусийн 2 омогт NA-Star® (ABI, USA) цомог ашиглан хемолюминесценцэт энзим саармагжуулах шинжилгээний бидний өмнө нь бичиглэсэн [6] аргаар, томуугийн вирусийн NA генийн оселтамиивирт тэсвэржсэн H274Y мутац илрүүлэх шинжилгээг нэг шатлалт бх-ҮТ-ПГҮ-ын аргаар [7],


Томуугийн вирусийн генуудийн нуклеотидын дараалал-ыг ABI Big Dye terminator v.3.1. Cycle Sequencing ашиглан ABI 3130 xl Genetic Analyser-аар бидний өмнө нь бичиглэсэн [8] аргаар тус тус хийлээ.

Үр дүн, хэлцэмж:

2010 оны 10 дугаар сарын 1-нээс 2011 оны 7 дугаар сарын 31-нийг дуусталх хугацаанд улсын хэмжээнд ТТӨ-ий өвчлөл амбулаториор үлчлүүлэгсдийн 5.8%, 10,000 хүн амд дунджаар 1232.0 тохиолдол бүртгэгдсэн нь 2009/10 оны мөн үетэй харьцуулахад 3.0%-иар, 10,000 хүн амд 814.5 тохиолдоор бага байна. Улсын хэмжээнд ТТӨ-ий өвчлөл эпидемиологийн 40 дүгээр долоо хоног буюу 10 дугаар сараас эхэн толерант дээд хязгаараас дунджаар 10,000 хүн амд 5,7 тохиолдоор илүү байж, 2011 оны 1 дүгээр долоо хоногт 10,000 хүн амд 55.8 тохиолдол бүртгэгдэж, оргил үедээ хүрсэн нь 2009/10 оны томуугийн цартахал, томуугийн В вирусийн шалтгаантай дэгдэлтийн үетэй харьцуулахад даруй

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН МОНГОЛЫН СЭТГҮҮЛ №3(40) 2011 ОН

2 дахин бага үзүүлэлттэй байна. 2010 оны 45 дугаар 7 долоо хоног буюу 11 дүгээр сарын эхний 7 хоногоос эхлэн харуулдан тандалтын цэгүүдээс шуглуулсан сорьцонд томуугийн A(H3N2) вирус илэрч, томуугийн дэгдэлтийн шалтгаан болж, 50 дахь долоо хоногт вирус илрэлт оргилдоо хүрч, аажмаар буурсан боловч 2011 оны 1 дүгээр долоо хоногоос томуугийн A(H1N1) 2009 цартахлын вирус зэрэгцэн эргэлтэнд орсон байна (Зураг 1).



**Зураг 1. Улсын хэмжээнд 2010/11 оны томуугийн
үлиралд бүртгэгдсэн
ТТӨ-ий өвчлөл, илрүүлсэн вирүсийн бүрдлийн
хөдлөлзүй (долоо хоногоор)**

Дээрхи хугацаанд эмнэлэгт сууриссан харуулдан тандалтын 38 нэгжид уушгинь үрэвслийн 19,096 тохиолдол, 45 (0.2%) нас баралт бүртгэгдсэн байна. Нас баралтын 39(86.7%) нь 4 хүртэлх насыханда

бүртгэгдэж, бага насны хүүхдийн дунд уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт зонхилох хувийг эзэлдэг зүйтогтол хэвээр ажиглагдаж байна. Дэлхийн нийт орнуудад 2010/2011 онд ТТӨ-ий өвчлөлийн үзүүлэлт 2009/2010 онтой харьцуулахад бага, ушигны хатгалгааны улмаас эмнэлэгт хэвтэл, нас баралтын тоо цөөн байна[9].

Нийт 3972 сорыц шинжилснээс 460(11.5%)-д нь томуугийн вирус илэрснийг дэд хэвшинжээр дүйн тодорхойлоход 349(75.9%) нь A(H3N2), 103(22.4%) нь A(H1N1)pdm, 8(1.7%) нь В хэвшинжийн вирус байлаа.

Бусад оронд хийсэн судалгаагаар ТТӨ-ий шалтгааны 10%–19% томуу байсан [10;11] нь манай судалгааны дүнтэй ойролцоо байгаа юм.

Томуугийн вирусийн хэвшинжүүдийн ирэлтийг сараар авч үзэхэд (Хүснэгт 1) 2010 оны 10 сараас 12 дугаар сарыг дуустал A(H3N2) ба B, 2011 оны 1 дүгээр сар буюу ТТӨ-ий оргил үед A(H3N2)(61%); A(H1N1) pdm (38.2%); B(0.8%) хэвшинжийн вирусүүд зэрэгцэн өвчлөл үүсгэж харин хүйтний улирлын төгсгөл 2-3 дугаар сард A(H1N1) pdm; В вирусүүд эргэлтэнд байсан байна (Хүснэгт 1). Дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст байрладаг Азийн орнуудад 2010 оны 10 дугаар сарын сүүлч 11 дүгээр сарын эхээр, Европ, Хойд Америкийн орнуудад үүнээс нэг сарын дараа томуугийн дэгдэлт эхэлж 2011 оны 4 дүгээр сарын сүүлч хүртэл үргэлжилсэн байна.

Хүснэгт 1

2010/2011 оны томуугийн үлиралд хийсэн томуугийн вирус илрүүлэх шинжилгээний дүн (сараар)

Сарууд	Цүүг - луулсан сорьц	6х УТ-НГҮ									
		ШИНЖИЛСЭН		ЭЗЕРЭГ		ҮЧҮҮС					
		ТОО	%	ТОО	%	A(H3N2)		A(H1N1) pdm		B	
2010.X	309	309	100	2	0.64	1	50	0	0	1	50
2010.XI	426	426	100	33	7.7	33	100	0	0	0	0
2010.XII	702	702	100	242	34.4	241	99.5	0	0	1	0.5
2011.I	748	748	100	118	15.7	72	61	45	38,2	1	0,8
2011.II	540	540	100	43	7.9	2	4.6	41	95.4	0	0
2011.III	622	622	100	21	3.3	0	0	16	76,2	5	23.8
2011.IV	357	357	100	0	0	0	0	0	0	0	0
2011.V	156	156	100	1	0.64	0	0	1	100	0	0
2011.VI	73	73	100	0	0	0	0	0	0	0	0
2011.VII	39	39	100	0	0	0	0	0	0	0	0
Нийт	3972	3972	100	460	11.5	349	75.9	103	22.4	8	1.7

Томуугийн тархалт Хятадын хойд бүс нутаг, Өмнөд Солонгос, Монгол улсад A(H3N2) вирусээр үүсгэгдэн эхэлж, 2011 оны 1 дүгээр сард A(H1N1)pdm вирус зонхицсон илэрсэн, харин Япон улсад A(H3N2) ба A(H1N1)pdm вирус зэрэгцэн тархаж, 1 дүгээр сарын сүүлчээс A(H1N1)pdm вирус давамгайлан илэрчээ [9]. Азийн орнуудад 2010/2011 оны томуугийн улиралд томуугийн В вирусийн илрэлтийн хувь бага, харин Хойд Америкд A(H3N2), В, Европын орнуудад A(H1N1) 2009, В хэвшинжийн вирусүүд холимог эргэлтэнд байж, Англид A(H1N1) 2009pdm вирусийн тархалт эрчимтэй илэрч, халдварын хүнд хэлбэрүүд бүртгэгдсэнийг ДЭМБ мэдээлсэн байна.

Амбулаториос цуглуулсан 2310 сорьшын

305(13.2%)-д, стационараас цуглуулсан 1662 сорьшын 155(9.3%)-д нь томуугийн вирус илэрч, стационараас вирус илрэлт бага байгаа нь ТТӨ-ий хожуу буюу хүндрэлийн үедээ эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх тохиолдол илүү байгаагас шалтгаалсан байх талтай (Хүснэгт 2).

Нэгдсэн эмнэлгийн сорьшны 105(67.7%)-д нь A(H3N2), 44(28.4%)-д нь A(H1N1)pdm илэрсэн нь улирлын томуугийн A(H3N2) хэвшинжийн вирус нь илүү хүндрэл дагуулсан байх магадлалтай байна. Томуугийн A(H3N2) вирус нь улирлын A(H1N1), В вирусийн халдвартай харьцуулахад эмнэлзүйн хүнд хэлбэрийн өвчлөл үүсгэж эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх магадлалыг илүү үүсгэдэг болохыг судлаачид бичсэн байна[10;11].

Хүснэгт 2

Амбулатори ба нэгдсэн эмнэлгээс ирсэн сорьцонд томуугийн вирус илрэлт

Сорьц цуглуулсан нэгжийн байршил	Нийт ирсэн сорьц	Эерэг	Үүнээс		
			A(H1N1)pdm	A(H3N2)	B
Амбулатори	2310	305(13.2%)	59(19.3%)	244(80%)	2(0.6%)
Нэгдсэн эмнэлэг	1662	155(9.3%)	44(28.4%)	105(67.7%)	6(3.8%)

Эргэлтээс бүрэн гарсанда тооцож байсан томуугийн A(H1N1) 2009 цартахлын вирус 2011 оны эхнээс дахин ялгарч эхлэсэн явдал уг омог дахин эрчимтэй тархалт үүсгэж чадах эсэхийг судлан тогтоох шаардлага бий болгосон юм. Тиймээс бид дахин ялгарч эхлэсэн цартахлын вирусийн төлөөлөл болох A/Улаанбаатар/190/2011 омгийн бүх 8 сегментийн нуклеотидын дарааллыг тогтоож, GenBank-д байршуулан [GenBank accession numbers: CY080571, CY080572, CY081057, CY080420, CY080573, CY080574, CY080592, CY080593] цартахлын вирусийн GenBank-д байрлуулсаномгуудын генийн нуклеотидын дараалалтай жишиж үзэхэд A/Улаанбаатар/190/2011 омгийн гемагглютининий ген нь цартахлын эх омог болох A/California/07/2009 омгийнхоос 2 байрлалд мутац [S188T; X208Q] үүсгэсэн нь 2010 оны 10 дугаар сараас АНҮ, Европийн орнуудад тархаж эхлэсэн цартахлын вирусийн шинэ субклейд болох A/Karaj/5327/2010(H1N1) омгийнхтой ижил байснаас

бусад өөрчлөлт илрээгүй юм. Европийн зарим орон, ялангуяа ОХҮ-ын зарим мужуудад эрчтэй тархаж байсан энэ омог манай оронд ноцтой дэгдэлт үүсгээгүй нь манай улсад цартахлын вирусийн омгоор боловсруулсан вакциныг харьцангуй өргөн хэрэглэж чадсантай холбоотой байж болох юм гэж бид үзэж байна.

Эсийн өсгөвөрт ялгасан томуугийн вирусийн төлөөлөлийг Япон улсын Халдварт Өвчин Судалын Үндэсний Хүрээлэн дэхь ДЭМБ-ын Томуугийн лавлагaa төвд илгээж эсрэгтөрөгчийн хэвшинжийг тодорхойлсон дүнгээр (Хүснэгт 3; 4) манай улсад ялгасан A(H3N2) омгууд нь 2010/2011; 2011/2012 оны томуугийн улиралд дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын орнуудад хэрэглэхээр зөвлөмж болгосон A/Perth/16/2009(H3N2) омгийтой, A(H1N1) 2009 pdm омгууд нь мөн вакцины омгоор зөвлөмж болгосон 2009 оны цартахлын эх омог A/California/07/2009 (H1N1)pdm вирустэй төстэй дүйгэсэн байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН МОНГОЛЫН СЭТГҮҮЛ №4(41) 2011 ОН

Хүснэгт 3

Монголд ялгасан зарим A(H3N2) омгийн эсрэг төрөгчийн шинжийн цус наалдахыг saatuuлах урвалаар тодорхойлсон дүн

№	Омгууд	С о р ь ц цуглуулсан он, сар, өдөр	Лавлагаа дархан ийлдсүүд		
			A/Uruguay/716/07 (H3N2)	A/Perth/16/09 (H3N2)	A/Niigata/403/09 (H3N2)
	Лавлагаа эсрэг төрөгчид				
1	A/Uruguay/716/2007	2007/06/21	<u>1280</u>	40	40
2	A/Perth/16/2009		10	<u>320</u>	320
3	A/NIIGATA/403/2009	2009/03/12	40	320	<u>320</u>
	Монгол омгууд				
1	A/Dornogobi/3875/2010	2010/12/06	80	640	40
2	A/Uvurkhagai/3970/2010	2010/12/09	40	640	320
3	A/Ulaanbaatar/3920/2010	2010/12/10	40	320	<u>320</u>
4	A/Ulaanbaatar/3887/2010	2010/12/09	80	640	640
5	A/Dornogobi/4064/2010	2010/12/15	40	320	320
6	A/Dornogobi/4067/2010	2010/12/13	40	320	320
7	A/Ulaanbaatar/3893/2010	2010/12/08	40	160	320
8	A/Ulaanbaatar/3805/2010	2010/12/02	20	160	160

Хүснэгт 4

Монголд ялгасан зарим A(H1N1)pdm 2009 омгийн эсрэг төрөгчийн шинжийн цус наалдахыг saatuuлах урвалаар тодорхойлсон дүн

№	Омгууд	С о р ь ц цуглуулсан огноо	Лавлагаа дархан ийлдсүүд		
			Brisbane/59/2007 (H1N1)	California/07/2009 (H1N1)pdm	Narita/1/2009 (H1N1)pdm
	Лавлагаа эсрэг төрөгч				
1	A/Brisbane/59/2007	7/1/2007	<u>640</u>	<10	<10
2	A/California/07/2009	4/9/2009	<10	<u>1280</u>	2560
3	A/Narita/1/2009	5/8/2009	<10	2560	<u>5120</u>
	Монгол омгууд				
1	A/Ulaanbaatar/322/2011(H1N1)v	2011/1/14	<10	2560	5120
2	A/Ulaanbaatar/909/2011(H1N1)v	2011/2/09	<10	2560	5120
3	A/Orkhon/1007/2011(H1N1)v	2011/2/11	<10	2560	1280
4	A/Orkhon/1019/2011(H1N1)v	2011/2/16	<10	1280	1280
5	A/Ulaanbaatar/1118/2011(H1N1) v	2011/2/14	<10	1280	1280
6	A/Ulaanbaatar/1132/2011(H1N1) v	2011/2/15	<10	640	2560

2010/2011 онд эсийн өсгөвөрт ялгасан А хэвшинжийн вирусийн 30 омгийг төлөөлөл болгож оселтамивирт мэдрэг байдлын тоон үзүүлэлт буюу омгуудын нейраминилаз(NA)ийн идэвхийг 50% saatuuлах эмийн төвшрүүлэгийг лавлагaa мэдрэг хяналт омгуудын тоон үзүүлэлттэй харьцуулж дүгнэхэд манай омгууд бүгд оселтамивирт мэдрэг тодорхойлогдлоо.

Бх-УТ-ПГУ болон секвенсинг шинжилгээгэр NA генийн оселтамивирт тэсвэржсэн H274Y мутац илэрсэнгүй. Дэлхий нийтийн томуугийн тандалтын сүлжээ лабораториудад вирусийн эсрэг эмийн бодист мэдрэг чанарыг шинжилсэн A(H1N1)pdm вирусийн 9,300 омогийн 98% нь оселтамивирт мэдрэг тодорхойлогдсон бөгөөд H275Y муташи бүхий тэсвэржсэн омгууд Европ тивийн орнуудад илүү тархалттай байжээ. A(H3N2); В вирусийн хувьд оселтамивирт илүү мэдрэг, харин 2011 оны 4 дүгээр сард АНУ-д оселтамивирт тэсвэржсэн A(H3N2) вирусийн нэг омог илэрснийг ДЭМБ мэдээлсэн байна[9].

Ном зүй

1. Бурмаа, А., Нямдаваа, П., Дармаа, Б. ба бусад (2010): Монгол улсад бүртгэгдсэн томуугийн A(H1N1) 2009 цартахлын эпидемиологийн төрх, Халдварт өвчин судалын Монголын сэтгүүл, 5(30):23-24;
2. Бурмаа, А., Дармаа, Б., Нямдаваа, П. (2009): Монгол улсад томуугийн сүүлийн гурван улиралд бүртгэгдсэн томуу, томуу-төст өвчний эпидемиологи, үүсгэгчийн бүрдэл, Халдварт өвчин судалын Монголын сэтгүүл, 5(30):23-24;
3. Darmaa, B., Tsatsral, S., Naranzul, T. et al. (2009): Influenza virus strains circulating in Mongolia in 2003-2007, Mongolian Journal of Health Sciences, 6(1):8-19;

4. Цацрал, С. (2008): Хибрид эсийн өсгөвөр болон полимеразын гинжин урвалын аргыг ашиглан амьсгалын замын зарим вирусийг эмнэлзүйн сорьцонд илрүүлэх харьцуулсан судалгаа, Магистрын зэрэг горилсон нэгэн сээдэвт бүтээл, Улаанбаатар, 60 х.;

5. Цацрал, С., Майшэцэг, Ч., Дармаа, Б., Нямдаваа, П. (2011): Монгол улсад 2008-2009 онд орчилд байсан амьсгалын замын өвчин үүсгэгч вирусүүдийн хөдлөлзүйг судласан дүн, Халдварт өвчин судалын Монголын сэтгүүл, 1(38):8-11;

6. Дармаа, Б., Губарева, А.В., Наранзул, Ц. ба бусад (2008): Монгол ялгасан томуугийн вирусийн омгуудын зарим эмийн бодист дасал үүсгэсэн байдлыг судалсан дүн, Эрүүл Мэндийн Шинжлэх Ухаан сэтгүүл, №9: 49-53;

7. Nakauchi, M., Yasui, Y., Miyoshi, T., et al. (2010): One-step reverse transcription-PCR assays for detecting and subtyping pandemic influenza A/H1N1 2009, seasonal influenza A/H1N1, and seasonal influenza A/H3N2 viruses, Journal of Virological Methods, V-11373;

8. Нямдаваа, П., Энхсайхан, Д., Ч.Майшэцэг ба бусад (2010): Монгол улсад ялгасан томуугийн A(H1N1) 2009 цартахлын вирусийн молекул генетикийн төрх, Халдварт өвчин судалын Монголын сэтгүүл, 5(36):7-12;

9. WHO (2011): Summary review of the 2010-2011 northern hemisphere winter influenza season, Weekly Epidemiological Record (WER), Vol. 86 (pp 221-232): Available from: http://www.who.int/influenza/surveillance_monitoring/2010_2011_GIP_surveillance_seasonal_review/en/index.html; vol. 86 (pp 221-232).

10. Sek Mardy , Sovann Ly , Seng Heng, et al.(2009): Influenza activity in Cambodia during 2006–2008, BMC Infectious Diseases, 9:168. doi:10.1186/1471-2334-9-168. pmid:19828051

11. Hien T, Nguyen Nila J, Dharanb, Mai T, et al.(2009): Vietnam National Influenza Surveillance and Evaluation Team. National influenza surveillance in Vietnam, 2006–2007. Vaccine, 28:398–402.

Үншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, анагаах ухааны доктор Р.Түүл



Албаны бичиг, баримт

**ДЭМБ-ЫН НОМХОН ДАЛАЙН БАРУУН БОЛОН ЗҮҮН-ӨМНӨД АЗИЙН БҮСЭЭС
ТОМУУГИЙН ҮНДЭСНИЙ ТАНДАЛТЫГ ЦААШИД БЭХЖҮҮЛЭХ ТУХАЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ: ТОМУУГИЙН ХЯНАЛТЫН
БОДЛОГО БА БҮСИЙН ТАНДАЛТ**

2011 оны 6 дугаар сарын 7-10-ны өдрүүдээд Лаос улсын Вьентьян хотод зохион
байгуулсан Номхон Далайн Баруун болон Зүүн Өмнөд Азийн бүсийн Томуугийн
Үндэсний Төвүүдийн уулзалтаас гарсан саналыг тусган
2011 оны 6 дугаар сарын 14-ний өдөр шинэчлэн найруулав.

Алсын хараа: Номхон далайн Баруун болон Зүүн Өмнөд Азийн бүсийн бүх гишүүн улс орнуудад томуугийн шалтгаантай өвчлөл, нас баралтыг бууруулах.

Зорилт: Томуугийнурьдчилансэргийлэлт, хяналтын бодлогыг боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд гишүүн улс орнууд лабораторийн, тархвар судаллын болон эмнэлзүйн мэдээ, мэдээллийг ашиглах.

Үдиртгал Ази Номхон Далайн бүс нь эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн хөгжилд асар их хор хохирол учруулдаг шинэ халдварт өвчний эхлэн тархах голомт байсаар ирсэн. Шинээр тархаж буй халдварт өвчний талаархи Ази Номхон Далайн Стратеги (ШТХӨАНДС) 2005 онд гарсан нь бүсийн улс орнуудын томуугийн цартахал, шинэ халдварт өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах хүчин чадлыг нэмэгдүүлэх стратегийн бичиг баримт болсон.

Шинэчлэн найруулсан Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОҮЭМД) 2005 нь 2007оны 6 дугаар сард хүчин төгөлдөр болж, ДЭМБ эрүүл мэндийг хамгаалах глобаль тогтолцоог бий болгохын тулд улс орнуудыг нийгмийн эрүүл мэндийн ноцтой үйл явдлыг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах хүчин чадлыг бэхжүүлэхийг уриалсан билээ.

ШТХӨАНДС нь бүх улс орнуудыг ОҮЭМД (2005)-ийн хүрээнд тавигдаж буй нөөц бүрдүүлэх шаардлагыг биенгүүлэхэд гол чиглүүлэгч нь болж байна. Гишүүн улс орнуудаас гаргасан зөвлөмж, ШТХӨАНДС-ийг хэрэгжүүлэхэд гарч буй сургамж, түүнчлэн 2009 оны томуугийн цартахлын үеийн хариу арга хэмжээний туршлага, шувууны томуугийн A(H5N1) вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийг илрүүлэх, хянах, томуугийн шинэ вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийг илрүүлэх зэрэг туршлагуудаас суралсан ШТХӨАНДС (2010)-ийг шинэчлэн боловсруулсан. ШТХӨАНДС (2010) нь ОҮЭМД (2005)-ийг хэрэгжүүлэх, мөн бүсийн нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг бий

болгоход дэмжлэг үзүүлнэ. Энэ 2 бүсийн стратеги нь 2010 оны 10 дугаар сард болсон Бүсийн Зөвлөлдөх Уулзалтын үед Гишүүн улс орнуудаар зөвшөөрөгдсөн юм.

Томуугийн үндэсний тандалтын тогтолцоо нь халдварт өвчинтэй тэмцэх үндэсний чадавхи, нөөцийг бүрдүүлэх чухал хэсэг бөгөөд улирлын болон томуугийн цартахлын урьдчилан сэргийлэлт, хяналтанд гол үүрэг гүйцэтгэнэ. Томуугийн үндэсний тандалтын тогтолцоо нь улирлын болон томуугийн цартахлын тандалт явуулах; өндөр хоруу чанартай шувууны томуу, гахайн вирус зэрэг томуугийн цартахлыг үүсгэж болзошгүй томуугийн шинэ вирусээр үүсгэгдсэн дэгдэлтийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах; тандалтын болон тусгай судалгааны мэдээнд тулгуурлан томуугийн өвчлөлийн дарамтыг тодорхойлох; томуугийн вакцин нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх зэрэг томуугийн хяналтын бодлогыг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ

Өнгөрсөн 5 жилд ОҮЭМД-ийн дагуу шаардлагатай чадавхийг бий болгож, бэхжүүлэхэд ихээхэн дэвшил гарсан бөгөөд томуугийн тандалт тэдгээр чадавхийг бүрдүүлэхэд гол чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэсэн. Номхон Далайн Баруун ба Зүүн Өмнөд Азийн бүсийн хэд хэдэн улс оронд томуугийн тандалтын тогтолцоо бий болж одоогийн байдлаар Номхон Далайн Баруун Бүсийн 15 оронд 21, Зүүн Өмнөд Азийн Бүсийн 8 оронд 10 Томуугийн Үндэсний Төв (TYT), Номхон Далайн Баруун Бүсийн Австрали, БНХАУ, Япон улсад ДЭМБ-ын Хамтын ажиллагааны 3 лавлагаа төв тус тус үйл ажиллагаа явуулж байна. Энэ 2 бүсийн томуугийн тандалт, цартахлын бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний ололт улирлын томуугийн вирусийг хянах нөхцлийг бүрдүүлж, томуугийн A(H5N1) вирус гэх мэт цартахал үүсгэж болзошгүй томуугийн вирусийг илрүүлэх, цартахлын бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээ авахад оршиж байна.

**Томуугийн үндэсний тандалт, хяналтыг бэхжүүлэх:
Томуугийн хяналтын бодлого ба бүсийн тандалт**

Зорилго: Томуугийн урьдчилан сэргийлэлт ба хяналтын бодлогыг тодорхойлох томуугийн үндэсний тандалтын тогтолцоог бэхжүүлэх.

Гишүүн үлс орнуудажлын төлөвлөгөөг боловсруулж ажлын 3 талбарт гарах ололт амжилтыг хянах:

1. Лабораторийн аюулгүй ажиллагаа, чанарын хяналтыг хангасан TYT-д вирусологийн шинжилгээ хийх хүчин чадлыг нэмэгдүүлэх.

- Биоаюулгүй ажиллагааны төлөвлөгөө, гарын авлага, шаардлагатай дэд бүтэц, тоног төхөөрөмж, хангамж, удирдлагын оролцоо зэргийг хамарсан чанарын тогтолцоог хэрэгжүүлэх.
- Удирдамж, гарын авлага, чанарын хяналт, лабораторийн алгоритм, чанарын хяналтын үнэлгээнд оролцоо оролцоог бий болго замаар чанарын стандартыг хэрэгжүүлэх.
- Эсийн өсгөвөр, өндөгний үр хөврөлийг хэрэглэн вирус ялгах.
- Улирлын томуу, томуугийн H5N1 болон томуугийн бусад шинэ вирусийг илрүүлэх бодит хугацааны полимеразын гинжин урвал зэрэг молекул оношлогооны хүчин чадлыг нэмэгдүүлэх.
- ДЭМБ-ын стандарт серологийн урвалжыг ашиглан томуугийн хэвшинж, дэд хэвшинжийг тодорхойлох.
- Дэд хэвшинж тодорхой бус вирусийг эртилрүүлж, хариу арга хэмжээ авах тогтолцоо, протоколыг сайжруулах. ДЭМБ-ын Хамтын Ажиллагааны Лавлагaa төвд төлөөлөл болох омгуудыг тогтмол, дэд хэвшинж тодорхой бус эсвэл шинэ вирусийг яаралтай илгээх Нуклейн хүчлийн нуклеотудын дарааллыг тогтоох, цус наалдахыг саатуулах урвал, эсийн өсгөвөрт бичил саармагжуулах урвал, вирусийн эсрэг эмийн тэсвэржилтийг оношлох;
- Үндэсний хэмжээнд TYT-ийн сулжээлабораторийг орон нутагт байгуулж, дэгдэлт, шартахлын үед хариу арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх;

2. Вирус судал, эпидемиологийн тандалтыг холбон томуугийн тархвар судал, дарамтыг тодорхойлж, үндэсний сүлжээг бэхжүүлэхийн тулд;

• ТТӨ, АЗХХ-ын тандалтанда шаардлагатай мэдээ мэдээллийг стандартжуулах гарын авлагыг боловсруулах;

• Өвчний тандалтын болон бусад мэдээ, мэдээллийг яаралтай цуглуулах, солилцох үндэсний хэмжээний томуугийн мэдээллийн тогтолцоог бий болгож, бэхжүүлэх;

• Томуугийн өвчлөлийн дарамтыг (тохиолдлын тоо ба зардлын) тусгайлсан судалгаа явуулж тодорхойлох;

• Улирлын томуугийн вакциныг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах;

3. Бүсийн болон дэлхийн сүлжээг бий болгож бэхжүүлснээр үндэсний хэмжээний мэдээллийг дэмжих, харилцаа, холбоо, мэдээллийг сайжруулах;

• Бүсийн мэдээллийн тогтолцоонд хамрагдах;

• FluNet-д долоо хоног тутам мэдээлэх

• Малын эрүүл мэндийн салбартай нягт хамтран ажиллах

ДЭМБ-аас хэрэгжүүлэх үйл ажиллагаа

• Туршлага солилцох, тулгамдаж буй асуудлыг ярилцах, ДЭМБ-ын Хамтын ажиллагааны төвүүдийн харилцаа холбоог нэмэгдүүлэхийн тулд жил бүр TYT-үүдийн уулзалтыг зохион байгуулах;

• TYT-үүдийн хүчин чадлыг үнэлэн, сургалтын хэрэгцээг тодорхойлох, хамгийн наад захын хэрэгцээт чадавхийг бүрдүүлэхэд TYT-үүдэд дэмжлэг үзүүлэх;

• Чанарын стандартыг хэрэгжүүлэхэд TYT-үүдэд дэмжлэг үзүүлэх;

• Улс орнуудад томуугийн үндэсний мэдээллийн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

• Бүсийн мэдээллийн тогтолцоог бий болгох;

• Бүсийн хэмжээнд вакцин үйлдвэрлэлийн асуудлыг судлах бүсийн хэмжээний вакцины бодлогын асуудлаар ажлын багтай болох;

• Улс орон тус бүрээр бодлого нэвтрүүлсэн, хэрэгжүүлсэн болон үйл явдалын зэрэглэл, хор үршгийг тооцсон мэдээ, мэдээлэлтэй болох;

• Өвчний дарамтын судалгаа явуулах техникийн туслацаа, практикийн гарын авлагаар хангах.

**Англи хэлнээс орчуулсан
А.Бурмаа**

Тойм, лекц, зөвлөлгөө


ДЭМБ-ЫН ТОМУУГИЙН ТАРХАЛТЫН БҮСҮҮД

П.Нямдаваа, Б.Гансоож


Монгол-АНУ-ын “Томуугийн тандалтын сүлжээг бэхжүүлэн хөгжүүлэх” төслийн баг

ТТӨ-ний Дэлхий дахини тархалт, томуугийн вирусийн шинэ хувилбаруудын орчлын олон жилийн хандлага дээр үндэслэн ДЭМБ томуугийн вирусийн газарзүйн тархалтыг 18 бүс болгон хувааж дүн

шинжилгээ хийж, мэдээлэх болоод байна [1,2]. Манай эпидемиологчид, шийдвэр гаргагчид ч ТТӨ-тэй холбоотой гадаад мэдээллийг ашиглахдаа энэ бүсчлэлийг анхаарах шаардлагатай болж буй тул ТҮТ



Зураг 1. ДЭМБ-ын томуугийн тархалтын бүсүүд: I-Умард Америк, II-Төв Америк, III-Өмнөд Америкийн сэргүүн бүс, IV-Өмнөд Америкийн дулаан бүс, V-Умард Европ, VI-Баруун өмнөд Европ, VII-Дорнод Европ, VIII-Умард Африк, IX-Дорнод Африк, X-Төв Африк, XI-Өрнөд Африк, XII-Өмнөд Африк, XIII-Өрнөд Ази, XIV-Төв Ази, XV-Дорнод Ази, XVI-Өмнөд Ази, XVII-Зүүн өмнөд Ази, XVIII-Далайн орнууд



Зураг 2. 2011 оны 24 дүгээр долоо хоног дахь томуугийн вирусийн тархалтын байдал.

Энэ оны 7 дугаар сараас эхлэн томуугийн вирусийн дэд хэвшинжийн Дэлхий дахины тархалтыг сард 2 удаа ДЭМБ-ын мэдээлэл дээр үндэслэн www.flu.mn сайтад тавьж эхлээд байгаа юм [3].

Томуугийн тархалтын энэ бүсүүд [Зураг 1] нь бүс бүртээ дараахи улс орныг хамарч байгаа болно. Үүнд:

I. Умард Америк (North America)

1. Бермудийн арлууд (Bermuda)
2. Канад (Canada)
3. Гренланд (Greenland)
4. Гэгээн Пьериин ба Микуелоны арлууд (Saint Pierre and Miquelon)
5. АНУ (United States of America)

II. Төв Америк (Central America)

1. Ангуилла (Anguilla)
2. Антигуа ба Барбуда (Antigua and Barbuda)
3. Аруба (Aruba)
4. Бахамын арлууд (Bahamas)
5. Барбадос (Barbados)
6. Британий Виржин арлууд (British Virgin Islands)
7. Кеймэн арлууд (Cayman Islands)
8. Куба (Cuba)
9. Доминикан (Dominica)
10. БН Доминикан улс (Dominican Republic)
11. Гренада (Grenada)
12. Гуаделуп (Guadeloupe)
13. Хайти (Haiti)
14. Ямайка (Jamaica)

Томуугийн тархалтын энэ бүсүүд [Зураг 1] нь бүс бүртээ дараахи улс орныг хамарч байгаа болно. Үүнд:

I. Умард Америк (North America)

1. Бермудийн арлууд (Bermuda)
2. Канад (Canada)
3. Гренланд (Greenland)
4. Гэгээн Пьериин ба Микуелоны арлууд (Saint Pierre and Miquelon)
5. АНУ (United States of America)

II. Төв Америк (Central America)

1. Ангуилла (Anguilla)
2. Антигуа ба Барбуда (Antigua and Barbuda)
3. Аруба (Aruba)
4. Бахамын арлууд (Bahamas)
5. Барбадос (Barbados)

6. Британий Виржин арлууд (British Virgin Islands)
7. Кеймэн арлууд (Cayman Islands)
8. Куба (Cuba)
9. Доминикан (Dominica)
10. БН Доминикан улс (Dominican Republic)
11. Гренада (Grenada)
12. Гуаделуп (Guadeloupe)
13. Хайти (Haiti)
14. Ямайка (Jamaica)
15. Мартиник (Martinique)
16. Монтсеррат (Montserrat)
17. Нидерландын Антилын арлууд (Netherlands Antilles)
18. Пуэрто Рико (Puerto Rico)
19. Сент-Китс ба Невис (Saint Kitts and Nevis)
20. Сент-Люси (Saint Lucia)
21. Сент-Винсент ба Гренад (Saint Vincent and the Grenadines)
22. Тринидад ба Тобаго (Trinidad and Tobago)
23. Туркс ба Кайкос арлууд (Turks and Caicos Islands)
24. АНУ-ын Виржин арлууд (United States Virgin Islands)
25. Белиз (Belize)
26. Коста-Рика (Costa Rica)
27. Сальвадор (El Salvador)
28. Гватемал (Guatemala)
29. Хондурас (Honduras)
30. Мексик (Mexico)
31. Никарагуа (Nicaragua)
32. Панам (Panama)

III. Өмнөд Америкийн сэргүүн бүс (Temperate South America)

1. Аргентин (Argentina)
2. Чили (Chile)
3. Фолкландын арлууд (Falkland Islands (Malvinas))
4. Прагвай (Paraguay)
5. Урагвай (Uruguay)

IV. Өмнөд Америкийн дулаан бүс (Tropical South America)

1. Боливи (Bolivia (Plurinational State of))
2. Бразил (Brazil)
3. Колумби (Colombia)
4. Эквадор (Ecuador)
5. Францын Гиана (French Guiana)
6. Гайана (Guyana)
7. Перу (Peru)
8. Суринам (Suriname)
9. Венесуэль (Venezuela (Bolivarian Republic of))

V. Умард Европ (Northern Europe)

1. Дани (Denmark)
2. Эстони (Estonia)
3. Финлянд (Finland)
4. Гуэрнси (Guernsey)
5. Исланд (Iceland)
6. Ирланд (Ireland)
7. Мен арал (Isle of Man)
8. Жерси (Jersey)
9. Латви (Latvia)
10. Литв (Lithuania)
11. Норвеги (Norway)
12. Свальбард ба Ян Майений арлууд (Svalbard and Jan Mayen Islands)
13. Швед (Sweden)
14. Их Британи, Хойд Ирландын Нэгдсэн Ванд улс (United Kingdom of Great Britain and Northern Ireland)

VI. Баруун өмнөд Европ (South West Europe)

1. Албани (Albania)
2. Андорра (Andorra)
3. Босни-Херцеговин (Bosnia and Herzegovina)
4. Хорват (Croatia)
5. Гибралтор (Gibraltar)
6. Грек (Greece)
7. Гэгээн тэнгис (Holy See)
8. Итали (Italy)
9. Мальт (Malta)
10. Черногор (Montenegro)
11. Португал (Portugal)
12. Сан Марино (San Marino)
13. Серб (Serbia)
14. Серби ба Монтнегро (Serbia and Montenegro)
15. Словени (Slovenia)
16. Испани (Spain)
17. Македон (The former Yugoslav Republic of Macedonia)
18. Австри (Austria)
19. Бельги (Belgium)
20. Франц (France)
21. ХБНГУ (Germany)
22. Лихтенштайн (Liechtenstein)
23. Люксембург (Luxembourg)
24. Монако (Monaco)
25. Нидерланд (Netherlands)
26. Швейцар (Switzerland)
27. Мидвейн арлууд (Midway Islands)

VII. Дорнод Европ (Eastern Europe)

1. Беларус (Belarus)
2. Болгар (Bulgaria)

3. Чех (Czech Republic)
4. Унгар (Hungary)
5. Польш (Poland)
6. Молдов (Republic of Moldova)
7. Румын (Romania)
8. Оросын Холбооны Улс (Russian Federation)
9. Словак (Slovakia)
10. Україн (Ukraine)

VIII. Умард Африк (Northern Africa)

1. Алжир (Algeria)
2. Египет (Egypt)
3. Ливи (Libyan Arab Jamahiriya)
4. Мороко (Morocco)
5. Судан (Sudan)
6. Тунис (Tunisia)
7. Өрнөд сахар (Western Sahara)
- IX. Дорнод Африк (Eastern Africa)
 1. Бурунди (Burundi)
 2. Коморын арлууд (Comoros)
 3. Жибути (Djibouti)
 4. Эритреа (Eritrea)
 5. Этиопи (Ethiopia)
 6. Кени (Kenya)
 7. Мадагаскар (Madagascar)
 8. Малави (Malawi)
 9. Маврик (Mauritius)
 10. Майотт (Mayotte)
 11. Мозамбик (Mozambique)
 12. Реюнион (Réunion)
 13. Рванда (Rwanda)
 14. Сейшелийн арлууд (Seychelles)
 15. Сомали (Somalia)
 16. Уганда (Uganda)
 17. Танзанийн Нэгдсэн Улс (United Republic of Tanzania)
 18. Замби (Zambia)
 19. Зимбабве (Zimbabwe)- X. Төв Африк (Middle Africa)
 1. Ангол (Angola)
 2. Камерун (Cameroon)
 3. Төв Африкийн БН Улс (Central African Republic)
 4. Чад (Chad)
 5. Конго (Congo)
 6. БНА Конго Улс (Democratic Republic of the Congo)
 7. Эквадорын Гвиней (Equatorial Guinea)
 8. Габон (Gabon)
 9. Сан Том ба Присип (Sao Tome and Principe)

XI. Өрнөд Африк (Western Africa)

1. Бенин (Benin)
2. Буркина Фасо (Burkina Faso)
3. Кап Верде (Cape Verde)
4. Котдивуар (Сфте d'Ivoire)
5. Гамби (Gambia)
6. Гана (Ghana)
7. Гвиней (Guinea)
8. Гвиней-Биссау (Guinea-Bissau)
9. Либери (Liberia)
10. Мали (Mali)
11. Мавритани (Mauritania)
12. Нигер (Niger)
13. Нигери (Nigeria)
14. Гэгээн Елений арлууд (Saint Helena)
15. Сенегал (Senegal)
16. Сьерра Леон (Sierra Leone)
17. Того (Togo)

XII. Өмнөд Африк (Southern Africa)

1. Ботсвана (Botswana)
2. Лесото (Lesotho)
3. Намиби (Namibia)
4. Өмнөд Африк (South Africa)
5. Свазиленд (Swaziland)

XIII. Өрнөд Ази (Western Asia)

1. Армен (Armenia)
2. Азербайжан (Azerbaijan)
3. Бахрайн (Bahrain)
4. Кипр (Cyprus)
5. Гүрж (Georgia)
6. Ирак (Iraq)
7. Израиль (Israel)
8. Йордан (Jordan)
9. Кувейт (Kuwait)
10. Ливан (Lebanon)
11. Оман (Oman)
12. Катар (Qatar)
13. Саудын Араб (Saudi Arabia)
14. Сирийн Араб БН Үлс (Syrian Arab Republic)
15. Түрк (Turkey)
16. Арабын Нэгдсэн Эмират (United Arab Emirates)
17. Йемен (Yemen)

XIV. Төв Ази (Central Asia)

1. Казакстан (Kazakhstan)
2. Киргизстан (Kyrgyzstan)
3. Тажикстан (Tajikistan)
4. Түркменистан (Turkmenistan)

5. Узбекстан (Uzbekistan)

XV. Дорнод Ази (Eastern Asia)

1. БНХАУ (China)
2. БНАСАУ (Democratic People's Republic of Korea)
3. Япон (Japan)
4. Монгол (Mongolia)
5. БНСҮ (Republic of Korea)

XVI. Өмнөд Ази (Southern Asia)

1. Афганистан (Afghanistan)
2. Бангладэш (Bangladesh)
3. Бутан (Bhutan)
4. Энэтхэг (India)
5. Исламын БН Иран Үлс (Iran (Islamic Republic of))
6. Мальдив (Maldives)
7. Балба (Nepal)
8. Пакистан (Pakistan)
9. Шриланк (Sri Lanka)
10. Иран (Iran)

XVII. Зүүн өмнөд Ази (South East Asia)

1. Бруней Даруссалам (Brunei Darussalam)
2. Кампучи (Cambodia)
3. Индонез (Indonesia)
4. Лаос (Lao People's Democratic Republic)
5. Малайз (Malaysia)
6. Мьянма (Myanmar)
7. Филиппин (Philippines)
8. Сингапур (Singapore)
9. Тайланд (Thailand)
10. Тимор-Лесте (Timor-Leste)
11. Вьетнам (Viet Nam)

XVIII. Далайн орнууд (Oceania, Melanesia and Polynesia)

1. Австрали (Australia)
2. Шинэ Зеланд (New Zealand)
3. Норфолкийн арлууд (Norfolk Island)
4. Фиджи (Fiji)
5. Шинэ Каледон (New Caledonia)
6. Папуа Шинэ Гвиней (Papua New Guinea)
7. Соломоны арлууд (Solomon Islands)
8. Вануату (Vanuatu)
9. Гуам (Guam)
10. Кирибати (Kiribati)
11. Маршалын арлууд (Marshall Islands)
12. Микронези (Micronesia (Federated States of))
13. Науру (Nauru)

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН МОНГОЛЫН СЭТГҮҮЛ №3(40) 2011 ОН

14. Умард Марианы арлууд (Northern Mariana Islands)
15. Палау (Palau)
16. Америкийн Самоа (American Samoa)
17. Кукин арал (Cook Islands)
18. Францын Полинези (French Polynesia)
19. Ниуе (Niue)
20. Питкайрны арлууд (Pitcairn Island)
21. Самоа (Samoa)
22. Токелау (Tokelau)
23. Тонга (Tonga)
24. Тувалу (Tuvalu)
25. Валлис ба Футуна (Wallis and Futuna)

Томуугийн тархалтын одоогийн байдлаас үзвэл

[Зураг 2] одоогоор хүйтэн улирал нь таарч байгаа Дэлхийн бөмбөрцгийн өмнөд хэсгийн орнууд ТТӨ-ний өвчлөл харьцангуй өндөр, томуугийн A(H1), A(H3) болон B вирус харилсан адилгүй тархалттай илэрч байна. Манай хөрш орнуудад дулаан улирал байгаа тул томуугийн вирусийн орчил алга байна.

Ном зүй

1. Influenza transmission zones http://www.who.int/csr/diseases/swineflu/Influenza_Transmission_Zones.pdf
2. Томуугийн тархалтын бүсүүд http://www.flu.mn/mgl/index.php?option=com_content&task=view&id=671&Itemid=49
3. Томуу Дэлхий дахинд (2011 оны 24 дүгээр 7 хоног) http://www.flu.mn/mgl/index.php?option=com_content&task=view&id=729&Itemid=49

* * *

ИНТЕРНЕТЭД СУУРИЛСАН ТОМУУГИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙГ АШИГЛАХ ТУХАЙ

Б.Ганшоож, Л.Энхбаатар, П.Нямдаваа

Монгол-АНУ-ын "Томуугийн тандалтын сүлжээг бэхжүүлэн хөгжүүлэх" төслийн баг

Интернетэд суурилсан томуугийн мэдээллийн систем (ИСТМС: FIS- InFluenza Information System)-ийг АНУ-аас санхүүжүүлэн хэрэгжүүлж буй "Томуугийн тандалтын сүлжээг бэхжүүлэн хөгжүүлэх" төслийн хүрээнд "Инженерсофт" ХХК компаниар хийлгэж, 2010/2011 оны томуугийн улиралтуршин нэвтрүүлсэн нь амжилттай болж, орчуулж бусийн гишүүн бусад орнуудад нэвтрүүлэхийг ДЭМБ-ын Номхон Далайн Баруун Бүсийн хорооноос манай улсад санал болгож байгаа билээ. ИСТМС-д нэвтрэхдээ www.flu.mn сайтын баруун дээд өнцөгт байгаа(зураг дээр сумаар заасан) "Интернетэд суурилсан томуугийн

мэдээллийн систем" холбоосон дээр дарж орно [Зураг 1]. Ингэхэд ИСТМС-ийн нэвтрэх хэсэг гарна [Зураг 2].

Нэр, нууц үгээ хийж "Нэвтрэх" гэсэн товчийг дараахад ИСТМС-д нэвтрэч "Амжилттай холбогдоо" гэсэн мэдээлэл гарна [Зураг 3]. Нэр, нууц үгээ буруу хийвэл нэр, нууц үгээ засахыг шаардсан мэдээлэл гарч ирнэ [Зураг 4].

Нэвтрэх нэр болон нууц үгийг TYT-өөс өгнө. Нэр нууц үгээ мартсан эсвэл орохгүй байгаа бол gantsoo@ mail.mn хаягаар буюу 91998239 утсаар холбогдож асууж тодруулж болно.



Зураг 1. www.flu.mn сайт дахь ИСТМС-ийн оролт

The screenshot shows the homepage of the Tomogii website. At the top right, there is a logo for 'NIC MONGOLIA' and the text 'Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам' and 'Халдварт өвчин судлалын үндэсний төв'. Below this, the title 'ТОМОУГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ' is displayed. On the left, there is a search bar with fields for 'Нэр:' and 'Нууц үт:', and a button labeled 'Нэвтрэх». At the bottom, a footer bar contains the text '2010 © Томуугийн Үндэсний Төв, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв, Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам'.

Зураг 2. ИСТМС-ийн нэвтрэх хэсэг

This screenshot is identical to the one above, showing the homepage of the Tomogii website. It features the 'NIC MONGOLIA' logo, the text 'Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам' and 'Халдварт өвчин судлалын үндэсний төв', and the title 'ТОМОУГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ'. The search bar at the top left is visible, along with the footer '2010 © Томуугийн Үндэсний Төв, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв, Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам'.

Зураг 3. ИСТМС-ийн үндсэн хуудас

This screenshot shows the same website layout as the previous ones. A large orange arrow points from the bottom left towards the search bar area. The search bar has fields for 'Нэр:' and 'Нууц үт:', and a button labeled 'Хэвлэх». The footer '2010 © Томуугийн Үндэсний Төв, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв, Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам' is at the bottom.

Зураг 4. Нэр, нууц үгээ буруу хийсэн үед гарах хуудас

Үндсэн цэсийн [Зураг 3] 1) "ТТӨ, А3ХХ(Өрхийн эмч)", 2) "ТТӨ, А3ХХ(Статистикч эмч)", 3) "Эмнэлэгт суурьласан тандалтын мэдээний бүртгэл", 4) "Сорыц", 5) "Шинжилгээ", 6) "Тохиргоо", 7) "Тайлан" гэсэн хэсгүүд нь Томуугийн харуулдан тандалтын нэгж(TXTH)-үүдийн өвөрмөц үйл ажиллагаатай зохицсон байх бөгөөд нэвтэрсэн хэрэглэгчийн эрхээс хамаарч зарим цэс нь харагдахгүй.

Нэг. ТТӨ, А3ХХ(өрхийн эмч)

Үндсэн цэсийн "ТТӨ, А3ХХ(Өрхийн эмч)" гэсэн хэсгээр өрхийн эмнэлгийн(ӨЭ) эмч болон Нэгдсэн

эмнэлэг(НЭ)-ийн статистикч, халдварт судлагч гэсэн эрх олгосон хэрэглэгчид нэвтэрч өдөр тутмын амбулаторын үзлэгийн мэдээг оруулна.

Мэдээ оруулах алхам:

- "ТТӨ, А3ХХ(Өрхийн эмч)" цэсэн дээр дараахад "ТТӨ, А3ХХ(Өрхийн эмч)" гэсэн хуудас [Зураг 5] гарч ирнэ. Энэ хуудсандаа нэвтэрсэн хэрэглэгчээс хамаарч аймаг, сум, эрүүл мэндийн байгууллага нь автоматаар сонгогдсон байна,

- Гарч ирэх хуудасны огноо хэсгээс оруулах мэдээны он сарыг сонгоод түүвэрлэх товчийг дараахад

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН МОНГОЛЫН СЭТГҮҮЛ №4(41) 2011 ОН

оруулсан оны сарын календарь гарч ирнэ. Улаан өнгөтэй нь мэдээ өгөөгүй, цэнхэр өнгөтэй нь мэдээ өгсөн, хар өнгөтэй нь мэдээ өгөх боломжгүй буюу ирээдүйн өдрүүдийг тэмдэглэсэн байна.

III. Гарч ирэх календараас мэдээ оруулах өдрийг дараахад “Амбулаторын үзлэгийн мэдээ оруулах маягт” [Зураг 6] гарч ирнэ,

IV. Гарч ирэх мэдээний маягтыг бөглөж хадгалах товчийг (зураг дээр сумаар заасан) дарна. “Нийт”,

“Амбулаторийн нийт үзлэгт ТТӨ-ний эзлэх хувь” болон “ТТӨ-ний шалтгаантай дуудлагын хувь” автоматаар бодогдоно. Хэрвээ “ТТӨ-өөс Амьсгалын замын хүнд халдварт” гэсэн нүдэнд оруулсан тоо нь “ТТӨ-ий нийт тохиолдол”-оос их, “ТТӨ-ий нийт тохиолдол” гэсэн нүдэнд оруулсан тоо нь “Амбулаторийн нийт үзлэг”-ээс их, “ТТӨ-ийн шалтгаантай” гэсэн нүдэнд оруулсан тоо нь “Түргэн тусламжийн дуудлага”-аас их байвал програмаас алдаатай мэдээлэл гэж үзэн автоматаар “0” болгоно.

Бүртгэлийн мэдээлэл																																																	
<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 30%;">Аймаг/ хот/</td> <td style="width: 70%;">Улаанбаатар</td> </tr> <tr> <td>Сум/дүүрэг/</td> <td>Хан-Уул/з/</td> </tr> <tr> <td>Эрүүл мэндийн байгууллага</td> <td>Хан-Уул дүүрэг Э/М/Г</td> </tr> <tr> <td>Огноо</td> <td>2010 <input type="button" value="▼"/> 9 сар <input type="button" value="▼"/> Түүвэрлэх</td> </tr> </table>	Аймаг/ хот/	Улаанбаатар	Сум/дүүрэг/	Хан-Уул/з/	Эрүүл мэндийн байгууллага	Хан-Уул дүүрэг Э/М/Г	Огноо	2010 <input type="button" value="▼"/> 9 сар <input type="button" value="▼"/> Түүвэрлэх																																									
Аймаг/ хот/	Улаанбаатар																																																
Сум/дүүрэг/	Хан-Уул/з/																																																
Эрүүл мэндийн байгууллага	Хан-Уул дүүрэг Э/М/Г																																																
Огноо	2010 <input type="button" value="▼"/> 9 сар <input type="button" value="▼"/> Түүвэрлэх																																																
ТТӨ, АЗХХ-ын мэдээ																																																	
<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th colspan="7" style="text-align: center;">2010 оны 09 сар</th> </tr> <tr> <th>Даваа</th> <th>Мягмар</th> <th>Лхагва</th> <th>Пүрвэв</th> <th>Баасан</th> <th>Бямба</th> <th>Ням</th> </tr> </thead> <tbody> <tr> <td></td> <td></td> <td style="text-align: center;">1</td> <td style="text-align: center;">2</td> <td style="text-align: center;">3</td> <td style="text-align: center;">4</td> <td style="text-align: center;">5</td> </tr> <tr> <td style="text-align: center;">6</td> <td style="text-align: center;">7</td> <td style="text-align: center;">8</td> <td style="text-align: center;">9</td> <td style="text-align: center;">10</td> <td style="text-align: center;">11</td> <td style="text-align: center;">12</td> </tr> <tr> <td style="text-align: center;">13</td> <td style="text-align: center;">14</td> <td style="text-align: center;">15</td> <td style="text-align: center;">16</td> <td style="text-align: center;">17</td> <td style="text-align: center;">18</td> <td style="text-align: center;">19</td> </tr> <tr> <td style="text-align: center;">20</td> <td style="text-align: center;">21</td> <td style="text-align: center;">22</td> <td style="text-align: center;">23</td> <td style="text-align: center;">24</td> <td style="text-align: center;">25</td> <td style="text-align: center;">26</td> </tr> <tr> <td style="text-align: center;">27</td> <td style="text-align: center;">28</td> <td style="text-align: center;">29</td> <td style="text-align: center;">30</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	2010 оны 09 сар							Даваа	Мягмар	Лхагва	Пүрвэв	Баасан	Бямба	Ням			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30			
2010 оны 09 сар																																																	
Даваа	Мягмар	Лхагва	Пүрвэв	Баасан	Бямба	Ням																																											
		1	2	3	4	5																																											
6	7	8	9	10	11	12																																											
13	14	15	16	17	18	19																																											
20	21	22	23	24	25	26																																											
27	28	29	30																																														
<p style="margin: 0;">Улан - Бүртгэл ороогүй</p> <p style="margin: 0;">Цэнэр - Бүртгэл орсон</p> <p style="margin: 0;">Саарал - Амралтын едер</p>																																																	

Зураг 5. “ТТӨ, АЗХХ(Өрхийн эмч)” хуудас

ТТӨ, АЗХХ-ын мэдээ																																																																																																																																							
<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td colspan="2" style="width: 20%;">Бүртгэлийн мэдээлэл</td> <td colspan="7" style="width: 80%;">Бүртгэсэн эрүүл мэндийн байгууллага</td> </tr> <tr> <td colspan="2"></td> <td colspan="7">Хан-Уул дүүрэг Э/М/Г</td> </tr> <tr> <td colspan="2" style="width: 20%;">Бүртгэсэн огноо</td> <td colspan="7">2010-09-1 нд</td> </tr> <tr> <td colspan="2"></td> <td colspan="7">ganb</td> </tr> <tr> <td colspan="9" style="text-align: center;">ТТӨ, АЗХХ-ын мэдээ</td> </tr> <tr> <td style="width: 15%; padding: 5px;">Үзүүлэлт</td> <td style="width: 10%;">0-11 сар</td> <td style="width: 10%;">1-4 нас</td> <td style="width: 10%;">5-9 нас</td> <td style="width: 10%;">10-15 нас</td> <td style="width: 10%;">16-24 нас</td> <td style="width: 10%;">25-44 нас</td> <td style="width: 10%;">45-64 нас</td> <td style="width: 10%;">65-с дээш</td> <td style="width: 10%;">Нийт</td> </tr> <tr> <td>Амбулаторийн нийт үзлэг</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>ТТӨ-ий нийт тохиолдол</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>ТТӨ-с Амьсгалын замын хүнд халдварт</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>ТТӨ-с Голомтолсон ячилж</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>Амбулаторийн нийт үзлэг ТТӨ-ийн эзлэх хувь</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>Түргэн тусламжийн дуудлага</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>ТТӨ-ийн шалтгаантай</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> <tr> <td>ТТӨ-ийн шалтгаантай дуудлагын хувь</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> <td>0</td> </tr> </table>	Бүртгэлийн мэдээлэл		Бүртгэсэн эрүүл мэндийн байгууллага									Хан-Уул дүүрэг Э/М/Г							Бүртгэсэн огноо		2010-09-1 нд									ganb							ТТӨ, АЗХХ-ын мэдээ									Үзүүлэлт	0-11 сар	1-4 нас	5-9 нас	10-15 нас	16-24 нас	25-44 нас	45-64 нас	65-с дээш	Нийт	Амбулаторийн нийт үзлэг	0	0	0	0	0	0	0	0	0	ТТӨ-ий нийт тохиолдол	0	0	0	0	0	0	0	0	0	ТТӨ-с Амьсгалын замын хүнд халдварт	0	0	0	0	0	0	0	0	0	ТТӨ-с Голомтолсон ячилж	0	0	0	0	0	0	0	0	0	Амбулаторийн нийт үзлэг ТТӨ-ийн эзлэх хувь	0	0	0	0	0	0	0	0	0	Түргэн тусламжийн дуудлага	0	0	0	0	0	0	0	0	0	ТТӨ-ийн шалтгаантай	0	0	0	0	0	0	0	0	0	ТТӨ-ийн шалтгаантай дуудлагын хувь	0	0	0	0	0	0	0	0	0
Бүртгэлийн мэдээлэл		Бүртгэсэн эрүүл мэндийн байгууллага																																																																																																																																					
		Хан-Уул дүүрэг Э/М/Г																																																																																																																																					
Бүртгэсэн огноо		2010-09-1 нд																																																																																																																																					
		ganb																																																																																																																																					
ТТӨ, АЗХХ-ын мэдээ																																																																																																																																							
Үзүүлэлт	0-11 сар	1-4 нас	5-9 нас	10-15 нас	16-24 нас	25-44 нас	45-64 нас	65-с дээш	Нийт																																																																																																																														
Амбулаторийн нийт үзлэг	0	0	0	0	0	0	0	0	0																																																																																																																														
ТТӨ-ий нийт тохиолдол	0	0	0	0	0	0	0	0	0																																																																																																																														
ТТӨ-с Амьсгалын замын хүнд халдварт	0	0	0	0	0	0	0	0	0																																																																																																																														
ТТӨ-с Голомтолсон ячилж	0	0	0	0	0	0	0	0	0																																																																																																																														
Амбулаторийн нийт үзлэг ТТӨ-ийн эзлэх хувь	0	0	0	0	0	0	0	0	0																																																																																																																														
Түргэн тусламжийн дуудлага	0	0	0	0	0	0	0	0	0																																																																																																																														
ТТӨ-ийн шалтгаантай	0	0	0	0	0	0	0	0	0																																																																																																																														
ТТӨ-ийн шалтгаантай дуудлагын хувь	0	0	0	0	0	0	0	0	0																																																																																																																														
<p style="margin: 0;">Хадгалах</p> <p style="margin: 0; color: blue;">Буцах</p>																																																																																																																																							

Зураг 6. Амбулаторын үзлэгийн мэдээ оруулах маягт

Хоёр. ТТӨ, АЗХХ(Статистик эмч)

Үндсэн цэсний “ТТӨ, АЗХХ(Статистик эмч)” цэс нь аймгийн Эрүүл мэндийн газар(ЭМГ), дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл (ЭМН)-ийн статистикч болон халдварт судлагч эрх олгосон хэрэглэгчид нэвтэрч мэдээллээ оруулна. Энэ цэс нь “Бүртгэл(Статистик эмч)”, “7 хоногийн мэдээ(Статистик эмч)” гэсэн 2 дэд цэстэй.

а. Бүртгэл(Статистик эмч)

Энд тухайн аймаг, дүүрэгт хариалагдах ТЭ-үүдийн мэдээг харах, засах, нэмэх үйлдвүүдийг хийнэ.

Мэдээ оруулах алхам:

I. “ТТӨ, АЗХХ(Статистик эмч)” цэс дээр дараад “Бүртгэл(Статистик эмч)” дэд цэсийг сонгоход “Бүртгэл(Статистик эмч)” хуудас [Зураг 7] гарч ирнэ. Энэ хуудсанд нэвтэрсэн хэрэглэгчээс хамаарч аймаг, сум автоматаар сонгогдсон байна,

II. Гарч ирэх хуудасны огноо хэсгээс оруулах мэдээний он сарыг сонгоод түүвэрлэх товчийг дараад оруулсан оны сарын календарь гарч ирнэ. Улаан өнгөтэй нь нэгч ТЭ мэдээ өгөөгүй, ногон өнгөтэй нь зарим ТЭ мэдээ өгөөгүй, цэнхэр өнгөтэй нь бүх ТЭ мэдээ өгсөн, хар өнгөтэй нь мэдээ өгөх боломжгүй буюу ирээдүйн өдрүүдийг тэмдэглэсэн байна,

III. Гарч ирэх календараас мэдээ оруулах өдрийг дараад өрхийн эмлэгүүдийн мэдээ өгсөн байдлыг харуулсан хүснэгт гарна[Зураг 8],

IV. Гарч ирэх хүснэгтээс ТЭ-ийн харгалзах “үүсгэх” эсвэл “засах” товчийг (зураг дээр сумаар заасан) дараад “Амбулаторын үзлэгийн мэдээ оруулах маягт” [Зураг 6] гарч ирнэ,

V. Гарч ирэх мэдээний маягтыг бөглөж “хадгалах” товчийг (зураг дээр сумаар заасан) дарна [Зураг 6].

2010 оны 09 сар							
Даваа	Мягмар	Пхагва	Пурз	Басан	Бимба	Ням	7 Хоног
1	2	3	4	5	35		
6	7	8	9	10	11	12	36
13	14	15	16	17	18	19	37
20	21	22	23	24	25	26	38
27	28	29	30				39

Улаан - Бүртгэл ороогүй
Ногоон - Бүртгэл длүү орсон
Цинкор - Бүртгэл гүйцэт орсон
Саарал - Амбарлын өдөр
Хар - Долоо хоног

Зураг 7. “Бүртгэл(Статистик эмч)” хуудас

Тандалтын нолж	Нийт	ТТӨ-ийн нийт тохиолдол	AZXX	Голомтлодсон өвчлөл	Амбулториан нийт улзгат TTӨR-ийн эзлэх хувь	Нийт	ТТӨ-ийн шалгаантай	Золз хувь	Модз
Манал ўйлс	83	0	0	0	0	2	0	0	Үзүүлэх
Амин тус									Үзүүлэх
Энхитэм									Үзүүлэх

Зураг 8. Тухайн аймаг, дүүрэгт хариалагдах ТЭ-үүдийн мэдээ өгөх хуудас


ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН МОНГОЛЫН СЭТГҮҮЛ №3(40) 2011 ОН

6. 7 хоногийн мэдээ(Статистикч эмч)
 Энд аймаг, дүүргийн 7 хоногийн мэдээг оруулна.
Мэдээ оруулах алхам:
 I. “ТТӨ, АЗХХ(Статистикч эмч)” цэс дээр дараад
 “7 хоногийн мэдээ(Статистикч эмч)” дэд цэсийг
 сонгоход аймаг, дүүргийн мэдээ өгөх хуудас гарна,
 II. Гарч ирэх хүснэгтээс мэдээ оруулах долоо

хоногийн хойно харгалзах “үүсгэх” (зураг дээр сумаар заасан) товчийг дарна [Зураг 9],

III. Гарч ирэх мэдээний маягийг бөглөж хадгалах товчийг (зураг дээр сумаар заасан) дарна [Зураг 6],

IV. Хэрвээ оруулах мэдээний долоо хоног харагдахгүй бол “түүвэрлэх сонголтууд” хэсгээс он, долоо хоногийг сонгоод түүвэрлэх товчийг дарна.



Түүвэрлэлтийн үр дүн												
Амбулаторын нийт үзлээ						Түрээн тусламжийн дуудлага						
Он	7 Хоног	Аймаг хот	Сум дүүрэг	Эрүүл мэндийн байгууллага	Нийт ТТӨ-ий нийт тохиолдол	АЗХХ	Голомтолсон өвчлөл	Амбулаторын нийт үзлэгээг ТТӨ-ий эзлэх хувь	Нийт	ТТӨ-ий шалтгаантай	Эзлэх хувь	Мэдээ
2010	38	Улаанбаатар	Хан-Уул/з/	Хан-Уул дүүрэг Э/М/Г								Үзүүлэх
2010	37	Улаанбаатар	Хан-Уул/з/	Хан-Уул дүүрэг Э/М/Г	6533	268	0	0	4	89	30	33
2010	36	Улаанбаатар	Хан-Уул/з/	Хан-Уул дүүрэг Э/М/Г	7164	238	0	0	3	74	29	39
2010	35	Улаанбаатар	Хан-Уул/з/	Хан-Уул дүүрэг Э/М/Г	7213	165	0	0	2	69	25	36

Зураг 9. Аймаг, дүүргийн статистикч эмчийн мэдээ өгөх хуудас

Гурав. Эмнэлэгт сууриссан тандалтын мэдээний бүртгэл

“Эмнэлэгт сууриссан тандалтын мэдээний бүртгэл” цэс нь НЭ, Лавлагaa төвүүдийн статистикч болон халдварт судлагч эрх олгосон хэрэглэгчид нэвтрэрэн орж долоо хоногийн орны хөдөлгөөний мэдээ оруулна.

Мэдээ оруулах алхам:

I. “Эмнэлэгт сууриссан тандалтын мэдээний бүртгэл” цэсийг сонгоно. Ингэхэд “Эмнэлэгт сууриссан тандалтын мэдээний бүртгэл” гэсэн хуудас [Зураг 10] гарна,

II. Гарч ирэх хүснэгтээс мэдээ оруулах долоо

хоногийн хойно харгалзах үүсгэх товчийг дарж гарч ирэх хуудсанд [Зураг 11] мэдээгээ шивж “хадгалах” товчийг дарна. Хэрвээ “Уүшигний үрэвсэл(АЗХХ)-ээр хүндэрсэн” нь “Больнишын орны хөдөлгөөн” –өөс их тоо оруулсан бол програмаас энэ тохиолдолыг алдаатай мэдээлэл гэж үзэн автоматаар “0” болгоно. Мөн долоо хоногийн эцэст байгаа тоо хасах тоо гарсан бол алдаатай мэдээлэл оруулсан тухай мэдэгдэл бүхий цонх гарна [Зураг 12],

III. Хэрвээ оруулах мэдээний долоо хоног харагдахгүй бол “түүвэрлэх сонголтууд” хэсгээс он, долоо хоногийг сонгоод түүвэрлэх товчийг дарна.

Түүвэрлэх сонголтууд											
2010	оны	1	дахь 7 хоногоос	Бүртгэсн эм байгууллага:	Хан уул дүүргэг Н/Э	<input type="checkbox"/>	Түүвэрлэх				
2010	оны	38	дахь 7 хоног хуртэл								

Түүвэрлэлтийн үр дүн															
Больницын орны хөдөлгөөн						Үнээс ушигийн үрэсэл/(4300)-зар хүндэрсан									
Он	7 Хоног	Аймаг хот	Сум дүүрг	Эрүүл мэндийн байгууллага	Өнгөрсөн 7 хоногийн эцэст байсан нийт вичен	Эдгэрч гарсан, шилжсан	Нас барсан	Шинээр хөтөснө	Энэ 7 хоногийн эцэст байгаа	Өнгөрсөн 7 хоногийн эцэст байсан нийт вичен	Эдгэрч гарсан, шилжсан	Нас барсан	Шинээр хөтөснө	Энэ 7 хоногийн эцэст байгаа	Мэдээ
2010	38	Улаанбаатар	Сонгинохайрхан	Хан уул дүүргэг Н/Э											Үсэргүүлж
2010	37	Улаанбаатар	Сонгинохайрхан	Хан уул дүүргэг Н/Э											Үсэргүүлж
2010	36	Улаанбаатар	Сонгинохайрхан	Хан уул дүүргэг Н/Э											Үсэргүүлж
2010	35	Улаанбаатар	Сонгинохайрхан	Хан уул дүүргэг Н/Э											Үсэргүүлж


Зураг 10. НЭ-үүдийн статистикч эмчийн мэдээ өгөх хуудас

Эмнэлгэтийн сууринласан тандалтын мэдээний бүртгэл											
Бүртгэлийн мэдээлэл											
Aймаг хот	Улаанбаатар										
Сум/дүүрг	Сонгинохайрхан										
Бүртгэсэн хэрэглэгчийн нэр	ganb										
Бүртгэсэн эрүүл мэндийн байгууллага	Хан уул дүүргэг Н/Э										

Эмнэлгэтийн сууринласан тандалтын мэдээ											
Хэд дах 7 хоног											
Хэд дах 7 хоног	38										
Батлагдан нийт орны тоо											
Больницын орны хөдөлгөөн											
Үзүүлэлт	0-4 нас	5-9 нас	10-19 нас	20-49 нас	50-59 нас	60-с дээш	Нийт	Үзүүлэлт	0-4 нас	5-9 нас	10-19 нас
Өнгөрсөн 7 хоногийн эцэст байсан нийт вичен	0	0	0	0	0	0	0	Өнгөрсөн 7 хоногийн эцэст байсан нийт вичен	0	0	0
Эдгэрч гарсан, шилжсан	0	0	0	0	0	0	0	Эдгэрч гарсан, шилжсан	0	0	0
Нас барсан	0	0	0	0	0	0	0	Нас барсан	0	0	0
Шинээр хөтөснө	0	0	0	0	0	0	0	Шинээр хөтөснө	0	0	0
Энэ 7 хоногийн эцэст байгаа	0	0	0	0	0	0	0	Энэ 7 хоногийн эцэст байгаа	0	0	0

Үнээс Ушигийн үрэсэл/(4300)-ээр хүндэрсан											
Үзүүлэлт	0-4 нас	5-9 нас	10-19 нас	20-49 нас	50-59 нас	60-с дээш	Нийт	Үзүүлэлт	0-4 нас	5-9 нас	10-19 нас
Өнгөрсөн 7 хоногийн эцэст байсан нийт вичен	0	0	0	0	0	0	0	Өнгөрсөн 7 хоногийн эцэст байсан нийт вичен	0	0	0
Эдгэрч гарсан, шилжсан	0	0	0	0	0	0	0	Эдгэрч гарсан, шилжсан	0	0	0
Нас барсан	0	0	0	0	0	0	0	Нас барсан	0	0	0

Зураг 11. НЭ-үүдийн орны хөдөлгөөн оруулах хуудас



Зураг 12. Мэдээ буруу оруулсан тохиолдолд гарах цонх

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН МОНГОЛЫН СЭТГҮҮЛ №3(40) 2011 ОН

Дөрөв. Сорыц

“Сорыц” цэс “Сорыцын жагсаалт”, “Сорыцын бүртгэл” гэсэн 2 дэд цэстэй ба бүх хэрэглэгчид сорыцын мэдээлэл оруулах боломжтой.

а. Сорыцын жагсаалт

Энд өмнө явуулж байсан сорыцын мэдээлэл, шинжилгээний хариуг харах ба “Түүвэрлэх сонголт” хэсгээр хэрэгтэй мэдээлээ хайж олно[Зураг 13].

Сорыцын жагсаалт Сорыцын бүртгэл											
Түүвэрлэх сонголт											
Жагсаалт											
Сорыцын мэдээлэл		Өвчтөний мэдээлэл				Шинжилгээний мэдээлэл					
Сорыцын №	Сорыцын төрөл	РД	Эзргэх/ийн нэр	Нэр	Өвчин эхэлсэн огноо	Сорыц авсан огноо	Шинжилгээнд авсан огноо	Сорыц/терел	Шинж/терел	Ерөнхий хариу	Дэлгэрэнгүй хариу
101010118	Хамрын арчдас	УО08230566	Уутанбаир	Цэнэг	2010-09-18	2010-09-21 01:09:00					
101010117	Хамрын арчдас	ХИ55113007	А	Халтар	2010-09-16	2010-09-16 01:09:00					
101010115	Хамрын арчдас	ИЮ91042318	Ганкуяг	Үүрцайх	2010-09-15	2010-09-15 20:09:00					
101010116	Хамрын арчдас	АЗ75052461	Жалганжав	Олончимэг	2010-09-15	2010-09-15 20:09:00					
101010050	Хамрын арчдас	УД66090103	Д	Уранчимэг	2010-06-04	2010-06-08 01:06:00	Ердийн ПГУ	Эрэг	Томуу А		
101010102	Хамрын арчдас	УЗ96050731	Н	Олонжаргал	2010-06-03	2010-06-08 01:06:00	Ердийн ПГУ	Серег			

Зураг 13. “Сорыцын жагсаалт”

б. Сорыцын бүртгэл

Энд сорыцны тухай мэдээллийг бүртгэнэ.

Сорыцын мэдээлэл оруулах:

I. “Сорыц” цэс дээр дараад “Сорыцын бүртгэл” дэд цэсийг сонгоход сорыц бүртгэх хуудас [Зураг 14] гарч ирнэ,

II. Гарч ирэх хуудсыг бөглөөд “Бүртгэх” товчийг дарна.

III. Сорыцон дээрээ “Шинжилгээнд авсан сорыцын мэдээлэл” хэсгийн “сорыцын дугаар”-ыг (зураг дээрsumaар заасан) програмаас автоматаар өгөх ба үүнийг Регистрийн дугаарын хамт хуруу шилэн дээр бичиж лабораторт хүргүүлнэ [Зураг 15].

Сорыцын жагсаалт Сорыцын бүртгэл											
Өвчтөний мэдээлэл											
Бүртгэлийн мэдээлэл											
Регистрийн дугаар:											
Эзргэх/ийн нэр:											
Нэр:											
Төрсөн огноо / хүйс:	<input type="button" value="Сонгох"/> <input checked="" type="button" value="Хүрс"/>										
Оршин суугаа аймаг, хот:	<input type="button" value="Сонгох"/>										
Оршин суугаа сум, дүүрэг:	<input type="button" value="Сонгох"/>										
Оршин суугаа хороо:											
Оршин суугаа дэлгэрэнгүй хаяг:											
Утасны дугаар:											

Зураг 14. Сорыц бүртгэх хуудас

Шинжилгээнд авсан сорьцын мэдээлэл

Сорьцын дугаар:	101010119	↑
Сорьц авсан эмч, сувилагчийн нэр:	Итгэл-Угтх	
Сорьцын төрөл:	[Сонгох]	
Сорьц авсан огноо:	2010-09-21 8:9	
Сорьцыг тээвэрлэлтэнд өгсөн огноо:	2010-09-21 8:9	
<input type="button" value="Бүртгэх"/> <input type="button" value="Болиж"/>		

Зураг 15. Сорьцын дугаар

Тав. Шинжилгээ

“Шинжилгээ” цэсээр лабораторийн эмч гэсэн эрхтэй хэрэглэгчид нэвтэрч шинжилгээний хариуг бөглөнө. Энэ цэс “Шинжилгээний жагсаалт”, “Шинжилгээний бүртгэл” гэсэн 2 дэд цэстэй.

Мэдээ оруулах алхам:

- I. “Шинжилгээ” цэсэн дээр дараахад явуулсан сорьцын мэдээллийг жагсаалтаар гарч ирнэ,
- II. Ирсэн сорьцыг Регистерийн дугаар, сорьцын дугаараар хайж харгалзах “хүлээн авах” (зураг дээр улаан сумаар заасан) товчийг дарна [Зураг 16],

III. Гарч ирэх хуудасанд тухайн сорьцыны мэдээлүүдийн доор байх сорьц хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минутыг бөглөөд “Бүртгэх” товчийг дарна [Зураг 17],

IV. Шинжилгээний хариуц шинжилгээний жагсаалтаас шинжилгээ хийсэн сорьцын хойно харгалзах “Шинжилгээ хийх” (зураг дээр цэнхэр сумаар заасан) товчийг дарна [Зураг 16],

V. Гарч ирэх “Шинжилгээний хариу оруулах” [Зураг 18] хуудасыг бөглөж “+” (зураг дээр сумаар заасан) товчин дээр дарж хариуг оруулна.

Шинжилгээний жагсаалт | Шинжилгээний бүртгэл

Түүвэрлэх сонголт	Эмчилгэлийн байгуулалтын нэр:	[Сонгох]																																																																																																																													
Регистрийн дугаар:	Зүйлжлийн нэр:	Нэр:																																																																																																																													
Төрөл:	Хүйс:	[Хүйс]																																																																																																																													
Сорьцын дугаар:	Бүртгэсэн огноо:	... с [] хүртэл																																																																																																																													
Шинжилгээний дугаар:	Түүвэрлэх																																																																																																																														
Шинжилгээний Жагсаалт																																																																																																																															
<table border="1"> <thead> <tr> <th colspan="2">Илгээсэн эмчилгээ</th> <th colspan="4">Өвчтөний мэдээлэл</th> <th colspan="4">Сорьцын мэдээлэл</th> <th colspan="4">Шинжилгээний мэдээлэл</th> </tr> <tr> <th>Аймаг хот Сум/дүүрэг</th> <th>Байгууллага</th> <th>Эз/эх Нэр</th> <th>ЭЗ онош</th> <th>Голомт</th> <th>Өвчтөл Эхэлсэн №</th> <th>Сорьцын Төрөл</th> <th>Огноо</th> <th>Тээвэрлэсэн</th> <th>Хулзэн авсан</th> <th>Шинжилгээний төрөл</th> <th>Ерөнхий хариу</th> <th>Дэлгэрэнгүй хариу</th> <th>Огноо</th> <th>Лаборатор</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Улаанбаатар Баянзүрх</td> <td>Биваангирид</td> <td>Шагдар Цэрэнханд</td> <td>Томуу</td> <td>Үгүй</td> <td>2011/05/07</td> <td>101113335</td> <td>Хамрын ардас</td> <td>2011/05/09</td> <td>2011/05/08</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td>2011/05/09</td> <td>Х/А алхам</td> </tr> <tr> <td>Дархан Дархан район</td> <td>Гос хот</td> <td>гомбоксав баянзүрх</td> <td>ТТӨ</td> <td>Үгүй</td> <td>2011/04/22</td> <td>451113332</td> <td>Хоолойны ардас</td> <td>2011/05/02</td> <td>2011/05/08</td> <td>2011/05/03</td> <td>бх- гпу</td> <td>Серег</td> <td></td> <td>2011/05/04</td> <td>Ш/Х хийд</td> </tr> <tr> <td>Дархан Дархан район</td> <td>Гос хот</td> <td>гандболд гандкинүүр</td> <td>ТТӨ</td> <td>Үгүй</td> <td>2011/04/30</td> <td>451113333</td> <td>Хоолойны ардас</td> <td>2011/05/02</td> <td>2011/05/08</td> <td>2011/05/03</td> <td>бх- гпу</td> <td>Серег</td> <td></td> <td>2011/05/04</td> <td>Дархан- Уул Н/Э</td> </tr> <tr> <td>Улаанбаатар Баянзүрх</td> <td>Баянзүрх дүүргэг Н/Э</td> <td>Баянзүрх Амарбааталан</td> <td>ТТӨ</td> <td>Үгүй</td> <td>2011/05/03</td> <td>101113347</td> <td>Хамрын ардас</td> <td>2011/05/05</td> <td>2011/05/06</td> <td>2011/05/16</td> <td>бх- гпу</td> <td>Серег</td> <td></td> <td>2011/05/06</td> <td>Х/СҮТ Ш/Х хийд</td> </tr> <tr> <td>Улаанбаатар Баянзүрх</td> <td>Баянзүрх дүүргэг Н/Э</td> <td>Угийнбаяр Далгун</td> <td>ТТӨ</td> <td>Үгүй</td> <td>2011/05/04</td> <td>101113348</td> <td>Хамрын ардас</td> <td>2011/05/05</td> <td>2011/05/06</td> <td>2011/05/16</td> <td>бх- гпу</td> <td>Серег</td> <td></td> <td>2011/05/06</td> <td>Ш/Х хийд</td> </tr> <tr> <td>Улаанбаатар Баянзүрх</td> <td>Баянзүрх дүүргэг Н/Э</td> <td>Ганчимаг Эрхэмбаяр</td> <td>ТТӨ</td> <td>Үгүй</td> <td>2011/05/02</td> <td>101113349</td> <td>Хамрын ардас</td> <td>2011/05/05</td> <td>2011/05/06</td> <td>2011/05/16</td> <td>бх- гпу</td> <td>Серег</td> <td></td> <td>2011/05/06</td> <td>Ш/Х хийд</td> </tr> </tbody> </table>			Илгээсэн эмчилгээ		Өвчтөний мэдээлэл				Сорьцын мэдээлэл				Шинжилгээний мэдээлэл				Аймаг хот Сум/дүүрэг	Байгууллага	Эз/эх Нэр	ЭЗ онош	Голомт	Өвчтөл Эхэлсэн №	Сорьцын Төрөл	Огноо	Тээвэрлэсэн	Хулзэн авсан	Шинжилгээний төрөл	Ерөнхий хариу	Дэлгэрэнгүй хариу	Огноо	Лаборатор	Улаанбаатар Баянзүрх	Биваангирид	Шагдар Цэрэнханд	Томуу	Үгүй	2011/05/07	101113335	Хамрын ардас	2011/05/09	2011/05/08					2011/05/09	Х/А алхам	Дархан Дархан район	Гос хот	гомбоксав баянзүрх	ТТӨ	Үгүй	2011/04/22	451113332	Хоолойны ардас	2011/05/02	2011/05/08	2011/05/03	бх- гпу	Серег		2011/05/04	Ш/Х хийд	Дархан Дархан район	Гос хот	гандболд гандкинүүр	ТТӨ	Үгүй	2011/04/30	451113333	Хоолойны ардас	2011/05/02	2011/05/08	2011/05/03	бх- гпу	Серег		2011/05/04	Дархан- Уул Н/Э	Улаанбаатар Баянзүрх	Баянзүрх дүүргэг Н/Э	Баянзүрх Амарбааталан	ТТӨ	Үгүй	2011/05/03	101113347	Хамрын ардас	2011/05/05	2011/05/06	2011/05/16	бх- гпу	Серег		2011/05/06	Х/СҮТ Ш/Х хийд	Улаанбаатар Баянзүрх	Баянзүрх дүүргэг Н/Э	Угийнбаяр Далгун	ТТӨ	Үгүй	2011/05/04	101113348	Хамрын ардас	2011/05/05	2011/05/06	2011/05/16	бх- гпу	Серег		2011/05/06	Ш/Х хийд	Улаанбаатар Баянзүрх	Баянзүрх дүүргэг Н/Э	Ганчимаг Эрхэмбаяр	ТТӨ	Үгүй	2011/05/02	101113349	Хамрын ардас	2011/05/05	2011/05/06	2011/05/16	бх- гпу	Серег		2011/05/06	Ш/Х хийд
Илгээсэн эмчилгээ		Өвчтөний мэдээлэл				Сорьцын мэдээлэл				Шинжилгээний мэдээлэл																																																																																																																					
Аймаг хот Сум/дүүрэг	Байгууллага	Эз/эх Нэр	ЭЗ онош	Голомт	Өвчтөл Эхэлсэн №	Сорьцын Төрөл	Огноо	Тээвэрлэсэн	Хулзэн авсан	Шинжилгээний төрөл	Ерөнхий хариу	Дэлгэрэнгүй хариу	Огноо	Лаборатор																																																																																																																	
Улаанбаатар Баянзүрх	Биваангирид	Шагдар Цэрэнханд	Томуу	Үгүй	2011/05/07	101113335	Хамрын ардас	2011/05/09	2011/05/08					2011/05/09	Х/А алхам																																																																																																																
Дархан Дархан район	Гос хот	гомбоксав баянзүрх	ТТӨ	Үгүй	2011/04/22	451113332	Хоолойны ардас	2011/05/02	2011/05/08	2011/05/03	бх- гпу	Серег		2011/05/04	Ш/Х хийд																																																																																																																
Дархан Дархан район	Гос хот	гандболд гандкинүүр	ТТӨ	Үгүй	2011/04/30	451113333	Хоолойны ардас	2011/05/02	2011/05/08	2011/05/03	бх- гпу	Серег		2011/05/04	Дархан- Уул Н/Э																																																																																																																
Улаанбаатар Баянзүрх	Баянзүрх дүүргэг Н/Э	Баянзүрх Амарбааталан	ТТӨ	Үгүй	2011/05/03	101113347	Хамрын ардас	2011/05/05	2011/05/06	2011/05/16	бх- гпу	Серег		2011/05/06	Х/СҮТ Ш/Х хийд																																																																																																																
Улаанбаатар Баянзүрх	Баянзүрх дүүргэг Н/Э	Угийнбаяр Далгун	ТТӨ	Үгүй	2011/05/04	101113348	Хамрын ардас	2011/05/05	2011/05/06	2011/05/16	бх- гпу	Серег		2011/05/06	Ш/Х хийд																																																																																																																
Улаанбаатар Баянзүрх	Баянзүрх дүүргэг Н/Э	Ганчимаг Эрхэмбаяр	ТТӨ	Үгүй	2011/05/02	101113349	Хамрын ардас	2011/05/05	2011/05/06	2011/05/16	бх- гпу	Серег		2011/05/06	Ш/Х хийд																																																																																																																

Зураг 16. Ирсэн сорьцын жагсаалт

Өвчлөлийн мэдээлэл
Эмнэлзүйн онош: Томуу
Голомтолсон өвчлөлийн тохиолдол эсэх: Угүй
Өвчин эхэлсэн огноо: 2011-05-07
Шинжилгээнд авсан сорьцын мэдээлэл
Сорьц авсан эмч, сувилагчийн нэр: nivaangird_bn
Сорьцын төрөл: Хамрын арчдас
Сорьц авсан огноо: 2011-05-09 11:30:00
Сорьцыг тээвэрлэлтэнд өгсөн огноо: 2011-05-08 21:05:00
Сорьцыг хүлээн авсан огноо: 2011-08-26 ... 02 : 51
Бүртгэх [Болих]

Зураг 17. Сорьц хүлээж авах

Шинжилгээнд авсан сорьцын мэдээлэл																								
Сорьц авсан эмч, сувилагчийн нэр: Баянурх НЭ																								
Сорьцын төрөл: Хамрын арчдас																								
Сорьц авсан огноо: 2011-05-12 18:05:00																								
Сорьцыг тээвэрлэлтэнд өгсөн огноо: 2011-05-13 18:05:00																								
Сорьцыг хүлээн авсан огноо: 2011-05-29 21:55:00 ... 21 : 55																								
Бүртгэх [Болих]																								
<table border="1"> <thead> <tr> <th>No</th> <th>Лабораторийн нэр</th> <th>Шинжилгээний дугаар</th> <th>Шинжилгээний төрөл</th> <th>Шинжилгээний огноо</th> <th>Ерөнхий хариу</th> <th>Дэлгэрэн үй хариу</th> <th></th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Хан-Уул дүүрэг Э/М/Р</td> <td>11-02421</td> <td>бх-ПГУ</td> <td>2011-08-26 ...</td> <td>Хийдээгүй</td> <td>[Сонгох]</td> <td></td> </tr> <tr> <td>1</td> <td>ХӨСҮТ</td> <td>11-02421</td> <td>бх-ПГУ</td> <td>2011-05-13</td> <td>Сөрөг</td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	No	Лабораторийн нэр	Шинжилгээний дугаар	Шинжилгээний төрөл	Шинжилгээний огноо	Ерөнхий хариу	Дэлгэрэн үй хариу		1	Хан-Уул дүүрэг Э/М/Р	11-02421	бх-ПГУ	2011-08-26 ...	Хийдээгүй	[Сонгох]		1	ХӨСҮТ	11-02421	бх-ПГУ	2011-05-13	Сөрөг		
No	Лабораторийн нэр	Шинжилгээний дугаар	Шинжилгээний төрөл	Шинжилгээний огноо	Ерөнхий хариу	Дэлгэрэн үй хариу																		
1	Хан-Уул дүүрэг Э/М/Р	11-02421	бх-ПГУ	2011-08-26 ...	Хийдээгүй	[Сонгох]																		
1	ХӨСҮТ	11-02421	бх-ПГУ	2011-05-13	Сөрөг																			

Зураг 18. Шинжилгээний хариу оруулах

Зургаа. Тайлан

“Тайлан” хэсгийг бүх хэрэглэгчид ашиглах боломжтой. Энд 12 төрлийн тайлан гаргана.

а. Мэдээ өгөлт – мэдээ өгөлтийг аймаг, дүүрэг, эрхөөр харуулна

б. Толерант – 10000 хүн ам дахь өвчлөл болон дээд доод толерант босгыг харуулна

в. ТТӨ, нас - өвчлөлийн байдлыг насны ангилалаар харуулна

г. ТТӨ, 7 хоног – аймгуудийн амбулаторийн үзлэгт ТТӨ-ний эзлэх хувийг өмнөх 7 хоног мөн өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулсан байдлыг харуулна

д. ТТӨ, Өрх - өрхийн эмнэлгүүдийн өвчлөлийн байдлыг өмнөх 7 хоног, өмнөх оны мөн үеийнхтэй

харьцуулсан байдалыг харуулна

е. АЗХХ, 7 хоног – НЭ-үүдийн орны хөдөлгөөн, ТТӨ-ний эзлэх хувийг харуулна

ж. Түргэн – Улаанбаатар хотын түргэн тусlamжийн дуудлагын байдлыг харуулна

з. ТТӨ, Аймаг – ТТӨ-ны өвчлөлийн бадлыг 7 хоногоор аймагаар харуулна

и. Лаб, 7 хоног – илэрсэн вирусийг 7 хоногоор харуулна

к. АЗХХ, 7 хоног - Пневмонитой /уушигны үрэвслээр хүндэрсэн/ хэвтсэн өвчтөний хөдлөлзүйг харуулна

	A	B	C	D	E	F	G	H
1	Он	2011						
2								
3								
4								
5								
6		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
8	52						1	2
9	1	3	4	5	6	7	8	9
10	2	10	11	12	13	14	15	16
11	3	17	18	19	20	21	22	23
12	4	24	25	26	27	28	29	30
13	5	31						
14								

2011

1-р сар



л. ТТӨ, 10000 - аймгуудийн ТТӨ-ний 10000 хүн
ам дахь өвчлөлийг өмнөх 7 хоног мөн өмнөх оны мөн
үеийнхтэй харьцуулж харуулна

м. Лаб, Аймаг - илэрсэн вирусийг аймгаар
харуулна

Эпидемиологийн 7 хоногийг тодорхойлох

Мэдээ оруулахдаа голдуу алдаг зүйл бол
эпидемиологийн долоо хоногийг тодорхойлох байдаг.
Үүнийг олон улсад тогтоосон журмаар (дэлгэрэнгүйг
http://en.wikipedia.org/wiki/ISO_8601 хаягаар орж
үзнэ үү) тооцохийн тулд <http://www.flu.mn/mgl/callendar.xls> хаягаар орж "callendar.xls" файлыг татаж авч
долоо хоногийг тооцно. Программыг ашиглахдаа

1. "callendar.xls" файлыг нээнэ,

2. "Он" хэсэгт оноо оруулж компьютерийн
гаран дээрээс "Enter" товчийг дарна. Ингэхэд тухайн
оны календарь гарна. Эхний багана долоо хоногийн
тоо[Зураг 19].

Зураг 19. Эпидемиологийн 7 хоногийг тодорхойлох

* * *

АУДИО ХУРАЛ ХИЙХ ЖУРАМ

Л.Энхбаатар, П.Нямдаваа

Монгол-АНУ-ын "Томуу тандалтын сүлжээ бэхжүүлэн хөгжүүлэх" төслийн баг

2010 оноос интертэд суурилсан томуугийн мэдээлийн систем (ИСТМС)-ийг нэвтрүүлж эхлэхэд гарч байсан бэрхшээл бодит хугацаанд шийдвэрлэх үүднээс намайг төслийн баг Skype тогтолцоог ажилгаа ТХТН-үүдтэй аудио-хурал зохион байгуулж эхэлсэн

билээ. Цаашид бид энэ аудио-хурлаа үргэлжлүүлэх, бусад халдварт өвчний тандалт, дархлаажуулалын ажлын явцыг энэ тогтолцоогоор харилсан мэдээлж байх журамд шилжих зорилт тавьж байгаа юм.

Хурлын дэг

1. Аудио хурлыг *Skype messenger* ашиглаж явуулна.
2. Хурал эхлэхээс 10 минутын өмнө ТХТН-үүд *Skype* -д орсон байна.
3. ТХТН-үүд хуралдааны өөрийн талын оролцогчдын ахлагчийг сонгосон байна.
4. Хурлын явцад оролцогчид мэдээлэл хийх, асуулт, хариулт өгөхөөс бусад үед микрофоноо **mute** эсвэл **off** горимд байлгана.
5. ТҮТ-ийн хурал даргалагч хурлыг нээж хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулна.

6. ТҮТ-ийн хурал даргалагч ТҮТ-өөс оролцогчдыг танилцуулсны дараа ТХТН-үүдээс оролцогчид хурал даргалагчийн асуусан дарааллаар өөрийн болон бусад оролцогчдын нэр албан тушаалыг танилцуулна.
7. Дүүргүүдэд ЭМН, НЭ, аймгуудад ЭМГ, НЭ-үүд, Өрхийн эмнэлгийн төлөөлөл нэг газраас холбогдоно.
8. Мэдээлэл хийх, асуух, хариулах, буюу санал хэлэхдээ ярьж буй хүнийг дуустал хүлээгээд дараа нь өөрийнхөө нэр, албан тушаалаа хэлж, товч бөгөөд тодорхой ярина. Ярьж дуусаад “**миний хэлэх юм дууслаа**”, “**асуулт дууслаа**” гэж мэдэгдэнэ.
9. Ярьж буй хүн микрофонд ойртоож 5 см-ээс холгүй зйтай ярих ба ярьж байхдаа микрофонд хүрэхгүй байх шаардлагатай.
10. Техникийн шалтгаанаас болж тасалдал гарсан тохиолдолд ТҮТ-ийн дата менежер/вэб мастер Б. Ганцоожтой утсаар холбогдож (утас: 91998239) эргэн холбогдоно.
11. Асуулт, танилцуулгаа хурлын явцад *Skype messenger*-ийн **share**, **send file** командыг ашиглан мэдээлж болно.

2011-2012 оны томуугийн улиралд баримтлахаар санал болгож буй хурлын хэлэлцэх асуудлын үлгэрчилсэн төлөвлөгөө дэг, хуваарийг Хүснэгт 1 ба 2-оос үзнэ үү.

Хэлэлцэх асуудлын үлгэрчилсэн төлөвлөгөө

Хүснэгт 1

Хэлэлцэх асуудал	Хариуцах	Хугацаа
Оролцгэсэн бүртгэл, танилцуулга	Л.Энхбаатар	10 минут
Интэрнэтэд сууринсан тандалтын мэдээллийн систем (ИСТМС)-ийг ашиглаж Томуугийн харуулдан тандалтын нэгж (ТХТН)-үүдийн мэдээ өгсөн байдал	Б.Ганцоож	10 минут
ТТӨ-ий өвчлөлийн байдал, цаг үеийн мэдээлэл	А.Бурмаа	10 минут
Холбогдсон ТХТН-үүдээс ирүүлсэн болон өмнөх 7 хоногт ирсэн сорьцонд лабораторийн шинжилгээ хийсэн тухай мэдээлэл	Б.Дармаа	10 минут
ТХТН-үүдээс асуулт асуух, санал хэлэх	оролцогчид	Хүн бүр 3 минут хүртэл
Дүгнэлт	Л.Энхбаатар	5 минут

№	Оролцох аймаг , сум хот дүүрэг	Сар бүрийн 1-р долоо хоног	Сар бүрийн 2-р долоо хоног	Сар бүрийн 3-р долоо хоног	Сар бүрийн 4-р долоо хоног	ТХТН-үүдээс оролцох мэргэжлийнүүд	ТҮТ-өөс оролцох мэргэжлийнүүд
1	Улаанбаатар хотын амбулагорид сууринсан (өрхийн эмчилгүүд) 23 НӨЭЖ	Лхагва гаригт, 13.00-14.00 цагт				Өрхийн эмч бусад эмч сувилаач нар	А.Бурмаа, Б.Дармаа, Л.Энхбаатар, Б.Ганцожж, Ц.Оюунчимэг
2	Улаанбаатар хотын эмнэлэгт сууринсан тандалтын нэлжүүд (лавлагатай төв, дүүргийн ЭМН, НЭ 22 нэлж	Лхагва гаригт, 14.00-15.00 цагт				Лавлагатай төвийн тандалтын багийн ахлагч дүүргийн ЭМН, НЭ-ийн халдаар судлаач дун бүртгэгч эмч, бусад эмч, сувилаач нар	А.Бурмаа, Б.Дармаа, Л.Энхбаатар, Б.Ганцожж, Ц.Оюунчимэг
3	Хэнтий, Дорнод, Сүхбаатар,Дундгovi, Өмнөговь, Төв, Говь- Сумбэр, Дорноговь	Лхагва гаригт, 14.00-15.00 цагт				Аймийн ЭМГ, НЭийн халдаар судлаач, дун бүртгэгч эмч, бусад өрхийн эмчилгүүний төвлөөлгүүд	А.Бурмаа, Б.Дармаа, Л.Энхбаатар, Б.Ганцожж, Ц.Оюунчимэг
4	Булган, Орхон, Архангай,Өвөрхангай, Хөвсгөл, Дархан-Уул, Сэлэнгэ			14.00-15.00 цагт		Аймийн ЭМГ, НЭйн халдаар судлаач, дун бүртгэгч эмч, бусад өрхийн эмчилгүүний төвлөөлгүүд	А.Бурмаа, Б.Дармаа, Л.Энхбаатар, Б.Ганцожж, Ц.Оюунчимэг
5	Ховд, Баян-Өлгий, Ус, Завхан, Говь-Алтай, Баянхонгор				14.00-15.00 цагт	Аймийн ЭМГ, НЭйн халдаар судлаач, дун бүртгэгч эмч, бусад өрхийн эмчилгүүний төвлөөлгүүд	А.Бурмаа, Б.Дармаа, Л.Энхбаатар, Б.Ганцожж, Ц.Оюунчимэг

Жич: Овчлөл ихэссэн, дэгдэлт гарсан үед энэ хуваарийг урьдчилсан тохиорлоод өөрчилж болно.

**2011-2012 ОНЫ ТОМУУГИЙН УЛИРАЛД ТХТН-ҮҮДИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

P.Туул, Б.Дармаа, Б.Ганцоож, П.Нямдаваа

Монгол-АНУ-ын "Томуугийн тандалтын сүлжээг бэхжүүлэн хөгжүүлэх" төслийн баг

ТХТН-үүдийн 2011/2012 оны томуугийн тандалтын улиралын бүрийн үйл ажиллагааг дүгнэхдээ мэдээ ирүүлсэн хувь, илрүүлсэн вирусийн тоо, сорьц ирүүлсэн хувь, вирус илрүүлсэн хувь, өмнөх оны

дүн, аудио хуралд оролсон байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдээр [Хүснэгт] 1 0-5 оноо өгч, онооны дундажийг гаргана. Бүтэн жилийн үнэлгээг хийхдээ 4 улирал тус бүрт авсан онооны дундажийг гаргана.

Хүснэгт 1

Үнэлгээний хамралт

	Шалгуур	I зэрэглэл	II зэрэглэл	III зэрэглэл
1	Мэдээ өгөлт			
2	Аудио хуралд ороцсон байдал			
3	Өмнөх оны үнэлгээ			
4	Сорьц ирүүлсэн хувь			
5	Вирусийн тоо			*
6	Вирус илрэлтийн хувь			*

* сорьц ирүүлээд вирус илэрсэн тохиолдолд энэ шалгуурыг ашиглана

Оноо өгөх журам:

1. Мэдээ өгөлт, мэдээг хугацаанд нь өгвөл - 5 оноо

Хоцорч өгвөл - 2,5 оноо улиралын эшэст мэдээ өгөлтийн оноог:

$5x \text{ "Хугацаандаа өгсөн тоо"} + 2.5x \text{ "Хоцорч өгсөн тоо"} / \text{өгвөл зохих мэдээний тоо}$
гэсэн томъёогоор бодож гаргана.


2. Аудио хуралд оролсон байдал оноог:

$5x \text{ "Хугацаандаа орсон тоо"} + 2.5x \text{ "Хоцорч өгсөн тоо"} / \text{орвол зохих тоо}$
гэсэн томъёогоор бодож гаргана.

3. Бүртгэгдсэн өвчлөлийн 40%-60%-аас сорьц авсан байвал хамгийн оновчтой байх алгоритмаар сорьц ирүүлсэн хувийг:


Ирүүлсэн сорьтой тоо/ өвчлөх x 100%
томъёогоор бодож олно. Гарсан хувиар нь доорх оноог өгнө [Зураг 1]

[0.0, 4.3[0 оноо
[4.3, 9.2[1 оноо
[9.2, 14.8[2 оноо
[14.8, 21.1[3 оноо
[21.1, 28.4[4 оноо
[28.4, 36.8[5 оноо
[36.8, 46.3[4 оноо
[46.3, 57.1[3 оноо
[57.1, 69.6[2 оноо
[69.6, 83.8[1 оноо
[83.8, 100.0]	0 оноо



Зураг 1 Сорьц авалтын оновчтой хувийн график

4. Вирусийн тоо, Вирус илрэлтийн хувь
Энэ 2 үзүүлэлтийн оноог өгөхдөө ижилхэн аргыг
хэрэглэв.




max – хамгийн их утга, min – хамгийн бага утга,
d – завсарын урт,
 $d=(\text{max}-\text{min})/5$

[min, min+d[1 оноо
[min+d, min+2d[2 оноо
[min+2d, min+3d[3 оноо
[min+3d, min+4d[4 оноо
[min+4d, max]	5 оноо

5. Эзэлсэн байр ахисан байдлыг жилийн дүн гаргахад ашиглана.

Улирал бүр байр ахиж байсан бол нэмэлт оноо өгнө. Үүнд: Өсөлтийн коэфицентын таигенсийг ашиглана Зураг 2.

Энд: Өсөлтийн өншгийн коефицент – $\text{tg}(-)$



Зураг 2. Үйл ажиллагааны ахицыг тоолох график

Ерөнхий зарчим баримтлана хүснэгт 2

Хүснэгт 2

ТХТН-үүдийн үйл ажиллагааны үзүүлэлтийн зэрэглэл

Эмнэлэг	байр	оноо
Өрхийн эмнэлэг	I	3.50-5.00
	II	2.50-3.49
	III	2.10-2.49
Нэгдсэн эмнэлэг	I	4.00-5.00
	II	3.00-3.99
	III	2.50-2.99
Паввлагаа төв	I	3.50-5.00
	II	2.50-3.49
	III	2.10-2.49

ТОМУУГИЙН ТУХАЙ

(Эрүүл мэндийн сурталчилгаанд ашиглахад зориулсан зөвлөмж)

Томуу нь вирусээр үүсгэгдэг хүнд халдварт бөгөөд түүнд эрэгтэй, эмэгтэй, бүх насны хүүхдүүд болон үндэстнүүд өртөнө. Томуу үхлийг дагуулдаг, ялангуяа бага насны хүүхэд, ахмад настнуудын нас баралт өндөр байдаг. Жил бүр хүйтний улиралд томуугийн тахалт тархалт тохиолдлог бөгөөд дэлхийн бөмбөрцөгийн хүн амын 15% хүртэл өртдөг байна. Томуутай ойролцоо шинж тэмдгээр илэрдэг олон олон төрлийн бусад вирусээр үүсэх халдварт мөн байх тул тэдгээрийг томуу-төст өвчин (ТТӨ), эсвэл амьсгалын замын цочмог халдварт (АЗЦХ) гэдэг. Томуу, томуут төст өвчин нь үечлэн давтагдаж, бид ойролцоогоор амьдралынхаа нэг бүтэн жилийг энэ өвчинөөр өвчиж өнгөрөөдөг гэж судлаачид тооцоолжээ.

Яж халдварлах вэ?

Томуугийн вирус маш амархан халддаг. Халдварт дамжуулах хамгийн түгээмэл зам – агаар – дусал. Түүнчлэн ахуйгаар дамжуулах зам (ховор боловч) байж болох юм, тухайлбал – эд хэрэгслээр. Хоногийн туршилхунойролцоо 15000 лагаараарамыгслаж, түүнд агуулагдаж байгаа микробыг шүүх ба тэд эпителийн эсийн гадаргуу дээр бууна. Агаар нь халдвартай өвчтөн болон тээгчдийн тараасан эмгэгтөрүүлэгч бактери, вирусээр бохирдсон үед л аюултай. Ханиах, найтаах, ярихад өвчтөн, вирус тээгчийн хамар залгиураас шүлс, салс, цэрээр эмгэгтөрүүлэгч бичил биетнүүд, тэдгээрээс томуугийн вирус цацагдана. Богино хугацаанд өвчтний эргэн тойронд вирусээр дээд зэрэгээр бохирдсон агаарын тоосонцорын хэсгүүд халдвартай бүс буй болгоно. Тоосонцорын хэсгүүдийн хэмжээ 100 мкм илүү нь (том дуслын давхраа) түргэн доош бууна. Алсад цацагдах нь 2–3 метрээс хэтрэхгүй.

Томуугийн вирусийн бөөгнөрөлийн зэрэг болон түүний агаарт жингүйдлийн байдалд байх хугацаа нь юуны өмнө тоосонцорын хэсгийн хэмжээнээс хамаарна. Энэ хэмжээ нь ярих, ханиах, найтаах зэрэг физиологийн үйлдлийн давтамж, хүчээр тодорхойлогдоно. Энэхүү баримт нь томуу, амьсгалын замын эрхтэний өвчтэй хүн ариун цэврийн сурталчилгааны дагуу эрүүл ахуйн жирийн ёсыг биелүүлэх хэрэгтэйг нотлож байна. Өвчтөн амаа дарж байгаад найтаахад агаарт цацагдах агаарын тоосонцорын хэсгүүд 10 – 100 дахин цөөрч болох бөгөөд тэгвэл агаарт томуугийн вирусийн бөөгнөрөл буурах төдийгүй цацагдаж буй агаарын тоосонцорын хэсгүүдийн 80% -ийнх нь хэмжээ 100 мкм – ээс дээш байна гэж тооцвол тэдгээр нь доош түргэн бууж өвчтөний эргэн тойронд ойрхон байгаа хүмүүст халдахыг багасгана.

Вирусний хэсгүүд халдвартасны дараа амьсгалын замын эпителiid саатна. Ер нь хамрын салст бүрхүүлийн эс, хоолой, амьсгалын зам вирусийг "шүүрдэн" халдвартыг зайлцуулна. Гэвч зарим тохиолдолд вирусийн хэсгүүд шууд уушгины цулцанд орж, бие махбодын анхны хамгаалах механизмаас зайлсхийнэ. Амьсгалын замд вирус гемаглютинини тусламжтайгаар эсэд бэхэлгэдэнэ. Фермент нейраминидаз эсийн мемброн салстыг гэмтээж вирус эсэд оруулах (эндоцитоз) замаар эсийн дотор орно. Дараа нь вирусийн РНХ эсийн цөмд нэвтэрнэ. Үүний дүнд эсэд амьдралын үйл ажиллагааг алдагдуулах үйл явц болох ба тэр өөрөө өөрийн нөөцийг ашиглан вирусийн уургийг үйлдвэрлэж эхлэнэ. Вирусийн РНХ хувирал (репликация) нэгэн зэрэг явагдаж, вирусийн хэсгүүд цугларна. Шинэ вирусүүд чөлөөлгөн (эсүүдэд сүйтгэл нэгэн зэрэг явагдаж, түүний уусалт болно) өөр эсийг гэмтээнэ.

Томуугийн шинж тэмдэг

Томуу – цочмог, өндөр халдвартамтгай чанартай өвчин бөгөөд хурцхордлого, дундзэргийн салсталттай, мөгөөрсөн хоолой, томоохон гуурсанцарыг нилээд өрчимтэй гэмтээх онцгой шинж тэмдэгтэй.

Янз бүрийн вирусээр үүсгэгдсэн томуу ба амьсгалын замын эрхтэний цочмог өвчний эмнэл зүй нь хорлогын шинж тэмдэг нь ижил төстэй, амьсгалын замын эрхтэнийг гэмтээдгүй тул олон төсөөтэй төрхтэй байдаг.

Ер нь томуу цочмог эхэлдэг. Нууц үе нь 1-2 өдөр, заримдаа 5 өдөр хүртэл үргэлжилж болно. Дараа нь эмнэлзүйн цочмог үе эхэнэ. Өвчний явц олон хүчин зүйлээс хамааралтай: Эрүүл мэндийн ерөнхий байдал, нас, өмнө нь тухайн хэв шинжийн вирусээр үүссэн өвчтэй өвчтөнтэй хэлхээ холбоотой байсан эсэхээс хамаарна. Үүнээс хамаарч өвчтөн томуугийн эмнэлзүйн явцын 4 хэлбэр: хөнгөн, хүндэвтэр, хүнд, хэт хорлогот хэлбэрүүдийн аль нэгээр нь өвдөнө. Шинж тэмдэг нь өвчний хүнд, хөнгөнөөс хамааран хүчтэй, сул илэрнэ.

Томуугийн хөнгөн хэлбэрийн үед (далд, эмнэлзүйн дэд хэв шинжийг оролцуулаад) биеийн халуун хэвийн буюу 38°C хэмээс хэтрэхгүй, халдварт хорлогын шинж сул илэрсэн, эсвэл огт илрэхгүй.

Томуугийн хүндэвтэр хэлбэрийн үед (тодорхой) халуун 38,5-39,5°C хүртэл нэмэгдэх ба өвчний сонгодог шинж тэмдэгүүд илэрнэ:

о Хордлого

- Их хөлрөх
- Бие сулрах;

- Нүд гялбах;
- Үе мөч, булчин өвдөх;
- Толгой өвдөх;

о Салст үрэвсэх шинж тэмдэгүүд

- Зөөлөн тагнайн улайлт залгиурин ар тал үрэвсэх;
 - Нүд улайж үрэвсэх;
- о Амьсгалын замын шинж тэмдэгүүд
- Төвөнх болон мөгөөрсөн хоолой үрэвсэх ;
 - Хуурай, хөндүүрлэн ханиалгах (Хэд хэдэн тохиолдолд - чийглэг);
 - Хэлсэн үгийн дуудлагыг алдагдуулах;
 - Цээжээр өвдөх;
 - Шуухниа (хамрын ханиад);
 - Улайлт, хөхрөлт, хамрын хөндийн салст болон залгиур хуурайших.

о Үүшгини сегмент үрэвсэх хам шинж - Хөдлөлзүйн өрнөлт (хэдхэн цагийн турш) үүшиг-зүрхний дутлын үед аль нэг үүшгини сегмент сүүдэртэй байх нь хэвийн зүйл, эмнэлзүй-рентген зурагт харагдах өөрчлөлт (бодит ул мөр үлдэхгүй) нь 2-3 өдөрт шийдвэрлэгдэнэ. (үүшгини хатгаанаас ялгаралгдах ялгаа нь) Их хордлогот хэлбэрийн үед үүшиг хавагнах, ер нь цус харвах хатгаагаар төгсөж болох юм.

о Гэдэсний хам шинж:

- Гэдэс хөндүүрлэх,
- Суулгалт (Диарея) – Ховор тохиолдох боловч ёс юм шиг бусад халдварын шинж байдаг. Тэрчлэн томуугийн вирусээр огт сэдээгдээгүй мөртөө “ходоодны томуу” гэж нэрлэгдэх тал бий.

Томуугийн хүнд хэлбэрийн үед биеийн халуун 40-40,5°C хүрнэ. Нэмэлт шинж тэмдэг: томуугийн хүндэвтэр хэлбэрийн үеийн онцгой шинж тархины үрэвсэлт эмгэг “энцефалопатии” (сэтгэл хямрах, татааж унах, хий юм үзэх сонсох), судасны өөрчлөлт (хамраас цус гоожих, зөөлөн тагнайд цэгчилсэн цус харвах) болон бөөлжих.

Томуугийн гипер хордлогын үед ялангуяа эрсдэлт бүлгийн өвчтнүүдэд нас баралтад хүргэх аюул бий болдог. Томуугийн энэ хэлбэр нь өөртөө (дээр дурдсанаас гадна) дараах илрэлүүдийг агуулдаг:

- Өндөр халуурах
- Менингит (тархини зөөлөн бүрхүүл талаас баттай үрэвсэлт өөрчлөлт байхгүй үед менингитийн ганц нэг буюу хослосон шинж тэмдэг).
- Тархини үрэвсэлт эмгэг

(Энцефалопатия) хүүхдийн цусны хөдлөлзүйн өөрчлөлттэй (мэдрэл хордлого-нейротоксикоз гэсэн нэр томьёо) хавсрах нь томуугийн хүнд хэлбэрийн үеийн нас баралтын зонхилох шалтгаан болдог;

• Хавант цусархаг хам шинж бий болох, янз бүрийн зэрэглэлийн амьсгал дутлын шинж илрэх, үүшиг хавагнах (цус харвалтат хатгаа), мөн түүнчлэн

зарим өвчтөнд тархи хавагнах хүртэл.

Хэрэв томуу хүндрэлгүй явагдвал, халууралтын үе 2-4 өдөр үргэлжлэх ба өвчин 5-10 хоногт дуусна. Бактерийн болон амьсгалын замын бусад вируст халдвар давхардсан үед дахин халуурч болно. Томуугаар өвчилсний дараа 2-3 долоо хоногийн туршид халдварын дараах үзэгдэл бие сулавтар байх (астении): ядрах, бие сулах, толгой өвдөх, цухалдах, нойргүйтэх болон бусад шинж тэмдэгүүд илэрнэ.

Томуугийн хүндрэл, үр дагавар

Амьсгалын хоолойд томуугийн вирус үржин, амьсгалын замыг тоос шороо, бактериа гэх мэт бусад зүйлээс цэвэрлэх үүрэгтэй сүүмэлзэх хөдөлгөөнт хүчүүр эд (мерцательного эпителия)-ийг устгахад хүргэнэ. Хэрэв сүүмэлзэх хөдөлгөөнт хүчүүр бүрхүүл устгагдвал тэр өөрийн хамгаалах үүргээ бүрэн гүйштэгж чадахгүйгээс үүшгиннд бактерит их хэмжээгээр хялбархан нэвтрэх болно. Иймд бактерит давхар халдвар(суперинфекции) гарах аюултай.

• Томуугийн нилээд элбэг тохиолдох хүндрэл нь үүшигни хатгаа байдаг бөгөөд энэ нь хоёрдогч бактерит халдвар (*Streptococcus pneumoniae*, *Haemophilus influenzae*, *Staphylococcus aureus*-ээр үүсгэгдсэн). Хам халдвар (вируст болон бактерит үүшигни хатгаа) нилээд ховор тааралдана. Анхдагч вируст үүшигни хатгаа – энэ ховор хүндрэл, үхэл өндөртэй. Хэрэв томуугийн хоруу чанар өндөртэй вирусээр үүссэн бол тэр тохиолдоно. Үүнд цус харвалтат үүшигни хатгаагаар “агшин зуур” үхэх, 2-3 өдрөөсөө хэтрэхгүй. Зүрх, үүшигни архаг өвчтэй, үүшигнд цус тогтоонгошил бүхий өвчтнүүдэд юуны өмнө анхдагч томуугаас үүдэлтэй үүшигни хатгаа ажиглагдаж болно.

• Бусад хоёрдогч бактерит халдвар ихэвчлэн томуугийн дараа үүсдэг – шуухинаа, хамрын хөндийн үрэвсэл, гуурсан хоолойн үрэвсэл, чихний хөндийн салст бүрхүүлийн үрэвсэл.

• Рейе хам шинжээр илрэх хүндрэл нь бараг зөвхөн хүүхдэд тохолдог бөгөөд (үндсэндээ В вируст томуугаар өвчилсний дараа) салицилатэм хэрэглэсний дараа (тухайлбал ацетилсалицилын хүчил) хүчтэй бөөлжих, тархи хавагнаснаас оврого (ком)-д оруулж болно.

• Ахимаг насыханд зүрх-судасны талаас хүндрэл элбэг тааралдана. Миокардит, перикардит (зүрхний булчингийн үрэвсэл нь зүрхний дуталд хүргэж ч болох юм).

• Томуугийн В хэв шинжээр өвчилсний дараа булчингийн үрэвслийн хүндрэл миозит болон бусад булчингийн өвчтнүүдээр илэрч болно. Тийм хүндрэл ихэвчлэн хүүхдэд тохолдох бөгөөд хэдэн өдрийн туршид булчин өвдөнө. Түүнчлэн шээсэнд миоглобина нэмэгдэж (миоглобинурия), бөөрний үйл ажиллагааны цочмог алдагдалд оруулж болно.

- Заримдаа нугасны хөндлөн хэсгийн үрэвсэл (миелит) тохиолддог.
- Менингит, энцефалит.
- Бактерт давхар халдварт (суперинфекция). Томуугаар өвчилж бие махбод сулрахад бактерит халдварт давхарлах нь элбэг (пневмококковая, гемофильная, стафилококковая).
- Томуугаар өвчилсний дараа архаг өвчинүүд сэдэрч дахих нь их ажиглагддаг. Үүнд: Ушигний гуурсан хоолойн багтраа, архаг мэнгэр, зүрх-судасны өвчин, бодисын солилцоо алдагдах, бөөрний өвчин гэхчилэн бусад.

Эмчилгээ, сэргийлэг

Ерөнхий эрүүл ахуйн хэрэглэгдэхүүн:

Нилээд түгээмэл хямд төсөр хэрэглэгдэхүүний нэг бол амны хөвөн самбайгаар хийсэн хаалт (маска). Чухамхүү энэ нь халдварт өвчний үед өвчтний ойр тойрныхон өөрсдийгөө халдвараас хамгаалахад үр дүн дутмаг арга юм. Бөхир гараар халдварт дамждагийг санах хэрэгтэй.

Тусгай ажиглалтаар өдөрт гар 300 дахинаас барагай удаа хамар, нүднээс ялгарч гарах зүйлтэй болон шүлстэй хавьтал болдогийг тогтоосон байна. Гар барих, хаалганы бариул, бусад эд зүйлээс вирус эрүүл гарти шилжиж, тэндээс хамар, нүд, аманда ордог байна. Ядаж тахалт тахлын үед гар барихаас татгалзахыг зөвлөсөн. Гараа байнга угаах, ялангуяа өвчтэй байхдаа буюу өвчтөнг асарч сувилахдаа гараа заавал угааж байх хэрэгтэй.

Томуу болон бусад АЗЦХ –аас урьдчилан сэргийлэхэд халдварын эх уурхайтай хавьтал болох тоог цөөлөх нь чухал, энэ нь ялангуяа хүүхдэд чухал юм. Хотын нийтийн тээврийг идэвхтэй ашиглах, бие биенийдээ зочлох зэргийг зөвлөхгүй. Хүүхдийг цэвэр агаарт аль болох их гаргаж байвал томуу бараг халдварлахгүй.

Биений эсэргүүшлийг сайжруулах арга хэмжээ

1. Чийрэгжүүлэх - Амьсгалын замын халдвараас сэргийлэх чухал арга хэмжээ (харин томуу биш бол манай орны уур амьсгалын сэргүүтэр агаар амьсгалын замын үйл ажиллагааг хэвийн болгож бие махбодод халдварласан вирусийн тунг багасгана. Иймд чийрэгжүүлэх замаар ханиад шуухинааг бүрэн биш ч гэсэн гэтлэн давах, хүүхэд түнэд мэдрэг байхыг багасгах боломжтой.

2. Нэмэлтээр аскорбины хүчил, поливитамин хэрэглэх хэрэгтэй. Аскорбины хүчил (витамин C) нь эсэлдэх, нөхөн сэргээх үйл явц, нүүрс усны солилцоо, цусны бүлэгнэлт, нэхмэл эдийн нөхөн төлжилтиг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Бие махбодын эсэргүүшлийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлдэг нь аскорбины хүчлийн антиоксидант шинж чанартай холбоотой. Витамин C-г өдөрт 0,5-1 граммыг 1-2 удаа

ууж хэрэглэнэ. Эсгэсэн байшаа, түүнчлэн жүржийн нимбэг, киви, мандарин, апельсин, грейпфрут зэрэгт нилээд их хэмжээгээр байдгийг тэмдэглэх нь зүйтэй. Шинэ байцаагаар наранцэцгийн тостой хийсэн салатанд витамин бичил эрдэст бодисууд их агуулагдаж байдаг тул хэрэглэхэд ашигтай.

3. Сармис – томуугийн тахалт тархалт болон ханиад тархаж байгаа үед урьдчилан сэргийлэхээр өдөр бүр 2-3 хумсыг хэрэглэнэ. Амнаас бактерийг бүрэн цэвэрлэхэд нэг хумс сармис хэдхэн минут жажлахад хангалттай. Тэрчлэн сонгино хэрэглэхэд эерэг үйлчилгээтэй.

4. Өдөр бүрийн хоолны тодорхой хувьд нь шинэ ногоо, жимс хэрэглэвэл вируст өвчний эсрэг биений дархлааг дээшлүүлэх боломжтой. Мөн түүнчлэн эм хэрэглэхэд зарцуулах зардалтай харьцуулахад гэр бүлийн зардлыг үлэмж хэмжээгээр хөнгөвчлөх болно.

Нэмэгдэл арга хэмжээ

Хамар цэвэрлэх: Амьсгалаар хамрын хөндийд орсон гадны биетийг цэвэрлэн өдөрт 2 удаа савандаж угааж байх. Хоолойгоо марганцийн уусмал, фурациillin, содын уусмал, хамба шарилжийн уусмалаар зайллах. Хамрын хөндийг сонгино зөгийн балтай (сахар) хандаар дусааж угаах. Жор нь: жижиг саванд 50 мл бүлээн усан дээр маш сайн жижиглэж хэрчсэн сонгиныг хоолны халбагаар 3 хийж, цайны халбаганы S зөгийн бал (сахар) нэмээд 30 минут байлгана. Хамрын салстад саримс, сонгины тосон хандны түрхлэг хийх. Жор нь: ургамлын тостой шилэн саванд буцамгай ус хийж 30 – 40 минут байлгаад 3-4 хумс саримс болон j-d нь жижиглэж хэрчсэн сонгино хийгээд тосон бэлдмэлээ 2 цаг байлгахад царцана.

Уураар утас. 300 граммын саванд ус хийж 2–3 минут буцалгаад эвкалиптийн ханднаас 30 – 40 дусал нэмэх буюу төмсний хальс 2–3 халбага эсвэл цайны халбаганы S sod хийнэ. Горчицтай бүлээн усанд хөлөө 5–10 минут дүрж байлгах, дараа нь хөлийн уландаа тос түрхээд халуу дүүгтэл үрж тосоо шингээх.

Уух.

Нохойн хошууны ундаа. Хуурай нохойн хошууны жимсийг нүдэж нунтаглах. 1 литр хүйтэн усанд 5 хоолны халбага нунтагласан жимс хийж 10 минут буцалгана. Түүнийгээ 8–10 цаг хучиж тавиад шүүж тунгаана. Өглөөд 1 стакан ууж, өдөржин 2–3 цагийн зйтай ууна. Зөгийн бал, варенье, сахартай ууж болно. Нохойн хошууны хандыг долоо хоногийн турш уухдаа аажмаар уултын тоог цөөлөх нь зүйтэй.

Далдуу мод, морин улааганатай ханд. Холимогийг бэлтгэхдээ дараах харьцааг ашиглах: далдуу модны цэцэг – 1 хэсэг, морин улааганы үр – 1 хэсэг тус тус холиод 2 хоолны халбага холимогийг 2 стакан буцалсан усанд найруулж, 5 – 10 минут тунгаана. Шөнө халуунаар нь 1 – 2 аяга ууна.

Ердийн бөөрөлзгөнө. Янз бүрийн цуглуулгыг

тусгайлан хэрэглэдэг. Бөөрөлзгөний шүүс сахартай - өндөр халуунтайд уухад сайн сэргээнэ. Хуурай үрийн ханд. 1 хоолны халбага хуурай үрийг стакан халуун усанд 20 минут байлгаж хандлана. Стаканаар хандыг халуунаар өдөрт 2 удаа ууна.

Бөөрөлзгөнөтэй далдуу мод. Бөөрөлзгөнө, далдуу модны цэцгийг тэнцүү хэмжээгээр хольж бэлтгэнэ. Стакан усанд хоолны халбага холимогийг хандалж, 20 минут тавьж хөргөнө. Стаканаар хандыг халуунаар нь шөнө хөлөргөхөөр ууна.

Зөгийн балтай бөөрөлзгөнө: 1 хоолны халбага зөгийн бал, 1 хоолны халбага нохойн хошуу, 1 хоолны халбага бөөрөлзгөнө, 1 хоолны халбага үхрийн нүдийг 100 мл буцалсан усанд хийж, 15 минут байлгана. Өдөрт 3 удаа хоолны өмнө хагас стаканыг ууна.

Зөгийн цавуу – Зөгийн цавууны 1–2 буурцагийг амандаа хийж, хаяа хэлээрээ татаж нэг талаас нөгөө талруу нь хөдөлгөнө. Зөгийн цавуутай спиртэн хандыг ётонд шингээж хэрэглэж болно.

Жодооны тос. Томуу, амьсгалын замын цочмог өвчин, амьсгалын замын цочмог вируст халдварт, уушгины үрэвсэл, гуурсан хоолойн үрэвсэл болон бусад ханиад шуухинаа (нэн ялангуяа хүүхэд) хүрсэн үед иллэг хийхдээ жодооны тос түрхэх, углага хийхэд хэрэглэнэ. Цээж, нуруу, хөлийн улана рефлексийн цэгүүдэд иллэг хийхдээ жодооны тос түрхэж хэрэглэнэ. Хоногт 4–6 цагийн зайдайгаар рефлексийн цэгүүдэд тос түрхэлтийг 4–5 удаа хийнэ. Өвчтөнд хийсэн түрхлэг бүрийн дараа бигнүүрийн цаасаар ороож ваадагнаа.

Эм хэрэглэгдэхүүн

Үрьдчилан сэргийлэх эм бэлдмэл

Томуугаас үрьдчилан сэргийлэх эм хэрэглэгдэхүүн өнөөдөр өргөн сонголттой байна. Гэвч үрьдчилан сэргийлэх ижил төстэй эм хэрэглэгдэхүүнүүд хангалттай үр дүн үзүүлж чадахгүй байгаа, тэдгээр эм бэлдмэлийн дийлэнх нь томуугийн А вирусийн хувьд үр дүнтэй харин В вируст үр дүнгүй байна. Үүн дээр нэмэхэд олон эм бэлдмэлд хэрэглэхийн эсрэг заалттай жагсаалтанд орсон бодис их байдаг бөгөөд ташрамын урвал үүсгэж ч болзошгүй байна.

Вирусийн эсрэг эм бэлдмэлүүд томуугаас үрьдчилан сэргийлэх ач холбогдоор томуугаас сэргийлэх вакцинжуулалтын дараа орж байгаа нь дараах шалтгаантай:

- Биологийн шалтгаан: Вакцин бол эсрэг биеийн болоход нөлөөлж, түүнийг үйлдвэрлэн бүтээдэг нилээд үр дүнтэй бөгөөд жинхэнэ вирусийн эсрэг бодис юм.

- Анагаах ухааны шалтгаан: Томуугаас үрьдчилан сэргийлэхэд тахалт тархалтын туршид вирусийн эсрэг эм бэлдмэл өдөр бүр хэрэглэхэд дор хаяж 6 долоо хоног ташрамын гаж нөлөө болон үл нийцэх эрсдэлтэй.

- Эдийн засгийн шалтгаан: нэг тун вакцины үнэ 6 долоо хоног үнэтэй эм хэрэглэхээс хямд.

Үрьдчилан сэргийлэх эм бэлдмэлийг дараах тохиолдолд хэрэглэнэ:

- Нэмэлт хожуу вакцинжуулалтад эрсдэлт бүлгийнхнээс анхны вакцинжуулалтаас хойш 2 долоо хоносон хүн (эсрэг бие бий болох үе);

- Анхны вакцинжуулалт хийгдсэн хүүхэд-анхны вакцинжуулалт хийгдсэнээс хойш 6 долоо хоносон (2 дахь вакцинжуулалт хийгээд 2 долоо хоноход эсрэг бие бүрэн бий болох);

- Дархлааны хомсдолтой хүн вакцинжуулалтад дархлааны хангалтгүй хариулт өгч магадгүй. Ийм тохиолдолд өвчтөнд вакцин хэрэглэх, дээр нь нэмэлтээр ремантадин (амантадин) буюу нейраминидазыг дарангуйлах эм бэлдмэл хэрэглэх;

- Томуугийн эсрэг вакцинжуулалтад зарим хүн хориг заалттай байдал (тахианы өндөгөнд харшилтай хүн вакцинжуулалтад хоригзаалтай). Гэхдээтиймэрхүү хориг заалт нэн ховор тохиолддогийг санах хэрэгтэй (1000 хүнд 1-ээс бага);

- Ахимаг насны хүнд вакцинжуулалтын үр дүн буурах бөгөөд 50–70% хүрдэг тул нэмэлт вакцинжуулалт хийх;

- Вакцинжуулалтад хамрагдаагүй хүн өвчтөнтэй хавьтал болдог төрөл садан, хөршийнхэнд байвал;

- Цар тахлын аюул байгаа бол (энэ тохиолдолд нейраминидазыг дарангуйлах эм бэлдмэл хэрэглэх);

- Вакцины омог тахалт тархалтынхтай тохиорхгүй байх;

- Хэн нэгэн ямарваа шалтгааны улмаас вакцинжуулалтад цаг тухайд нь хамрагдаагүй байх.

Суурь эмчилгээ

Томууг өөрөө эмчлэх хэрэггүй, ялангуяа хүүхэд, ахимаг настай хүн гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Томуугийн явцыг үрьдаж таах боломжгүй шүү! Мөн хүндрэл нь маш олон янз байж болдог. Томуугийн хүнд хэлбэрийн үед цусархаг болон янз бүрийн хүндрэл (уушгины хатгаа, чихний үрэвсэл, гайморит г.м) гардаг.

Зөвхөн эмч л өвчтөний биеийн байдлыг зөв үнэлэх болно. Тийм хүндрэл томуу өвчний эхний өдөрт л уушгины цочмог хатгаа болох нь ховор биш, заримдаа томуугийн эхний цагт хүндрэл гарна. Иймд вирусийн эсрэг өвөрмөц эм бэлдмэл, адилтгах эмчилгээнд бактерийн эсрэг эм бэлдмэл болон бусад эм бэлдмэл (хүндрэл гаргахгүй тулд) хэрэглэх заалт өгөх, нэмэлт үзлэг, шинжилгээ /Цээжний рентген зураг, зүрхний цахим бичлэг болон бусад/ хийх нь олонтоо. Томуутай өвчтөнг эмнэлгийн ажилтнууд байнга ажиглаж байх шаардлагатай.

Харамсалтай нь ойролцоогоор өвчтний 30% нь өвчнийхээ 5–6 хоногт эмнэлэгт хэвтдэг нь удан явтай уушгины хатгаа, бусад хүндрэл оруулдаг

байна. Өвчтөн өөртөө болон хүүхдэд эцэг, эх, асран хамгаалагчид нь дур мэдэж янз бүрийн антибиотик хэрэглэж эхэлдэг нь байнга зөв болдоггүй төдийгүй хүүхэд, насандхүрэгсийг бактерит өвчиний хүндрэлээс сэргийлэхгүй, харшил үүсэхэд заримдаа нэрмээс болох, өвчин архагших, дисбактериоз, бактери эмэнд тэсвэрт хэлбэрт шилжихэд хүргэдэг.

Томуугийн анхны шинж тэмдэг бий болж мэдэгдмэгц нь хэрэглэх дараах эм хэрэглэгдэхүүн :

- Халуун цай, цангис буюу анисты сэргүүн ундаа, шүлтэг эрдэст ус (сүүтэй боржом, г. м бусад) байдлаар их юм уух;
- Халуун бууруулах эм паршетомол (жишээлбэл, панадол, колдрекс), НПВС (солпафлекс, бруфен)-ийг насанд нь тунг тохируулан хэрэглэх; Ацетилсалициловын хүчил (аспирин) 16 –аас доош насны хүүхдэд хэрэглэвэл Рией хам шинж үүсэх эрсдэлтэй тул хэрэглэхгүй заалттай;
- Хамраар амьсгалахад хөнгөвчлөх зориулалтаар судас агшаах эм хамарт хэрэглэх;
- Задь, амуу соёолжийн үндэс, алтайн ханд г. м.бусад эм хэрэглэгдэхүүнийг цэр шингэрүүлж гаргахад хэрэглэх; ;
- Ханиалгахын эсрэг эм: Пертусин – ханиалгах рефлекс нэмэгдэх, тусупрекс буюу бронхолитин болон глаувент - хуурай хий ханиалгах; либексин – салахгүй ханиалгах; бромгексин - чийглэг ханиалгах, цэр ховхрохгүй байх; Мукалтин, алтайн үндэс, амуу соёолжны үндэс, шар дэр, анист жимс – удаан үргэлжилсэн ханиалга; декстрометорфан – шөнө ханиалгахад хэрэглэх;
- Хүүхэд 2 наснаас дээш, насанд хүрэгсэд томуу өвчиний эхний өдөр хамба шарилжны ханд, шар дэр, тэрэлж, нарсан бөөр, 1–2%-ийн натри гидрокарбонат уусмал зэргийн уураар утлага хийхийг зөвлөдөг.
- Аскорбины хүчил, поливитамин;
- Антигистамины эм (тавегил, супрастин, задитен г.м. бусад);
- Томуу өвчиний эхний өдөр хамарт хүний цагаан эст интерофероныг 3–5 дуслаар өдөрт 4 удаа цацах буюу мөгөөрсөн хоолойд ИП- 2 загварын амьсгалуураар мананцар байдлаар (2-3 ампул интерофероныг 3-5 мл буцалсан эсвэл нэрсэн усанд найруулах) шүршиж.

Дурдсан бүх эм бэлдмэлийг эмчийн заалтаар хэрэглэхийг санах хэрэгтэй.

Өвөрмөц эмчилгээ

Иммуноглобулин

Томуугийн хүндэвтэр, хүнд хэлбэрийн үед томуугийн эсрэг биеийн өндөр агууламжтай донорын хэвийн иммуноглобулиныг 2 хүртэлх насны хүүхдэд 1,5 мл, 2–7 насныхад 3 мл, 7 наснаас дээших болон насанд хүрэгсэд 4,5 – 6 мл-ээр хэрэглэнэ. Хэт хордлогот хэлбэрт насны тунг 12 цагийн зайтай

иммуноглобулиныг давтаж хэрэглэж болно.

Амантадин болон ремантадин

Томуугийн халдвартын эмчилгээнд зориулсан өвөрмөц эм бэлдмэл 60-аад оныг хүртэл байсангүй. Зөвхөн өвчиний шинж тэмдгийг хөнгөвчлөхд л эм бэлдмэлийг ашиглаж байв.

Эбала вирүст цусархаг чичрэг бол халдварт авсан 10 хүн тутмын 9 нь эндэж төгсдөг аюулт өвчин. Шинжлэх ухааны адал явдал бүтээлээр мэргэжсэн АНУ-ын зохиолч Ричард Престоны 1994 онд хэвлүүлсэн "The Hot Zone" хэмээх зохиол бол энэ аюулт өвчнийг судласан үнэн түүх дээр үндэслэсэн чансаатай бүтээл бөгөөд манай сайн вирус судалчдын нэг, доктор Э.Пүрэвдаваагийн орчуулгаар 2010 онд "Гоц аюулт бүс" нэрээр "Адмон" хэвлэлийн газар нийтлэсэн билээ.

Р.Престоны энэ бүтээл бол байгалийн голомтот шинэ халдвартай анх тулгарахын аюул осол, аймшигийн тухай чин үнэнээр нь бичсэнээрээ нийтэд алдаршсан бөгөөд дэлхийн 30 шахам орны хэлээр орчуулгадж, Дастин Хоффман нарын АНУ-ын кино одод тоглосон "Тахалт дэгдэл" (Out-break) хэмээх Холливудын аймшигийн киноны зохиолын эх болсон билээ. Р.Престоны энэ бүтээл зөвхөн сонирхолтой уран зохиол төдий бүс, гоцааултай халдварт өвчинтэй гэнэт тулгарах үед мэдүүштэй сургамж арвантай тул АНУ-ын Вүүдрөү Вильсоны San(Woodrow Wilson Foundation)-гийн

ажилтан Э.Голденкранц энэ зохиолыг дээрхи сангаас жил бүрийн зүн зохион байгуулдаг биологийн багш нарын зуны сургуулийн сургалтын материал болгон найруулсан нь одоо интернетээр чөлөөтэй ашиглаж болох хичээл болсон байна (Р.Престоны тухай дэлгэрэнгүй мэдээллийг түүний вэб-сайт <http://richardpreston.net> болон интернетийн "Википедиа" тайлбар толийн өгүүлүүдээс (http://en.wikipedia.org/wiki/Richard_Preston, http://en.wikipedia.org/wiki/The_Hot_Zone) авна уу).

Халдварт өвчинтэй тэмцэх Монголын үндэсний холбоо Р.Престоны энэ ном бол халдварт өвчинтэй тэмцэх ажил, үйлст оролцдог хүн бүрийн уншвал зохих бүтээл хэмээн үзэж буй тул доктор Э.Пүрэвдаваагийн зөвшөөрснөөр сэтгүүлээ цувралаар нийтлүүхээр шийдсэн юм.

Энэ номын монгол эхийг "Интерном" дэлгүүрээс худалдан авч болохоос гадна drpurev@gmail.com хаягаар орчуулагчтай харилцан олж авч болно.

Сэтгүүлийн зөвлөл

Нэгдүгээр дэвтэр ЭЛГОН УУЛЫН СҮҮДЭР

ОЙГООС ХАЛДСАН ВИРУС
1980 оны шинэ жил

Нзойагийн чихрийн үйлдвэрийн нишингийн тариалан, Кени улсын баруун зүгийн нутгийг дайран урсдаг Нзойа голын эргийг даганхан халиурч байдаг бөгөөд тэр тариалангийн хаанаас нь ч гэсэн, Элгон уул сүндерлэнхэн харагдаж байдаг юм. Элгон уул бол, зэлүүд орших маш сүрлэг, унтарсан галт уул. Түүний, Рифт хөндийрүү харсан талых нь өндөр 4267 метрт хүрдэг ажээ.

Нзойагийн чихрийн үйлдвэрийн эдлэн газар дахь хувийхaa нэг жижигхэн модон байшинд Шарль Моне гэдэг франц гоонь эр ганцаархнаа суудаг байжээ. Түүний намтар нэн будэг бадаг. Шарль Моне чухам юунаас болж Африкт ирж суурьшсан нь тэндхийн дийлэнх гадаадын иргэдийнх адил тодорхойгүй байлаа. Магадгүй, Франц эх оронд нь түүний ажил үйлс бүтээмж муутай байсан ч юм уу, аль эсвэл Кени улсын тансаг сайхан байgal сэтгэлийг нь соронзон татсан ч юм уу, бүү мэд. Ямар ч байсан, байгалийг сонирхон судалдаг байсан тэр хүн, шувууд болоод

амьтдыг зөвхөн өрөвчхөн сэтгэлийхээ үүднээс биш, харин үнэн голоосоо хайлрадаг байсан байна.

Шарль Моне тавин зургаан настай, дунд зэргийн нуруутай, махлагдуу биетэй, гялтганасан шулуун хүрэн үстэй, нүдэнд дулаахан эр байжээ. Хүмүүсийн ярьснаас үзвэл, Элгон уулын эргэн тойронд оршдог, зарим жижигхэн хотод суудаг хэд хэдэн бүсгүй л, түүний хамгийн дотны найз байсан бололтой. Гэтэл Шарль Монегийн нас барсан шалтгааныг судалж байсан эмч нарт түүний талаар тодорхой хэлээд өгчих юм үнэндээ тэдгээр найз нарт нь ч байсангүй. Тэр бүсгүйчүүд "Нзойа голоос ус соруулж, олон километр үргэлжилсэн чихрийн нишингийн талбайг усладаг шахуургын машиныг Шарль Моне ажиллуулж, түүнийгээ засч сэлбэх ажлыг эрхлэн, өдрийн ихэнх цагаа голын захын, ус шахуургын байшинд өнгөрөөдөг байсан нь, магадгүй, машиныхаа ажиллаж байгааг нь харж, дуу чимээг нь сонсож сүүх түүнд аятайхан санагддаг байсных биз" гэлгээжээ.

Эв эрүүл, сав саруул байсан хүн гэв гэнэтхэн нас барсных нь дараа, аливаа нарийн ширийн зүйлийг тодруулах гэдэг тун бэрх байсан бөгөөд зөвхөн эмч нар л, Шарль Монегийн өвчний шинж тэмдгийг тодхон санаж байлаа. Биологийн аюулгүй ажиллагааны дөрөвдүгээр зэрэглэлийн дэглэмийг хатуу баримтлан ажиллах шаардлагатай, гоц аюултай халдварт өвчин

үүсгэгч вирус хүний биед хэрхэн нөлөөлж, өвчний шинж тэмдгүүд ар араасаа нэмэгдэн илэрсээр, эцэст нь, түүнийг хэрхэн хөнөөж байгааг нүдээр үзсэн хэн боловч, ийм явдлыг огт мартахгүй нь мэдээж. Шарль Монегийн өвчин болэмнэлзүйнбодитилрэл, аймшигийн үзэгдэлтэй холилдсон содон бөгөөд түгшүүртэй, үлгэрлэвээс, алс тэнгэрийн нар өнгөө хувиргачихсан байхыг гэнэт харсан хүн цочирдон ухарч, дальдчих мэт сэтгэлд жихүү татуулсан тохиолдол байжээ.

Шарль Моне анх 1979 оны зүн Африкт ирсэн байна. Тэр үе бол, дархалын олдмол хомстол (ДОХ) өвчнийг үүсгэдэг, хүний дархлал хомстлын вирус (ХДХВ) Төв Африкийн ширэнгэ ойгоос алдуурал гарч, хүн төрөлхтний дунд тархаж эхлээд байсан цаг байв. Ийм халдварт байдгийг нэг ч хүн мэдээгүй байсан тэр үед, ДОХ өвчин, хүн төрөлхтнийг сүүдэр мэт алгуурхан нөмөрсөөр л байжээ. Энэ өвчин эхлээд Киншасын хурданы замын дагуу аажим тархсан байна. Киншасын хурданы зам, Африкийн зүүн захаас баруун зах хүртэл, тив дамнан сунайхдаа Виктори нуурын захаар дайран өнгөрдөг юм. Тэндээс ч, нөгөө Элгон уул сүндэрлэн харагддаг билээ.

ДОХ өвчнийг үүсгэгч ХДХВ, хэдийгээр, үхэлд зайлшгүй хүргэдэг боловч, хүнд амархан халдвартладаггүй тул, энэ вирустый ажиллахад биологийн аюулгүй ажиллагааны хоёрдугаар зэрэглэлийн дэглэмийг мөрддөг журамтай. Өөрөөр хэлбэл, ХДХВ нь агаар дуслын замаар хүнээс хүнд дамжин халдлаггүй учраас, халдвартай цус, бусад материалтай ажиллахад иж бүрэн хамгаалах хувцас өмсөх шаардлага байдаггүй юм.

Талийгаач Шарль Моне ажлыахаа өдрүүдэд ус шахуургын байшиндаа шургуу гэгч нь ажиллаад, хагас, бүтэн сайн өдөр болон баяр, амралтын өдрүүдээр, чихрийн үйлдвэрийн ойролцоо ой модтой газраар аялж, эргэн тойрондоо идэх юм цацхихаад, шувууд болоод амьтад цацсан юмыг нь ирж идэхийг ажиглан, огт хөдлөхгүй сууж чадаг байжээ. Түүнийг таньдаг байсан хүмүүсийн хэлснээр бол, Шарль Моне зэрлэг сармагчинд жигтэйхэн хайртай, бас түүнийг биедээ татах тусгай аргатай байсан учир, идэх юм бариад сууж байхад нь сармагчин хүрч ирээд гараас нь идчихдэг байсан гэнэ.

Шарль Моне үдэш оройг зуслангийхаа байшинд өнгөрөөж, Жонни гэдэг үйлчлэгч эмэгтэй гэр орныг нь цэвэрлэж, хоол ундыг нь бэлтгэдэг байжээ. Шарль Моне Африкийн шувуудыг яланг таних аргыг бие даан судалж, гэрийхээ ойролцоо ой модонд үүрлэсэн, үүрээ нэхэгч шувуудын сүрэг, уут маягийн үүрээ хэрхэн нэхэж засахыг ажиглан цагаа нөхцөөдөг байжээ. Хүмүүсийн ярьснаар бол, зүл сарын баяр ойртох байхад Шарль Моне нэгэн өвчтэй шувууг гэртээ авчирч, эмчлэхийг хичээсэн боловч хөөрхий тэр шувуу гар дээр нь үхжээ. Тэр шувуу, үүрээ нэхэгч шувуу ч байсан юм уу, өөр шувуу ч байсан юм уу, гоц

аюултай халдварт өвчинөөр үхсэн ч юм уу, ясан ч юм, бүү мэд.

Талийгаач бас шаазгай тэжээж, тэр амьтантай дотно нөхөрлөдөг байжээ. Хар цагаан алагласан, хүнд ойрхон, ухаантай энэ шувууг Африкийн зарим хүн гэртээ тэжээх дуртай байдаг юм. Байшингийх нь дээвэр дээр сугаад, эзнийхээ ирэх, буцахыг ажиглаж байдаг шаазгай нь, өлсөхөөрөө тавсан дамжсаар гэрт нь орж ирэхэд, гэрийн эзэн түүнийг ширээн дээрх хоолны уртсээр хооллодог байжээ.

Шарль Моне өглөө болгон чихрийн нишингийн талбай дундуур гурван километр гаруй газар алхсаар ажилдаа очдог байсан бөгөөд тэр жилийн зул сарын баярын үеэр ажилчид тариалангийн талбайг шатааж байсан болохлоор, хааяагүй, түлэгдэж харласан байлаа.

Хуйхлагдаж түлэгдсэн, тариалангийн талбайгаас умар зүг 40 километрийн тэртээ Элгон уул харагдана. Энэ уулын төрх байдал, Африкийн цаг агаар, сүүдэр, бороо, нарны тусгал зэргийг дагалдан байнга өөрчлөгдөж байдаг юм. Үүрийн гэгээ тусах үед Элгон уулын сэrvэн манан дунд умбаж, дэлбэрэлтээс үүссэн хоёр амсарых нь оргил сүмбэрлэн харагдана. Харин наран мандах үед Элгонуул мөнгөлөгнөгоон харагддаг нь түүний ширэнгэ ойн өнгө биээ. Үд дундын үед үүлс бүрхэн уулыг халхална. Үд өнгөрснөөс нэлээд хойхноос нар шингэж эхлэх хүртэл тэндхийн үүлс өтгөрөн өтгөрсөөр тэнгэр дуугарч, цахилгаан цахилах бөгөөд үүлсийн доод хэсэг нь нүүрс мэт харлан, дээд хэсэг нь агаарт сарниад, жаргаж буй нарын тuyaанд жигдхэн улбар шар өнгөөр тuyaарна. Энэ үес, үүлсээс тэртээ дээрх үүн цэнхэр огторгуйд халуун орны ганц нэгхэн од гялбалзан харагддаг юм.

Элгон уулаас зүүн өмнө зүгт оршдог Элдорет тосгонд Шарль Моне хэд хэдэн найз бүсгүйтэй байжээ. Тэндхийн хүмүүс нь ядуу, банс төмрөөр барьсан оромжинд сүудаг юм. Шарль Моне найз бүсгүйчүүдээ мөнгөөр тусалж, хариуд нь тэд янагалаар мляадаг байв. Зүл сарын амралт эхлэхэд Шарль Моне амралтын өдрүүдээ Элгон ууланд, майханд өнгөрөөхөөр шийдэн, Элдоретийн бүсгүй найз нарынхаа нэгийг урьж, хамт явжээ. Хожим нь, тэр бүсгүйн нэрийг санах хүн нэг ч байсангүй. Гэхдээ тэр үед иймэрхүү юм болжээ.

Шарль Моне найз бүсгүйнхээ хамт ланд-рover машинаар галт уулын зүүн талын Эндебессийн хадан цохио хэмээх цуутай хясааг хүрдэг улаан тоостой, урт шулуухан замаар өгсчээ. Энэ зам, хатсан цус мэт ув улаан өнгөтэй, галт уулын дэлбэрэлтийн нуранги шороон зам юм. Хоёр аялагч, галт уулын доод бэл хүртэл өгсөөд, бэлчээр рүү ордог замтай, эрдэнэ шишийн талбай, кофейн тариалангийн дундуур гарч, эгнэн ургасан уд моддын ард халхлагдан оршдог, Английн колончлолын үед баригдаад, одоо хагас нь нурж сүйрсэн эртний нэгэн сууринг өнгөрөв. Үүл өөд

өгсөх тусам агаар сэргүүсч, үе үе хуш моддын дотроос зогдорт бүргэд дэвэн ниснэ. Ер нь, Элгон ууланд жуулчид олноороо очдоггүй болохлоор, машинтай яваа хүмүүс гэвэл, ердөө Шарль Моне, түүний наиз бүсгүй хоёр л байлаа. Харин явган хүмүүс үй олноороо багшралдах нь уулын хормойн налуу хэсэгт жижиг тариалан эрхэлдэг тосгоныхон ажээ.

Тэр хоёр, Элгон уулын ширэнгэ ойн нуранги захруу сөөм сөөмөөр ойртон ахисаар, "Элгон уулын отог" хэмээх хорьдугаар зууны эхэн үед баригдаж, одоо сэргээн засахын аргагүй эвдэрч, хана нь цуурч нураад будаг нь нар бороонд ховхорч арилсан, англи маягийн нэгэн дэн буудлын буурины хажуугаар өнгөрлөө.

Элгон уул бол, Уганда улс, Кени улс хоёрын яг хилийн зааг дээр, Судан улсаас ч бас холгүй оршдог юм. Африкийн төв хэсгийн ширэнгэ ойн дундах, биологийн нэгэн өвөрмөц арал болсон энэ үзэсгэлэнт уул бол, тэгш, хуурай газраас дээш орь ганцаар сүндэрлэсэн тусгаарлагдмал нэгэн ертөнц бөгөөд ой мод, хулс, уулын хонин арцаар хучигдсан 80 гаруй километр өргөн талбайг эзэлдэг юм. Төв Африкийн нуруун дээрх өндөрлөгийн нэг, энэ галт уул 7–10 сая жилийн өмнө үүссэнээсээ хойш, дахин дахин дэлбэрч, дэлбэрэх бүрдээ гал үнсээр тургин, өөрийгөө бүрхэж байсан ой модыг шатаан түймэрдсээр, хамгийн сүүлчийн хүчит дэлбэрэлтийхээ дараа л унтарчээ. Элгон уул ингэж дэлбэрэхээсээ өмнө, өнөөгийн Африкийн хамгийн өндөр уул Килиманжарогоос ч өндөр байсан байж магадгүй. Ямар ч байсан, өргөнөөрөө дэлхийн хамгийн өргөн уул хэвээрээ байгаа билээ.

Наран мандах үед, Элгон уулын сүүдэр баруун тийшээ Уганда улсыг бүрхэн, наран жаргах үед зүүн тийшээ Кени улсыг нөмөрнө. Элгон уулын сүүдэрт орших олон жижиг хот, тосгодод төрөл бүрийн үндэс угсаатан амьдардгийн дотор Элгон уулын мазай үндэстэн багтана. Өвөрмөц шашин шүтлэгтэй энэ үндэстэн, умардаас хэдэн зууны тэртээ нүүдэллэн ирж, энэ уулын эргэн тойронд суурьшсанаас хойш, үе удам дамжин, малааmallan аж төрж иржээ.

Элгон уулын доод бэл, зөөлөн шүрших бороонд угаагдан, жилийн турш сэргүүхэн цэвэрэргаартай байдалдаг бөгөөд галт уулын хөрс сайхан ургаш өгнө. Галт уулын эргэн тойрны тосгод, үндсэндээ, нэгэн цагиргийг үүсгэдэг төдийгүй энэ цагираг, ой орчмын налуу энгэрүүдэд улам улам нарийсч, уулын зэрлэг амьтдыг боймлон устгагч-дүүжлүүрийн гогцоо болсоор байгаа юм. Хүмүүс ой модыг тулшиндээ хэрэглэхээс гадна бэлчээрийн талбай гаргах зорилгоор хөрөөдөж сүйтгэснээс тэндхийн заан устаж эхэлжээ.

Шарль Моне наиз бүсгүйтэйгээ аялан явсаар Элгон уулын багаахан хэсгийг эзэлдэг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн хаалганы дэргэд ирж, машинаа зогсоон, дотогш нэвтрэх тасалбар авах үед сармагчин ч юм

үү, бич ч юм уу, одоо хэн ч сайн мэдэхгүй байгаа нэг амьтан, хаалганы орчмоос дүүжлэгдэн, хүн юм өгөхийг горьдон харж байлаа. Моне тэр амьтанд гадил жимс харуулан хорхойг нь хүргэж байгаад мөрөн дээрээ суулгахад наиз бүсгүй нь баясан баярлаж, инээд алдсаар байсан бөгөөд хоёулаа тэр амьтныг жимсээ идэж дуусан дуустал тайван хоололлоо. Дараа нь, тэр хоёр, уул өөд жаахан өгсөөд горхируу налсан, чийгтэй ногоон өвсний чөлөөнд буудаллан, майхнаа босгов. Ширэнгэ ойгоос үндрэн гарсан горхины ус, галт уулын шороотой холилдсоноос сүү шиг өвөрмөц өнгөтэй болжээ. Хавь орчных нь ногоог одос үхэр зулгааснаас тачирхан болж, хааяагүй, үхрийн баас толботон харагдана.

Тэдний буудалласан газрын эргэн тойронд, Элгон уулын ой нүүгэлтэж байв. Африкийн чидун хэмээх уртай мodyg хөвд болон мөлхөө ургамал торлон сүлжээд, хүний биед хортой хар чидунаар цоохортсон мөчир нь нэвсийнэ. Модон дотор хооллож байгаа сармагчдын зодолдоон, шавьжны дүнгэнээн, хааяа нэг намуухнаар "Хүү-үү, хүү-үү" гэх сармагчны дуу сонстоно. Энэ бол, колобус сармагчны дуу. Колобус сармагчин, заримдаа, ганц нэгээрээ модноос буун, майхны хажуугийн нуга дундуур харайлган хүрч ирээд, Моне, бүсгүй хоёрыг болгоомжиж, сорьсон нүдээр ажиглаж байв. Чидуны модон дотроос сүрэг тагтаа гэнэт дэрхийн нисч, маш хурдтайгаар доош шунгах нь, махчин харцаганд бариулж, далавчaa тас татуулахаас аврагдах тэдний гол арга ажээ. Гаврын мод, судалт мод, Африкийн хувь, эвгүй үнэрт улаан мод ургасан ойн дээгүүр энд тэндгүй хар ногоон өнгөөр тунарах мөөгөн хэлбэрт бөөн навчис хүглийн харагдана. Энэ бол, Калифорнийн секвойя модтой хэмжээгээрээ бараг адилхан Африкийн хамгийн том, подокарпус хэмээх модны оройн титэм билээ. Энэ ойд олон мянган заан амьдарч, сүрэг сүргээрээ бэлчин, модны холтос хуулах, мөчир хугалах чимээ тасардаггүй байсан үе бий.

Үдээс хойш, Элгон ууланд бороо асгардаг зантай болохлоор, тэр үеэр Шарль Моне бүсгүйтэйгээ амарч, аадар бороо майхныг бөмбөрдөнхөн байхад, хоёулаа янагланхан жаргаж байсан нь мэдээж. Бүрэнхий болж, бороо арилахад, тэд гал түлэн, хоолоо хийцгээж, шинэ жилийн урьд орой байсан тул, бас оргилуун дарс хундгалан, баяраа тэмдэглэсэн нь гарцаагүй. Харин бороо зогссноос хойш, хэдэн цагийн дараа үүл арилдаг жамаараа арилахад, галт уул сүүн замын доохно, бараан сүүдэр мэт тодорч ирсэн байлгүй. Тэгээд, шөнө дундын цаг цохих үед, дарсанд халамцсан Шарль Моне тэнгэрийн оддиг ширтэн, зүлгэн дээр гүйван зогсож байсан нь лав.

Шинэ жилийн өглөө бараг +5°C-ийн хэмийн хүйтэвтэр, зүлэг ногоо нойтон байлаа. Шарль Моне наиз бүсгүйхээ хамт өглөөний үндүүснэ дараа, шавар шавхай болсон замаар уул өөд өгссөөр Китумын агуин

доохно, нэгэн жижиг нугад машинаа орхив. Чидуны мод болоод сахлаг өвстэй нуга дундуур урсах жижиг горхины хажуугаар зурайсан, зааны мөрийг даган, бут соөгөн дундуур хөндийг өгслөө. Тэр хоёр, ойд халз тулгарвал тун аюултай одос үхрээс сэрэмжилж явав. Хөндийн дээд эхэнд орших Китумын агуин амыг горхины ус нөмрөн буух ажээ. Зааны мөр яваасаар, тэр агуин аманд ирж нийлээд, бүр дотогш орсон байлаа. Шарль Моне шинэ жилийн өдрийг найз бүсгүйтэйгээ цуг Китумын агууд өнгөрөөжээ. Мэдээж, бас л бороо асгасан нь гарцаагүй болохлоор, тэр үед, мань хоёр агуин аман дээр хэдэн шагаар суун, дээрээс хөшиглөн буух горхины ус, хөндийд бэлчих заан, энэ тэрийг сонирхон, хад асганд амьдардаг, том багаараа тарвагатай нэлээд төстэй, даман хэмээх үслэг амьтад агуин амны ойролцоо үхэр чулууг өгсөн уруудан гүйлдэхийг ажиглаж байгаа биз ээ.

Шөнө болохоор, эрдэс бодис, давс олж идэх гэсэн олон заан Китумын агууд орж ирдэг юм. Тэдгээр заан, нам дор газрын давхрага, усны хатсан нүхнээс эрдэс бодис, давсиг амархаан олоод идчихдэг бол, харин энэ ширэнгэ ойд эдгээр зүйл түйлийн үнэ цэнэтэй, ховор тэжээл болдог билээ. Китумын агуу нэгэн зэрэг 70 заан багтахуйц уужимхан зйтай бөгөөд олон заан энд шөнийг өнгөрөөхдөө заримдаа зогсоогоороо унтаж, заримдаа хад чулууг соёогоороо ухаж буулган, зажилж бутлаад, жижиг чулуунуудыг шууд залгидаг юм. Иймээс, агуин эргэн тойронд хэвтэх зааны баасанд жижигхэн чулуу дүүрэн байдаг билээ.

Шарль Моне Китумын агуин хөндий хэр хол үргэлжилдгийг үзэхээр гар чийдэн авч бүсгүйтгээ дагуулан агууд буцан оржээ. Агуин ам тавь гаруй метр өргөн байсан боловч, цаашлах тусам уlam өргөссөн байлаа. Зааны нунтаг баасаар хучигдсан хэсэг газрыг өнгөрөөд, агуин гүн рүү уlam ахих тусам, хөл дор пургих тоос ч уlam нэмэгдэж, гэрэл ч уlam бүдгэрлээ. Шат маягаар дээшээ өндөршсөн, агуин ёроол ногоон өнгийн залхагаар бүрхэгджээ. Энэ залхаг бол, жимс ногоогоор хооллон, агуин таазанд амьдардаг үй олон сарьсан багваахайн ялгадас байлаа. Сарьсан багваахайнүүд нүхнээсээ нисэн гарч, чийдэнгийн гэрэл дундуур сүлжилдэн, тэр хоёрын толгой дээгүүр эргэлдэн, чанга чанга дуугарч байв. Гар чийдэнгийн гэрэл, сарьсан багваахайнүүдиг цочоосон бололтой, уlam олноороо сэргээж, хэдэн зуун улаан нүд агуин таазнаас эрдэнийн чулуу мэт гялтайж байлаа. Сарьсан багваахайнүүдийн далавчaa дэвэх чимээ тааз дамжин шуурайтах нь тосгүй болчихсон нугастай, олон жижиг хаалга нээгдэх мэт чахарсан, хахир дуу хадаанаа.

Тэгж явахдаа, Моне бүсгүй хоёр Китумын агуин хамгийн гайхамшигтай зүйлийг олж үзлээ. Агуу тэр аяараа чулуужсан ширэнгэ ойгоос үүсчээ. Агуин хана, таазнаас ёрдойсон, чулуужсан дархи моддыг ажиглавал, судалт мод, подокарпус, мөнх ногоон модод байв. Элгон уул, долоон сая жилийн

өмнө дэлбэрч, гал үнсээрээ ширэнгэ ойг булах үед дарагдсан модод нь гэрэлт чимэд чулуу, занар болон хувирчээ. Хаднаас ургасан, цагаан өнгийн эрдэст талстууд чулуужсан моддыг бүрхсэн байв. Арьсан дор тариа хийдэг зүү шиг хурц, нарийхан тэдгээр талст чийдэнгийн гэрэлд гялталзаж байлаа.

Моне, бүсгүй хоёр, агуин хана, таазнаас амьтдын чулуужсан яс сэрийж байхыг бас үзжээ. Матрын яс, эртний хирсийн яс, зааны өвөг болох амьтны яс ч байлаа. Чулуужсан моддын хооронд татсан торондоо дүүжлэгдсэн аалзнууд элдэв эрвээхий, шавьжаар хооллож байв. Хоёулаа агуудаар хэсэн, чулуужсан моддыг гэрэлтүүлэн сонирхсоор явах зуураа Моне чулуужсан модонд гарцаа эсгэсэн үү, эсвэл хурц үзүүртэй талстад гарцаа хатгуулсан үү, бүү мэд. Ямар ч байсан, энэ агууд л халдварт авсан байж таарна...

Нөгөө хоёр дахиад жаахан өгстөл, агуин хөндий нь ер гаруй метр буюу хөл бөмбөгийн талбайн уртаас арай өргөн боллоо. Хоёулаа тэнд нэгэн ангал байхыг олж, гэрлээ доош нь тусган харвал, хүрэн саарал өнгийн нэг сонин зүйл харагдсан нь, зааны занданшиж хатсан тугал байв. Заанууд харанхуй шөнө агууд явахдаа хүрэлцэх мэдрэхүйгээрээ зүг чигээ багцаалан, хушуугаараа өмнөх газраа шалгаж явдаг боловч, хараахан ингэж сургаагүй зааны тугал заримдаа ангалд унаж осолддог ажээ.

Хоёр аялагч агуин гүнрүү лавхан орж, налуур uu буугаад, дээврийг нь тулан тогтоож байгаа нэгэн тулгуурт хүрлээ. Энэ тулгуур дээр, зааны соёоны ором, ховил дүүрэн гарчээ. Хэрэв энэ тулгуурын ёроолыг заанууд нэмээд жаахан ухах л юм бол, тулгуур ч нурж, Китумын агуин дээвэр ч цөмөрч болзошгүй болжээ. Агуин арын хэсэгт байсан өөр нэг тулгуур аль хэдийнэ нурж унаад, дээгүүр нь хүрэн улаан өнгийн сарьсан багваахайнүүд дүүжлэгдэж, тэр хавийг хар өнгийн залхагаар бохирдуулсан нь агуин амны орчимд байсан сарьсан багваахайнүүдийн ногоон өнгөтэй ялгадаснаас огт өөр байв. Энэ хавийн сарьсан багваахайнүүд шавьжаар хооллодог амьтад бөгөөд энэ хар өнгөтэй залхаг бол, тэдний идэж боловсруулсан шавьжны үлдэгдэл ажээ. Тэр ялгадсанд Моне гарцаа хүргэнээс халдварт авсан ч байж магадгүй билээ.

Шарль Монегийн найз бүсгүй Элгон ууланд аялснаасаа хойш хэдэн жил огт харагдсангүй. Гэтэл Шарль Монегийн нас барсан шалтгааныг судалж байсан кени эмч тэр бүсгүйг Момбаса хотын нэгэн бааранд биээ үнэлдэг байхад нь ёстой санамсаргүй тохиолдоор тааралджээ. Тэр кени эмч бааранд шар айраг шимсэн шиг, нэг эмэгтэйтэй дэмий ярьсан шигээ сууж байхдаа Шарль Монегийн нэрийг санамсаргүй дурдсан юм байжээ. Тэгтэл, нөгөө эмэгтэй: “Би түүнийг танилгүй яахав. Баруун Кенигээс ирж Шарль Монетой хамт явсан тэр эмэгтэй чинь би байхгүй юу” гэхэд нь нөгөө эмч анхандаа түүнд итгэсэнгүй. Харин

тэр эмэгтэй өмнө өгүүлсэн зарим нарийн ширийн зүйлийг эмчид ярьж өгсөн тул арга буюу үгэнд нь итгэжээ.

Тэр эмэгтэй, кени эмчтэй бааранд тааралсанаасаа хойш харагдахаа бүр болж, Момбаса хотын үймээн шуугиан дунд уусан алга болжээ. Магадгүй, одоо тэр байхгүй, аль хэдийнэ ДОХ өвчинөөр нас барсан байж ч болзошгүй дээ, хөөрхий.

Шарль Моне зул сарыхаа амралтын дараа, нөгөөх л ус шахуургын байшиндаа дахин ажиллаж эхэлжээ. Тэр, өглөө болгон чихрийн нишингийн шатаасан талбайг гатлан, ажилдаа очиж явах замдаа, үүлэнд умбасан Элгон уулын бараа сүрийг харан бахдаж, үл үзэгдэх ертөнцийн татах хүчинд автсан мэт тэрхүү үзэсгэлэнт ууланд сэтгэл нь хоргодсоор байсан нь эргэлзээгүй. Гэтэл, тэр л өдрүүдэд түүний бие махбодод нэгэн зүйлийн бичил биетэн амьдарсаар, үржиж олширсоор л байжээ. Тэр бичил биетэн бол вирус хэмээх амьдралын нэгэн хэлбэр байсан бөгөөд Монегийн бие махбодийг бүрэн эзэлж, өөрийхөө амьран орших эзэн болгоод, зогсоо зайлгүй үржин олширсоор л байлаа.

* * *

Ийм аюултай вируст халдварт өртсөн хүний толгой долоо дахь өдрөөс нь өвдөж эхэлдэг онцлогтой. Тэгвэл, 1980 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн Шарль Монегийн нүдний угаар лугшин өвдөж эхэлсэн тул, ажилдаа очихоо болихоор шийдэн, орондоо хэвтэж өнжжээ. Энэ өдөр бол түүний Китумын агууд өнгөрүүсэн шинэ жилийн аяллын дараах яг долоо дахь өдөр байв.

Толгойных нь өвчин түүнийг уlam зовоож, нүднийх нь алм хөндүүрлэж байснаа, дараа нь, чамархайгаар нь хатгуулж, нэг ёсондоо, толгой дотор нь өвчин тойроод л явах мэт санагджээ. Аспирин уугаад ч өвчин намдсангүй, удалгүй нуруугаар нь хүчтэй өвдөж эхэллээ. Гэрийнх нь үйлчлэгч Жонни зул сарын амралтаа аваад явчихсан тул, Шарль Моне саяхнаас нэг үйлчлэгч түр хөлслөлсөн байлаа. Үйлчлэгч эмэгтэй, түүнийг хэрээрээ асарч сувилахыг хичээсэн боловч, чухам яж туслахаа үнэндээ мэдэхгүй сандарч байв. Монегийн толгой өвдөж эхэлснээс хойших гурав дахь өдөрөөс нь түүний дотор эвгүйрч, цочир халауран, бөөлжиж эхэлжээ. Бөөлжих нь улам нэмэгдсээр, сүүлдээ хоосон огиулж, бие нь жигтэйхэн сул болж, нүүрэнд нь амьд хүний шинж огт байхгүй, баг шиг хөдөлгөөнгүй болж, нүд нь гөлийлөө. Зовхи нь жаахан унжиж, нүднийх нь алм аяганаасаа бүлтийн, нүдээ хагас аньсан мэт өвөрмөц дүртэй болов. Хөлдчихсөн юм шиг огт хөдөлгөөнгүй болсон нүд нь час улайж, нүүрнийх нь арьс шарлан, од хэлбэрийн гялалзсан улаан өнгийн толбууд гарч эхэллээ. Шарль Моне яг үхээрийн хүн шиг харагддаг болов. Тэр, яагаад ингэж сүрхий өөрчлөгдөж байгааг үйлчлэгч нь ерөөсөө ойлгосонгүй. Шарль Моне эрс хувирал,

огт өөр хүн шиг болж, дүнсгэр, өөнтөгч, ууртай, оюун ухаан нь хийсэн одсон мэт боллоо. Гэхдээ тэр дэмийрч солиорсонгүй, асуусан юманда хариулж чадаж байвч, чухам хаана байгаагаа яг таг мэдэхгүй байгаа бололтой байв.

Хамт ажилладаг нөхөд нь, Шарль Монег ажил дээрээ үзэгдэхээ больсонд гайхаж, чухам юу болсон юм бол гэж санаа нь зовж зовж, эцэст нь, нөхрөө эргэхээр зуслангийх нь байшинд очиход, алаг шаазгай нь зочид дотогш орохыг ажиглан, дээвэр дээр сууж байв. Нөхөд нь Шарль Монег харангутаа л, түүнийг заавал эмнэлэгт хүргэх шаардлагатайг ойлголоо. Ажлын нь газрын нэг хүн, бие нь тун тааруу, машинаа ч жолоодох тэнхэлгүй болчихсон нөхрөө Виктори нуурын эрэг дээр оршдог, Кисуму хэмээх нэг жижигхэн хотын хувийн эмнэлэгт хүргэж өгөв.

Шарль Монег үзсэн эмч нар, түүний нүд, нүүр, ухаан санаа яагаад ингэж өөрчлөгдсөнийг тайлбарлаж чадсангүй. Ямар нэг нянгийн халдвараас болсон байж болзошгүй гэж санаад, түүнд антибиотик тарьсан боловч өвчинийг нь анагааж дийлсэнгүй. Тэгээд эмч нар, Зүүн Африкийн хувийн эмнэлгүүдийн дотроос хамгийн сайнд тооцогддог Найроби хотын эмнэлэгт очиж эмчлүүлэхийг түүнээ зөвлөөд, тэр эмнэлгийн аль нэгэмчид өвчтөн очих гэж байгааг урьчилаан мэдэгдэх гэж хичээсэн боловч, холбооны шугам ажиллахгүй байсан тул бүтсэнгүй. Гэхдээ Шарль Моне өөрөө явж чадахтайгаа байсан болохлоор, унаанд суугаад ганцаараа явчихаж дөнгөхөөр харагдаж байжээ. Түүнд замын зардлын мөнгө хүрэлцээтэй байснаас гадна Найроби хотруу явах хэрэгтэй гэдгээ ч сайн ойлгосон байлаа. Эцэст нь эмч нар Шарль Монег таксида суулган онгоцны буудал руу явуулснаас хойш, удалгүй тэр Кени улсын агаарын тээврийн онгоцнаа суужээ.

Ширэнгэ ойгоос тархсан гоц аюултай вирус хоногийн хорин дөрвөн цагийн туршид дэлхийн хот болгоноос нисдэг ямар ч онгоцнаа тээгдэн жуулчилж чадна. Хэрэв ийм аюултай вирус дэлхийн бүх хотыг тор мэт холбосон, агаарын тээврийн сүлжээнд нэг л нэвтэрсэн бол ганцхан хоногийн дараа Парис, Токио, Нью-Йорк, Лос Анжелес хаана л бол хаана, онгоц нисдэг газар бүхэнд хүрчихэж чадна. Тэгвэл, Шарль Моне, түүний бие үржих буй аюулт вирус хоёр энэ сүлжээнд хэдийнэ орчихсон байлаа.

Шарль Монегийн сусан онгоц нь “Фоккер Френдшип” хэмээх, сэнстэй, гучин таван хүний суудалтай зорчигч тээврийн онгоц байв. Онгоцны хөдөлгүүр асан хөөрч, цэнхэртэн гялбалзах мандалд нь загасчдын модон завь торойн торойн харагдах Виктори нуурын дээгүүр эргээд, зүүн зүгийг барин, цайны ургамлын тариалан, жижиг фермууд ээлжлэн тасралтгүй үргэлжилсэн ногоон толгодын дээгүүр өндөр аван нислээ. Африкийн хаана л бол хаана дүнгэнэлдэн нисч байдаг зорчигч тээврийн онгоц

бараг дандаа л пиг дүүрэн хүнтэй явдаг болохлоор энэ нислэг ч дүүрэн зорчигчтой байсан нь магад. Онгоц улам дээшлэн, ойн бүс болоод дугуй хэлбэрийн оромж, нимгэн дээвэртэй байшиングууд бөөгнөрсөн суурингуудын дээгүүр өнгөртөл, газар гэнэтхэн холдоод, тэртээ дор хөндийд үлдэж, ногоорон харагдаж байсан өнгө нь хүрэн болж хувирлаа.

Онгоц Зүүн Рифт хөндийг гатлан нисч явах үед, хүн хэмээх нэгэн зүйлийн амьтны анх үүссэн өлгий нутгийг зорчигчид цонхоор сонирхон харж явав. Тэртээ дор, өргөст бутан хашаагаар хүрээлгэсэн оромжууд нь цэг мэт, мал сүргийн зам нь цацраг мэт үзэгдэнэ. Сэns нь дүнгэнэсээр, Рифт хөндийн салхинд туугдсан, үүлэн зурваст орсон онгоц донслон дайвалзахад Шарль Монегийн дотор муухай оргиж эхлэв.

Онгошны нарийхан суудлууд хоорондоо маш ойрхон давчуу учраас кабинд юу л болно хүн бүхэнд заавал ажиглагддаг юм. Кабины хаалгыг бив битүү хааж, зөвхөн доторх агаараар нь сэлгүүлэн салхижуулсан болохлоор, агаарт ямар нэг үнэр тархвал хүн болгонд мэдрэгдэж, хэн нэгэн зорчигч өвдөвөл хүн бүхэн анзаарч таарна. Шарль Моне суудал дээрээ бөгтийгөөд, бие нь нэг л тавгүй байгаа нь илэрхий ч, чухам ясныг нь хэлэх боломж хэнд ч байсангүй.

Шарль Моне бөөлжисний хүүдий амандаа бариад, хүчтэй ханиалган, ямар нэг зүйлээр байн байн гулгихад, хүүдий нь цүлхийгээд ирэв. Түүнийг эргэн харах хооронд нь ажиглавал, кофены шаар зажилж байсан юм шиг жижигхэн жижигхэн хар мөхлөг холилдсон, тослог улаан зүйлээр уруул нь будагдсан харагдлаа. Нүд нь час улайж, цус хурсан нүүр нь огт хөдөлгөөнгүй болон гөлийжээ. Хэдэн хоногийн өмнө үүссэн од хэлбэрийн улаан толбууд нь томорсоор томорсоор хоорондоо нийлээд аянаа хүрэн улаан өнгөөр сүүдэртсэнээс, нүүр царай нь тэр аяараа харлан хөхөрсөн байлаа. Шарль Монегийн нүүрний холбох эд уусан алга болсноос нүүрнийх нь арьс, яснаасаа ховхрон салаад дөнгөж л дүүжлэгдэж байгаа мэт харагдана. Тэр амаа ангалзуулан бөөлжисний хүүдий шүүрэн авч, зогсоо зайгүй бөөлжсөөр л явлаа. Бөөлжиж бөөлжиж хodoод нь хоосорсны дараа түр амсхийгээд дахин шингэн хуралдаад ирмэгц, дахиад л бөөлжиж эхэнлэ. Vomito negro буюу "хар бөөлжис" гэж нэрлэдэг зүйлээр хүүдий нь дүүрч байв. Хэдийгээр "хар бөөлжис" гэдэг ч, энэ нь үнэндээ тас хар биш, хар улаан хоёр өнгө холилдсон буюу чанасан махны нитэг шиг хар бижирмэг, тараагуур судасны, хүчилтөрөгчөөр ханасан ув улаан цустай холилдсон байдаг юм. Энэ бол, өвчтөн дотуур цус алдаж байгаагийн шинж бөгөөд энэ үед яг л мал нядалгааны газрынх шиг үнэр ханхална. Харин энэ хар бөөлжис вирус агуулсан байлаа. Түйлийн халдвартай төдийгүй, үхлийн аюултай энэ шингэнээс биологийн

аюул судлаач, цэргийн мэргэжилтэн ч сүнсээ зайлтал айдаг юм. Хар бөөлжисний үнэр онгоцоор дүүрэн ханхаллаа. Шарль Моне "хар бөөлжис"-өөр дүүрсэн хүүдийнийхээ амыг хамхин, ирмэгийг нь нугалав. Хүүдий цүлхийн зөвлөрөөд, доторх бөөлжис нь шүүрч асгарах гээд байсан тул Шарль Моне түүнийг онгошны үйлчлэгчид өглөө.

Гоч аюултай вирус халдвартасан эзнийхээ тархинаас эхлээд, арьсыг нь хүртэл бүх эрхтнийг пиг дүүртэл үрждэг юм. Үүнийг "вирусийн хэт олшрол" гэж цэргийн мэргэжилтнүүд нэрлэдэг билээ.

* * *

Энэ өвчин, ердийн нэг ханиад туссантай огтхон ч адилгүй, тун аюултай. Вирусийн хэт олшрол дээд цэгтээ хүрсэн үед, нүдний дусаагуурын ганцхан дусал төдийхөн, өчүүхэн цусан дотор зуун мянган вирус агуулагддаг юм. Вирус ингэж хэт олшрох явцад, хүний биейн зарим эд эс вирус болон хувирч байдаг бөгөөд халдвартасан эзнээ эрхшээлдээ оруулж авсан вирус эд эс бүхнийг нь өөрийхөө бүтцийн бүрэлдэхүүн хэсэг болгон хувиргахыг чармайсаар л байна. Хэдийгээр, вирус хүний бүх эд эсийг бүгдийг нь ингэж хувиргаж чадахгүй ч гэсэн, эцсийн эцэст, ихээхэн эд эс гэмтэн уусч, вирустай холилдсон байдаг нь биологийн хувьд, сүйрэл мөн. Шарль Монегийн биед вирус хэт олширсны илрэл нь дээрх хар бөөлжис байлаа.

Шарль Монег хажуугаас нь харвал, хөдлөх л юм бол дотор нь нэг зүйл хагарчих гээд байгаа аятай, огт хөдөлгөөнгүй сууж байв. Чухамдаа, энэ үед түүний цус нөхжөн бүлэгнэж, үүссэн бүлэнгүүд цусны урсгалаар зөөгдөн, энд тэндгүй тархан, очсон газар бүхнийхээ судсыг таглаж байжээ. Элэг, бөөр, уушиг, гар хөл, толгойных нь судас цөм бүлэнгээр тагларснаас хагарч, бүх биед нь цус харвалт үүслээ. Нарийн, бүдүүн гэдэсний булчингуудын судас мөн л бүлэнгээр тагларснаас, цусан хангамж нь тасарч, булчин нь үхжиж, гэдэс нь сув сул болов. Тархинных нь судас бүлэнгээр битүүрч, цусных нь урсгал хаагдан, уураг тархи нь гэмтсэнээс Шарль Моне өвдөлтийг мэдрэхээ хэдийнэ больжээ. Уураг тархи нь гэмтсэнээс хойш, түүний бодьгал чанар арчигдах мэт алга болсоор байлаа. Ийм байдлыг "хүний өвөрмөц чанараа алдах" гэж нэрлэдэг бөгөөд энэ үед хүний сэргэлэн чанар, зан төлвийн нарийн онцлогууд бүрмөсөн алга болдог юм. Чухам үүнээс л болж, Шарль Моне яг автоматаар ажилладаг робот шиг л боллоо. Түүний тархины маш чухал төвүүд гэмтсэнээс, хамгийн түрүүнд ухамсын дээд үйл ажиллагаа нь алга болж, зөвхөн уртавтар тархины үүний хэсэг (хулгана, гүрвэлийн тархи шиг хэсэг) нь амьд үлдээд, ажиллаж байв. Төсөөлөн хэлэхэд, Шарль Монегийн хувьд хэн бэ гэсэн асуултанд хариулагдах зүйл нь аль хэдийн үхээд, зөвхөн юу вэ гэсэн асуултанд хариулагдах зүйл нь л амьд байлаа.

Тэр, хүчтэй бөөлжсөнөөс болж, хамрын нь судас тасарсан бололтой цус гоожиж эхлэв. Тараагуур судасны тяярсан улаан цус хамрых нь хоёр нүхнээс зэрэг асгаран, шуд болоод эрүүн дээгүүр нь урслaa. Шарль Монегийн цус бүлэгнүүлэх факторууд хэдийнэ шавхагдаж дууссанаас, цус нь тогтохгүй гоожсоор байсан тул, онгоцны үйлчлэгч хэсэг цаасан алчуур авчирч, түүнд өгсөн боловч, цаасан алчуураар хамраа бөглөөд бөглөөд цус нь тогтсонгүй, нэвт шүүрсээр л байв.

Ер нь, хэн ч байлаа гэсэн, онгоцонд зэрэгцээд суусан хүн маань өвдөвөл, юу юуны туханд хүрэлгүй, хэт их санаа тавьж, тэр хүнээ улам зовоохгүй хичээн “Гайгүй биз... ...Зүгээр болох байх” хэмээн өөрийгөө тайвшруулах нь мэдээж билээ. Онгоцонд суухдаа бие нь эвгүйцэг хүн байдаг шүү дээ. Тэгээд л, онгоцонд суугаад бөөлжиж байгаа байх, зайлцуул гэж бодох юмуу, онгоцны доторх агаар хуурай, сийрэг байдаг болохлоор зарим хүний хамраас цус гоождог, тэгээд л гоожиж байгаа байх гэж бодно. Гэхдээ, нөгөө хүний бие улам муудаад ирвэл, ямар нэг тусlamж хэрэгтэй эсэхийг түүнээс аяархан асууж таарна. Шарль Моне шиг, ноштой хүнд өвчтэй хүн бол асуултанд хариулахгүй. Сайндаа л, амандaa нэг юм бувтнах боловч, юу хэлснийг нь хэн ч ойлгохгүй. Тийм өвчтөнийг аль болохоор тайван байлгахыг хүн бүхэн хичээнэ. Гэвч, хүний төлөө санаа зовсон үед, нислэг даанч удаан үргэлжилж байгаа юм шиг санагдана. Онгоцны үйлчлэгч өвчтэй хүнд туслах нь мэдээж. Гэтэл Шарль Моне шиг гоц аюултай вируст халдварт нэрвэгдсэн хүний зан төрх өөрчлөгдөн, ямар тусlamж хэрэгтэйгээ илэрхийлэх ч чадваргүй болдог юм. Ийм өвчтэй хүн их өөнтөгч болж, биенд нь хүрэх төдийд ч дургүйцэнэ. Юм ярих дургүй болж, асуусан зүйлд хариулахгүй. Хариуллаа ч, хамраараа гунших юмуу, ганц нэгхэн үе бувтнах бөгөөд хэлэх гэсэн үгээ олохгүй байгаа мэт сэтгэгдэл төрүүлнэ. Ийм өвчтэй хүмүүс нэрээ хэлж чадавч, өнөөдөр долоо хоногийн ямар гараг болсоныг, чухам юунаас болж бие нь өвдсөнийг тайлбарлаж ерөөсөө чадахгүй.

Онгоц үүлэн дундуур нүргэлсээр, Рифт хөндийг тушид нь туулан ниссээр л байв. Энэ үед Шарль Моне суудлаа налан сулбайгаад, зүүрмэглэж байгаа мэт харагдана. Зарим зорчигч, түүнийг үхчихэв үү, явав гэж гайхаж байгаа бололтой. Үгүй ээ, тэр үхээгүй... ...бүр хөдөлж байна гээч. Бас, ув улаан нүдээ нээгээд, эргэн тойрноо харах аядаж байна.

Үдээс нэлээд хойно, нар Рифт хөндийн баруун толгод руу тонгойн, нүд гялбам хурц гэрлээ дөрвөн зүг, найман зовхиист цацруулах нь ертөнцийн наран яг экватор дээр хага үсэрсэн мэт ажээ. Онгоц зөөлөн эргээд, Рифт хөндийн зүүн талын хавсал дээгүүр өнгөрөв. Газрын байдал өндөрсөөд, бараан өнгө нь ногоон болоод ирлээ. Нгонгийн толгод, онгоцны баруун далавчны тушаа харагдан, онгоц доошилсоор

судалт тахь, анааш торойн харагдах хэсэг модтой газрын дээгүүр өнгөрөв. Минутын дараахан онгоц Жомо Кенниата хэмээх Олон улсын буудалд газардлаа. Шарль Моне аяархан аяархан хөдөлж, ганцаараа явах тэнхээтэй байсан тул цусаа гоожуулан дайвсаар онгоцны шатаар буув.

Цамц нь ув улаан цусанд будагдан заваарсан Шарль Монегийн гарти ямар ч ачаа байсангүй. Түүний цорын ганц ачаа нь гэвэл, биед нь үржсэн аюулт вирус л байв. Нэг үгээр хэлэхэд, Шарль Моне дүүрэн вирустэй “хүн–бөмбөг” болон хувирчээ. Тэр, шуудхан онгоцны буудлын байшин дундуур гарч, аажимхан алхалсаар байнга такси зогсож байдаг тахир замруу гарч ирлээ. Таксины жолооч нар түүнийг бүчин авч: “Такси авах уу?”, “Такси?” гэцгээв.

“Найроби... ...эмнэлэг...” гэж Шарль Моне арай ядан бувтнаалаа.

Нэг жолооч түүна туслан таксиндаа суулгав. Ер нь, Найробийн таксины жолооч нар тээж яваа зорчигчтойгоо дэмий ярьж явах дуртай болохлоор, тэр жолооч ч Монегоос өвдсөн эсэхийг асуусан нь мэдээж бөгөөд хариулт нь ч илэрхий байгаа бизээ. Тэр үед, Шарль Монегийн хodoод арай гайгүй болж, хоосон оргих юмуу, урагдаж байгаа юм шиг өвдөх, эсвэл халуу оргих зэргээ болиод, харин цадталаа хоол идсэн мэт цанхайж байв.

Такси Ухуругийн гол замд орж, Найроби хотыг чиглэн, хуайс модоор хүрээлсэн билчээрийн талбайг түүлж, үйлдвэрүүдийн хажуугаар өнгөрөөд, эцэст нь нэг эргэлтэн дээр иртэл, Найроби хотын түм түжигнэж, бүм бужигнасан гудамжны амьдралд орж ирлээ. Замын хоёр талаар цуврах бөөн бөөн хүмүүс, шавар шавхайтай зөргөөр алхлах эмэгтэйчүүд, залхуурч нозоорсон эрчүүд, дугуй унаж давхисан хүүхдүүд, замын хажууд гутал засч суугаа хүн, модны нүүрс ачсан чиргүүлтэй трактор ээлжлэн тааралдаж байв. Тэгснээ, такси зүүн тийш эргэн, Нгонгийн замд орж, хотын цэцэрлэгийг өнгөрөөд, нэгэн толгойг өгсөж, эгнэн ургасан өндөр өндөр эвкалипт модны хажуугаар гаран, дахиад нэг нарийхан зам руу эргээд, дэргэд нь харуул зогссон хаалгаар орсноор, Найробийн эмнэлгийн нутаг дэвсгэрт нэвтэрч, цааш явсаар, цэцгийн мухлагийн хажууд зогсов. Нэг шилэн хаалган дээр “Гэмтлийн тасаг” гэсэн хаяг харагдлаа. Шарль Моне жолоочид мөнгө атгуулаад, таксинаас буун, мөнөөх шилэн хаалгаар орж, хүлээн авахын цонхон дээр очоод, маш хүнд өвчилснөө арай чамай илэрхийлж хэлэв.

Шарль Моне цус алдаж байсан учраас хүлээн авахын сувилагч: “Таныг эмч одоохон үзнэ. Гэхдээ эмчийг дуудаж ирүүлэх тул, та иртэл нь хүлээн хэрэгтэй. Эмч ирэнгүүтээ л үзнэ, санаа зовох хэрэггүй” гэж тайвшруулсанда, тэр хүлээлгийн өрөөнд очиж суулаа.

Хүлээлгийн өрөө нь зөөлөвчтэй урт сандал

цууулан тавьсан жижигхэн тасалгаа байв. Цонхоор нь Зүүн Африкийн хурц тод нарны гэрэл нэвт тусан, халтар хултар сэтгүүлүүд овоолоостой ширээндээрээс ойн голдоо усны нүхтэй саарал чулуун шалруу тэгш өнцөг гарган цацаарчээ. Өрөөгөөр дүүрэн, модны утаа, хөлсний үнэр холилдон ханхалж, сүүмгэр нүдтэй хүмүүс чихцэлдэн, африкийн болоод европыхон эгнэн суушгааж байлаа. Гэмтлийн тасагт голдуу шархандаа оёдол тавиулах хүмүүс ирсний, зарим нь алчуураар толгойгоо даран, зарим нь цус нэвтэрсэн боолттой хуруугаа атган, тэвчээртэй хүлээн сууж байв. Урт сандал дээр суугаа Шарль Монегийн хувьд, хөхөрч хавдсан гөлгөр царай, ув улайсан нүд хоёрыг нь эс тооцвол, тэнд суугаа хүмүүсээс нэг их ялгарахгүй байлаа.

Хүлээлгийн өрөөний ханан дээрх нэг санамжида халаасны хулгайчаас болгоомжлохыг анхааруулсан бол, өөр нэг санамжид: “ГЭМТЛИЙН ТАСАГ НЬ, ЯАРАЛТАЙТУСЛАМЖШААРДЛАГАТАЙХҮМҮҮСИЙГ ТҮРҮҮЛЖ ҮЗНЭ. ИЙМЭЭС, ӨӨРИЙГ ТАНЬ ДУУДАХ ХҮРТЭЛ ХҮЛЭЭХ ХЭРЭГТЭЙ. ЧИМЭЭ ШУУГИАН БҮҮ ГАРГАГТУН! БИДНИЙГ ОЙЛГОЖ, ТУСАЛСАНД ТАНЬ БАЯРЛАЛАА!” гэжээ.

Шарль Моне чимээ шуугиан гаргалгүй, өөрийг нь дуудахыг хүлээсээр л суув. Гэтэл бие нь гэнэтхэн түйлдаа хүртэл муудлаа. Дүүрэн вирүстэй “хүнбөмбөг” тэсэрлээ. Яг ийм үеийг биологийн аюул судлагч цэргийн мэргэжилтнүүд тун өвөрмөцөөр тодорхойлж, аюулд өртсөн хүн “цус алдаж шоконд

орлоо” гэх юм уу, арай зөөлрүүлээд аюулд өртсөн хүн “өнгөрлөө” гэдэг юм.

Шарль Монегийн толгой нь эргэн, бие нь бүр суураад, нуруугаар нь эвгүй оргиж байснаа мэдээгүй болж, тэнцвэрээ бүр алдаж, өрөө тасалгаа нүднийх нь өмнө эргэлдээд явчихлаа. Тэр шоконд орж эхэлжээ. Шарль Моне толгойгоо өвдгөндөө хүртэл тонгойгоод, хodoодондоо хуримтлагдсан асар их цусыг шалан дээр асгаруулан бөөлжиж, аахилан зовиурласаар байлаа. Тэгснээ тэр ухаан алдан, шал руу харуулдан унав. Ухаангүй, өөрийн мэдэлгүй бөөлжин хэвтэж байгаа өвчтөнөөс хахаж цацах чимээ л сонстож байлаа.

Гэнэтхэн, орны даавуу цуу татан урах мэт дуу гарсан нь, өвчтөний шулуун гэдэсний хуниасууд огцом нээгдэж, бүдүүн гэдсэнд нь хуралдсан асар их цус хошногоор нь эрчлэн цацагдсан хэрэг ажээ. Тэр цусан дотор, гэдэсний дотор ханын хучаас эдхолилдон гарсан байв. Энэ бол гэдэсний дотор хана хуурч байгаагийн гэрч. Өвчтөн шулуун гэдэснээсээ маш их хэмжээний цус алдаж, гэдэсний дотор хананаас хуурч салсан хучаас эд улам ихээр холилдон гарсаар байлаа. Эдгээр шинж тэмдэг бол, Шарль Моне “шоконд орж, цус алдаж” байгааг харуулж байв.

Хүлээлгийн өрөөнд байсан өвчтөнүүд босцгоон, шалан дээр ухаангүй хэвтэж байгаа Шарль Монегоос холдож, эмч дуудахаар явцгаалаа. Өвчтөний эргэн тойронд тунарсан цус маш түргэн нэмэгдсээр л байв. Аюулт вирүс, дотор нь үргиж олширсон эзнээ сүйрүүлээд, нүх сүв болгоноор нь гадагшилж, дахиад л шинэ эзэн олж халдах гэж эрмэлзэж байгаа нь энэ билээ.

(Үргэлжлэл бий)
Англи хэлнээс орчуулсан Э.Пүрэвдаваа



English abstracts of the original research articles

Influenza morbidity and surveillance results in Mongolia in 2010/2011 season

B. Darmaa¹, A. Burmaa¹, Ts.Naranzul¹, N.Bayasgalan¹, D.Enkhsaikhan¹, Ch.Maitsesteg¹, G.Nyama¹, B.Tserendulam¹, L.Enkhbaatar¹, B.Gantsoo¹, Ch.Urtasan¹, P.Nymadawa^{1,2},

¹National Center of Communicable Diseases, Ministry of Health, Mongolia

²Mongolian Academy of Medical Sciences

During 2010/2011 influenza season there has been registered in average 1232.0 ILI per 10,000 which is 5.8 % of all the registered outpatient visits it is 3.0% lower in comparison to the 2009/2010 season.

The proportion of hospitalization and deaths due to pneumonia were less than in the 2009/2010 season.

We were tested 3, 972 naso-pharyngeal samples from ILI patients by rt-RT-PCR for detection of influenza viruses and it has been detected 460(11.5%) positive samples, among them 349(75.9%) A(H3N2), 103(22.4%) A(H1N1)pdm and 8(1.7%) influenza B strains.

The A(H3N2) and B viruses were detected from October to December 2010, the A(H3N2)(61%); A(H1N1)pdm (38.2%) and B(0.8%) viruses co-circulated in January 2011 or peak point of ILI morbidity. While late of February – March predominated A(H1N1) pdm virus and small numbers of influenza type B viruses were detected.

All 8 genes were sequenced of A/Улаанбаатар/190/2011(H1N1)pdm and deposited in GeneBank(accession numbers are: CY080571, CY080572, CY081057, CY080420, CY080573, CY080574, CY080592, CY080593). There found amino-acid changes on S188T; X208Q positions of HA gene compared with original pandemic strain A/California/072009(H1N1). The HA sequence of A/Улаанбаатар/190/2011(H1N1)pdm is closely related to the sequence from Iran, A/Karaj/5327/2010, which is new sub-clade of pandemic stains starting circulated countries USA and Europe since October, 2010.

All viruses tested for NAI susceptibility were sensitive to oseltamivir.

Mongolian Journal of Infectious Disease Research Disease Research, 2011, № 3(40):2-6; 4 Tables, 1 Figure and 11 References;



“Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн редакцийн зөвлөл

- Ерөнхий эрхлэгч:** **П.Нямдаваа**, ХӨТМҮХ-ны тэргүүн, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
академич, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, 99112306, pumadawa@gmail.com
- Дэд эрхлэгчид:** **М.Алтанхүү**, Монголын вирус судлалын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, анагаах ухааны доктор, 99092337, amurd@magicnet.com
- Г.Батбаатар**, Монголын дархлаа, нян судлалын нийгэмлэгийн тэргүүн, анагаах ухааны доктор, дэд профессор, 99081827 gobi_bat@yahoo.com
- Г.Зулхүү**, Монголын халдвартын эмч нарын нийгэмлэгийн тэргүүн, анагаах ухааны доктор, дэд профессор, 99196772, zulkhuuu@yahoo.com
- Д.Нямхүү**, ХӨСҮТ-ийн ерөнхий захирал, Анагаах ухааны доктор, профессор, 99100155
- Д.Отгонбаатар**, БГХӨСҮТ-ын ерөнхий захирал, анагаах ухааны доктор, клиникийн профессор, 99113549, 632859
- Л.Энхбаатар**, ХӨТМҮХ-ны гүйцэтгэх захирал, анагаах ухааны доктор, 99780134, cmb1691@yahoo.com

Эрхэлсэн нарийн бичгийн дарга:

Хүндэт гишүүд:

- Д.Дандийн**,
Биологийн ухааны доктор, төрийн шагналт, 99881009
- Ч.Долгор**,
ЭМШҮИС-ийн зөвлөх багш, анагаах ухааны доктор, профессор, ардын эмч, 99725670
- Н.Донлог**,
“Эрүүл мэнд- дархлаажуулалт” төрийн бус байгуулагын гүйцэтгэх захирал, клиникийн профессор, 99948695
- Г.Жамбаа**,
ЭМШҮИС-ийн захирлын зөвлөх, анагаах ухааны доктор, профессор, гавьяат багш, 458010

Гишүүд:

- Д.Абмэд**,
ХӨСҮТ-ийн паразитологийн тасгийн эрхлэгч, биологийн ухааны доктор, 99778211, 454188 abmed99@yahoo.com
- З.Адяасурэн**,
БГХӨСҮТ-ын зөвлөх, анагаах ухааны доктор, клиникийн профессор, 99166676, adiyas_z@yahoo.com
- Д.Анхлан**,
ХБНГУ-ын Мюнстерийн Их сургуулийн Үрэвслийн молекул биологийн төвийн Молекул вирусологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, анагаах ухааны доктор, (45)-251-83-52214, anhlan@uni-munster.te
- Б.Арьяа**,
АНУ-ын Үндэсний эрүүл мэндийн хүрээлэнгийн Настан судлалын институтийн Дархлаа судлалын лабораторийн тэргүүлэх судлаач, биологийн ухааны доктор, biragina@mail.nih.gov

- О.Баатархүү,**
ЭМШҮИС-ийн халдвартын тэнхимийн багш, анагаах ухааны доктор, 99188386, baatarkhuu6@yahoo.com
- Ж.Баттаа,**
ХӨСҮТ-ийн Зоонозын халдвартын тасгийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 96012505
- Д.Даваалхам**,
ЭМШҮИС-ийн Эпидемиологи-биостатистикийн тэнхимийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 91990560, dawaalkham@hsu.edu.mn
- Я.Дагваалдорж**,
ЭМШҮИС-ийн халдвартын тэнхимийн эрхлэгч, анагаах ухааны доктор, дэд профессор, 91180537, dahg wah@yahoo.com
- Б.Дармаа**,
ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 99754821
- Т.Дэлгэр**,
ХӨСҮТ-ийн зөвлөх эмч, клиникийн профессор, хүний гавьяат эмч, 99170153
- Ч.Мөнхшэшэг**,
ЭМЯ-ны халдварт өвчин, тархвар судлалын мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор, 99136244, munkh828@yahoo.com
- Н.Наранбат**,
Анагаах ухааны доктор, “Гялс” анагаах ухааны төвийн гүйцэтгэх захирал, 99099471, naranbat@givals.mn
- Ж.Оюунбилэг**,
НЭМХ-ийн захирал, биологийн шинжлэх ухааны доктор, профессор, 99762000, jobileg@magicnet.mn
- Р.Оюунгэрэл**,
ХӨСҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор, ravjirouyun@yahoo.com

Р.Туул,
ХӨСҮТ-ийн Улаан бурхны лавлагаа лабораторийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 99093674, r_tuul@yahoo.com

Н.Хоролсүрэн,
ЭМШҮИС-ийн халдвартын тэнхимийн багш, анагаах ухааны доктор, 99189309, khorolnran@yahoo.com

Ж.Хулан,
МУИС-ын Биотехнологийн сургуулийн багш, биологийн ухааны доктор,

Н.Хүрэлбаатар,
ЭМЯ-ний төрийн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор, профессор, 99196665, khurel@nccd.goy.mn

Б.Цацаалт-од,
ХӨСҮТ-ийн эрдэм шинжилгээ хариуцсан дэд захирал, анагаах ухааны доктор, 88031009

С.Цогтсайхан,
ЭМШҮИС-ийн Бичил амь-дархлаа судлалын тэнхимийн эрхлэгч, анагаах ухааны доктор дэд профессор, tsog-San@yahoo.com

Н.Цэнд,
ХӨСҮТ-ийн зөвлөх, анагаах ухааны доктор, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан 88858929

Д.Цэрэнноров,
БГХӨСҮТ-ын дэд захирал, биологийн ухааны доктор, 99883159, 99069998 dnorov_99@yahoo.com

Ч.Эрдэнэчимэг,
ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-тай тэмцэх албаны тасгийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 99263767, ch_erdenechmg@yahoo.com

Редакцийн хаяг:

Улаанбаатар, Төв шүүдан ш/х 119,

“Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн редакцийн зөвлөл

Эрхэлсэн нарийн бичгийн дарга Л.Энхбаатар, ХӨСҮТ, Захиргааны байр, Амьсгалын замын вирус судлалын лаборатори

E-mail: cmb1691@yahoo.com; Утас:455847

Хэвлэлийн дизайнер: С.Эрдэнэпүрэв

Цаасны хэмжээ: А4

Хэвлэсэн тоо: 300 ш

“СПИЙД ВЕЙ” ХХК-д хэвлэв.